ДБТБАС ТДБЦ – Монгол улс: Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын Байгаль орчин, нийгмийн үнэлгээ (БОНҮ)

Нэмэлт баримт бичиг: Талуудын оролцоог хангах төлөвлөгөө

2019 оны 7-р сар

Мэдэгдэл

Энэхүү баримт бичиг, түүний агуулга нь гагцхүү Талуудын оролцоог хангах төлөвлөгөөнд хамаатайгаар ашиглахад зориулсан мэдээлэл хэлбэрээр боловсруулагдсан болно.

ЭсЭнСи-Лавалин (SNC-Lavalin) компани нь уг баримт бичиг болон түүний агуулгын талаар буюу түүний улмаас үүсэх, эсвэл түүнтэй холбоотой асуудлаар аливаа этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү баримт бичиг нь хавтастайгаа нийлээд 72 хуудаснаас бүрдэнэ.

Баримт бичгийн түүх

Засвар өөрчлөлт	Зорилгын тодорхойлолт	Бэлтгэсэн	Шалгасан	Хянасан	Баталсан	Огноо
Засвар 1.0	Төсөл	ГЦ, CG	ITI	KP	KP	05/07/19
Засвар 2.0	Эцсийн хувилбар	ГЦ, CG	ITI	KP	GL	09/07/19

Агуулга

Бүлэг		Хуудас
Товчилсон үг хэллэгийн тайлбар		**5**
1.	**Удиртгал**	**7**
1.1.	Оршил	7
1.2.	ТОХТ-ний зорилтууд	7
1.3.	ТОХТ-ний хамрах хүрээ	7
1.4.	ТОХТ-ний агуулга	8
1.5.	Мэдээллийг нийтэд ил тод болгох ерөнхий арга барил	8
2.	**Төслийн тодорхойлолт**	**9**
2.1.	Танилцуулга	9
2.2.	Төслийн хам сэдэв	9
2.3.	Төсөл	10
2.4.	Санал болгож буй ажил	12
3.	**Талуудын оролцоог хангах болон мэдээллийг нийтэд ил болгох тухай шаардлагууд 15**	
3.1.	Танилцуулга	15
3.2.	Үндэсний шаардлага	15
3.3.	ЕСБХБ-ны шаардлага	17
3.4.	Үндэсний болон ЕСБХБ-ны шаардлага хоорондын ялгаа	19
4.	**Талуудын оролцоог хангах чиглэлд өмнө хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тойм 20**	
4.1.	Танилцуулга	20
4.2.	Тодорхойлогдсон асуудлуудын тойм	25
4.3.	Цаашид санал болгож буй үйл ажиллагаанууд	26
5.	**Оролцогч талуудыг тодорхойлох нь**	**27**
5.1.	Танилцуулга	27
5.2.	Оролцогч талуудыг тодорхойлох арга барил	27
5.3.	Оролцогч талуудыг тодорхойлох ба шинжлэн дүгнэх	27
5.4.	Эмзэг бүлгүүд	28
6.	**Нэмэлт оролцоог хангах нь**	**33**
6.1.	Танилцуулга	33
6.2.	Фокус бүлгийн ярилцлага	33
6.3.	Гол мэдээлэгчийн ярилцлага	33
6.4.	Үр дүнгийн хураангуй	34
7.	**Талуудын оролцоог хангах хөтөлбөр**	**37**
7.1.	Танилцуулга	37
7.2.	Оролцооны зорилго, зорилтууд	37
7.3.	Харилцааны аргууд	38
7.4.	Талуудын оролцоог хангах хөтөлбөр	39
8.	**Өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизм**	**48**
8.1.	Танилцуулга	48
8.2.	Гомдол барагдуулах механизм	48
8.3.	ГБМ-ын журам ба хугацаа	49
9.	**Хяналт үнэлгээ ба тайлагналт**	**52**
9.1.	Танилцуулга	52

9.2. Гүйцэтгэлийн голлох шалгуур үзүүлэлтүүд болон хяналт үнэлгээний арга хэмжээнүүд 52
9.3. Тайлагналт 54
10. Эх үүсвэр болон үүрэг хариуцлага 56
10.1. Барилгын өмнөх ба барилгын үе шат 56
10.2. Ашиглалт ба засвар арчлалтын үе шат 56

Хавсралт 57

Хавсралт А. Ярилцлагын асуултууд 58
Хавсралт Б. Төслийн өргөдөл гомдол гаргах маягт 68
Хавсралт В. Уулзалтын тэмдэглэл хөтлөх загвар 69
Хавсралт Г. Өргөдөл гомдлын мэдээллийн сангийн бүртгэлийн загвар 70

Хүснэгт

Хүснэгт 2-1. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд 10
Хүснэгт 4-1. БОННҮ-ний бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулагдсан уулзалтууд 23
Хүснэгт 5-1. Тодорхойлогдсон оролцогч талууд, үр нөлөө, ашиг сонирхол ба нөлөөлөл 29
Хүснэгт 6-1. Оролцогч талууд болон оролцоог хангах аргачлалын хураангуй 33
Хүснэгт 6-2. Оролцогч талуудтай холбоотой тодорхойлогдсон асуудлуудын тойм 34
Хүснэгт 7-1. Талуудын оролцоог хангах цаашдын хөтөлбөр 41
Хүснэгт 9-1. Гүйцэтгэлийн голлох шалгуур үзүүлэлтүүд 52
Хүснэгт 9-2. Хяналт үнэлгээний арга хэмжээ 53

Зураг

Зураг 2-1. Монгол улсын авто замын сүлжээ 9
Зураг 2-2. Монгол улс дахь Азийн хурдны авто замын сүлжээний АН-3 чиглэл (улаанаар тэмдэглэсэн нь Улаанбаатар-Дархан чиглэлийн зам) 10
Зураг 2-3. Төслийн байршил 11
Зураг 2-4. Замын тэнхлэгийн жишээ (улаанаар тэмдэглэсэн нь ЕСБХБ-ны санхүүжүүлэх зам) 12
Зураг 2-5. Одоо байгаа зам дагуух карьер 14
Зураг 8-1. ГБМ-ын журам ба хугацаа 51

Товчилсон үг хэллэгийн тайлбар

Товчилсон үг / Товчлол	Тайлбар
АХБ	Азийн Хөгжлийн Банк
АХЗ	Азийн хурдны авто зам
ОНХОХҮА	Олон нийтэд хүрч очих, хяналт үнэлгээний ажилтнууд
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
БОНБҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОННҮ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОНҮ	Байгаль орчин, нийгмийн үнэлгээ
БОНҮАТ	Байгаль орчин,, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө
БОНЭМАБ	Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд ба аюулгүй байдал
БОННҮ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНУХШТ	Байгаль орчин ба нийгмийн удирдлага, хяналт шинжилгээний төлөвлөгөө
БОНЕҮ	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ
ОУСТ	Олон улсын сайн туршлага
ГБМ	Гомдол барагдуулах механизм
ГЧНШХХ	Газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлтийн хамрах хүрээ
ГЧНШТ	Газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
МСРСgr ХХК	Монголын барилга байгууламжийн төслийн зөвлөхүүдийн групп ХХК
МҮС	Монголын үндэсний стандарт
ЗТХЯ	Зам, Тээврийн Хөгжлийн Яам
АЗА	Ашиглалт ба засвар арчлалт
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ГШ	Гүйцэтгэлийн шаардлага
ТОХТ	Талуудын оролцоог хангах төлөвлөгөө
Сум	*Монгол үг:* Нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгж
НҮБЕЭЗК	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Европын эдийн засгийн комисс

1. Удиртгал

1.1. Оршил

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ) нь Монгол улсын Засгийн газарт Зам, Тээврийн Хөгжлийн Яамаар дамжуулан Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам [Азийн хурдны авто зам 3 буюу "АХЗ-3" чиглэл]-ыг өргөтгөхөд зориулан зээлийн санхүүжилт олгох асуудлыг авч үзэж байна. Одоо ашиглагдаж буй авто зам нь нийслэл Улаанбаатар хотоос тус улсын хоёр дах том хот болох Дархан хүртэл үргэлжлэх 202.42км урттай, 2 эгнээ бүхий 4-р зэргийн сайжруулсан хучилттай зам юм.

Зам өргөтгөх төсөл нь авто замыг шинэчлэн засварлах ажлын 2-р үе шат болох бөгөөд дээрх чиглэлийн замыг 1-р зэрэглэлийн, 2 урсгалтай, 4 эгнээ бүхий цемент бетонон хучилттай авто зам болгон өргөтгөх (Төслийн 1-р үе шат буюу Төсөл гэнэ) ажлыг хамарна. Төслийн 1-р үе шатанд хийгдэх ажлыг Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны зээлээр санхүүжүүлэх ба үүнд одоогийн (2 эгнээтэй) замыг шинэчлэн засварлах ажил (Төслийн 1-р үе шат буюу АХБ-ны төслийн ажил гэнэ) багтана.

ЕСБХБ нь Төслийн 2-р үе шатыг А Зэрэглэлийн Төсөл гэж тодорхойлсон бөгөөд энэ нь Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)-г бэлтгэх ажлыг багтаасан Төслийн Байгаль орчин, нийгмийн үнэлгээ (БОНҮ)-г цогц хэлбэрээр хийсэн байх ёстой гэсэн үг. Энэхүү баримт бичиг нь ЕСБХБ-ны Байгаль орчин, Нийгмийн Бодлого (БОНБ) 2014[1]-т тусгасан ёсоор, ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага (ГШ) 10 буюу *Мэдээллийг нийтэд ил болгох, Талуудын оролцоог хангах* шаардлагын дагуу ТОХТ-г танилцуулж байна.

ЗТХЯ болон Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь замын барилгын ажил эхлэхээс өмнө ТОХТ-г илүү нарийвчилсан байдлаар боловсруулах ба Барилгын гэрээт гүйцэтгэгч нар уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх, мөн өөрсдийн хариуцсан ажлын чиглэлд гүйцэтгэх нарийвчилсан барилгын ТОХТ/Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ТХН-ээр батлуулах үүрэг хүлээнэ. Ашиглалтын үйл явцад ТОХТ-ний хэрэгжилтийг хангах ажлыг ЗТХЯ хариуцна.

1.2. ТОХТ-ний зорилтууд

ТОХТ нь дараах зорилтуудтай. Үүнд:

- Талуудын оролцоог үр дүнтэй байлгах тухайд зохих стандартуудыг дүрслэх;
- Талууд болон тэдгээрийн ашиг сонирхол буюу эсвэл анхаарал хандуулж буй асуудлуудыг тодорхойлох;
- Өнөөдрийг хүртэл талуудын оролцоо ямар түвшинд байсан, ЕСБХБ-ны ГШ10-ыг хангахын тулд оролцоог хэрхэн нэмэгдүүлснийг тогтоох;
- Талуудтай үр дүнтэй харилцаа холбоо тогтоох, хэвээр хадгалахад тус дөхөм болох цаашидалуудын оролцоог хангах системтэй арга барилыг бататгах;
- Байгаль орчны ба нийгмийн талаар зохих мэдээллийг нийтэд ил болгож, Төслийн талуудтай утга учиртай зөвшилцөл өрнүүлж, шаардлагатай үед зөвшилцөөнөөс гарсан санал хүсэлтийг харгалзан үздэг байх нөхцлийг хангах;
- Талуудын оролцоог хангах үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, Төслийн хүрээнд оролцоог хэрхэн яаж нэгтгэх талаар тайлбарлах;
- Хяналт үнэлгээ хийх, тайлагнах журмыг тодорхойлох; мөн
- Талуудын санааг зовоосон асуудлуудыг авч үзэж, тэдгээрт үр дүнтэй, цаг үеэ олсон хэлбэрээр хариу арга хэмжээ авах замаар өргөдөл гомдол барагдуулах механизмыг бий болгох.

1.3. ТОХТ-ний хамрах хүрээ

Дээрх зорилтуудын дагуу Төслийн дараагийн үе шатуудын туршид Талуудын оролцоог чиглүүлэх, баримтжуулах өргөн хүрээний нэг хэсэг болохын хувьд ТОХТ нь өнөөг хүртэл хэрэгжүүлсэн Талуудын

[1] ЕСБХБ нь 2019 онд Байгаль орчин, нийгмийн бодлогоо шинэчлэн танилцуулсан. Гэхдээ энэхүү бодлого нь 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх тул энэхүү Төсөлд 2014 оны бодлогыг тусган авч үзэв.

оролцоог хангах үйл ажиллагаанууд болон тэдгээрийн үр дүнг баримтжуулахыг зорино. ТОХТ нь орон нутгийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний шаардлагуудын хүрээнд татан оролцуулсан байдал, мөн ЕСБХБ-ны БОНБ 2014-ыг дагаж мөрдөх БОНҮ-ний хүрээнд татан оролцуулсан байдлыг хамрах бөгөөд Төслийн барилга угсралт ба ашиглалт үйлчилгээний үе шатуудад уг арга барилыг нэвтрүүлнэ.

1.4. ТОХТ-ний агуулга

ТОХТ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- 2 дугаар хэсэг- Төслийн тодорхойлолт: Төслийн байршил, онцлог шинж чанар, загвар шийдэл болон үе шатууд;
- 3 дугаар хэсэг- Талуудын оролцоог хангах болон мэдээллийг нийтэд ил болгох шаардлагууд: ЕСБХБ-ны болон үндэсний шаардлагууд;
- 4 дүгээр хэсэг- Өнөөг хүртэлх талуудын оролцоо: БОННҮ болон оролцоог дэмжих бусад үйл ажиллагаа, хөндөгдсөн асуудал, цаашид хэрэгжүүлэхээр санал болгох үйл ажиллагаа;
- 5 дугаар хэсэг- Оролцогч талуудыг тодорхойлох нь: Оролцогч талуудыг тодорхойлох арга барил;
- 6 дугаар хэсэг- Талуудын нэмэлт оролцоо: БОНҮ-ний хүрээнд хийсэн оролцоог хангах ажлын арга барил ба гарсан үр дүн;
- 7 дугаар хэсэг- Талуудын оролцоог хангах хөтөлбөр: цаашдын Талуудыг нийтэд ил болгох, Талуудын оролцоог хангах хөтөлбөр;
- 8 дугаар хэсэг- Өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизм: гомдол барагдуулах механизм (ГБМ), ГБМ-ын журам ба хугацаа;
- 9 дүгээр хэсэг- Хяналт үнэлгээ ба тайлагналт: ГГШҮ, хяналт үнэлгээний арга хэмжээнүүд болон тайлагналт; мөн
- 10 дугаар хэсэг- Хөрөнгийн эх үүсвэр болон үүрэг хариуцлага: ТОХТ-г боловсруулах, хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг хариуцлага.

1.5. Мэдээллийг нийтэд ил тод болгох ерөнхий арга барил

ЕСБХБ нь мэдээллийг нийтэд ил болгох, талуудын оролцоог хангах ажил нь тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд Төслийн бэлтгэл ажлын хүрээнд хамгийн эхний үе шатанд эхлүүлж, Төслийн хэрэгжилтийн явцад үргэлжлүүлэх ёстой гэж үздэг. Эцэст нь, энэхүү баримт бичиг бол барилга угсралт болон ашиглалтын ажиллагааг эхлүүлэхээс өмнө судлах, шинэчлэх ёстой “амьд” эх сурвалж бөгөөд талуудын оролцоог хангах хувьсан өөрчлөгдсөөр буй хэрэгцээ шаардлага, Төслийн хүрээнд хуримтлуулсан дадлага туршлага, үр дүн буюу эсвэл Төслийн үргэлжлэх хугацааны туршид бий болох Төслийн загвар шийдэл ба үйл ажиллагаанд гарах өөрчлөлтүүдийг тодорхой цаг хугацааны давтамжтайгаар тусган харуулах учиртай.

Энэхүү ТОХТ-г ДаблюүЭс Аткинс Интэрнейшнл Лимитед (Аткинс) болон Састэйнабилити Ийст Эйжия ХХК (СИЭ ХХК) нар БОНҮ-ний хүрээнд ЕСБХБ-ны дараах бодлогуудыг баримтлан боловсруулав:

- ЕСБХБ-ны БОНБ (2014), ялангуяа ГШ10; мөн
- ЕСБХБ-ны Олон нийтийн мэдээллийн бодлого (2014).

Энэ нь Монгол улсын үндэсний шаардлагад нийцүүлэх үүднээс БОННҮ-ний хүрээнд хэрэгжүүлсэн талуудын оролцоог хангах үйл ажиллагаанд үндэслэсэн болно. Уг баримт бичгийг А зэрэглэлийн төслүүдэд тавигдах шаардлагуудыг хангахад чиглэсэн БОНҮ-ний Нэмэлт баримт бичгийн багцын хүрээнд ЕСБХБ нийтэд ил болгоно.

2. Төслийн тодорхойлолт

2.1. Танилцуулга

Одоогийн 2 эгнээтэй замын их засварын ажилд зориулан 2017 онд Монголын барилга байгууламжийн төслийн зөвлөхүүдийн групп ХХК (MCPCgr)–ийн гүйцэтгэсэн техник эдийн засгийн үндэслэл судалгаа (ТЭЗҮ)-г Засгийн газрын зүгээс санхүүжүүлсэн. ТЭЗҮ нь техник, нийгэм эдийн засаг, байгаль орчны шинжилгээнд үндэслэн одоогийн 2 эгнээтэй замыг шинэчлэн засварлахын зэрэгцээ өргөтгөж 4 эгнээтэй зам болгох нь зүйтэй гэж дүгнэсэн. Төсөл нь дараах 2 үе шаттай. Үүнд:

- 1-р үе шат – одоогийн замыг шинэчлэн засварлах; мөн
- 2-р үе шат - 2 эгнээ зам нэмж барих зарчмаар авто замын хүчин чадлыг өргөтгөх.

Төслийн 1-р үе шатыг АХБ санхүүжүүлсэн ба 2 эгнээ замыг шинэчлэн засварлах, үүнд замын аюултай хэсгүүдийг тэгшлэн засах, авто замын ангиллын зохих стандартыг хангахын тулд одоо байгаа замын шаардлагатай хэсгийг 3 метр орчим хэмжээгээр өргөсгөх ажил багтана. Төслийн 1 ба 2-р үе шатны ажлыг гүйцэтгэх зорилготой Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийг ЗТХЯ-ны дэргэд байгуулсан.

Төслийн 2-р үе шатанд замыг 4 эгнээ бүхий хурдны зам болгон өргөтгөх ажил багтах ба үүнийг ЕСБХБ санхүүжүүлэхээр авч үзэж байна.

2.2. Төслийн хам сэдэв

Монгол улс нь Азийн хурдны авто замын сүлжээнд гурван чиглэлээр холбогдсон нь Зураг 2-1-т харуулсан АН-3 (Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд), АН-4 (Ярант-Ховд-Өлгий-Улаанбайшинт) болон АН-32 (Сүмбэр-Өндөрхаан-Улаанбаатар-Цэцэрлэг-Улиастай-Ховд-Өлгий-Улаанбайшинт) чиглэлүүд юм. Уг Төсөл АН-3 чиглэлийн хүрээнд багтах бөгөөд ОХУ, Монгол улс, БНХАУ-ыг холбосон, тус гурван улсын “Эдийн засгийн хонгил”-ын маш чухал хэсэг нь юм.

АН-3 чиглэл нь Зураг 2-2-т харуулсан ёсоор Монгол улсын нутаг дэвсгэрт 1,029.6 km үргэлжлэх зам бөгөөд Монгол улсын аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, мал аж ахуйн зэрэг эдийн засгийн голлох бүс нутгуудыг дайран өнгөрнө. АН-3 чиглэлийн авто замыг шинэчлэн сайжруулах нэг гол зорилго нь Алтанбулаг-Улаанбаатар-Замын үүд чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын транзит тээврийг нэвтрэн өнгөрүүлэх чадварыг сайжруулахад оршино.

Зураг 2-1. Монгол улсын авто замын сүлжээ

Эх сурвалж: MCPCgr ХХК, Инженерийн нарийвчилсан зураг төсөл – 1 дүгээр хэсэг, 2019 оны 5-р сар

Зураг 2-2. Монгол улс дахь Азийн хурдны авто замын сүлжээний АН-3 чиглэл (улаанаар тэмдэглэсэн нь Улаанбаатар-Дархан чиглэлийн зам)

Эх сурвалж: MCPCgr ХХК, Инженерийн нарийвчилсан зураг төсөл – 1 дүгээр хэсэг, 2019 оны 5-р сар

2.3. Төсөл

Төсөл нь Улаанбаатар хотын гадна орших Дархан-Эмээлтийн тойрог уулзвараас эхлэх бөгөөд нийт гурван аймгийн зургаан сумд буюу Төв аймгийн[2] Баянчандмань ба Борнуур сум[3], Сэлэнгэ аймгийн Мандал ба Баянгол сум, Дархан-Уул аймгийн Хонгор сумдын нутгийг дайран өнгөрч, мөн Дархан-Уул аймагт орших Дархан хотын өмнөд хэсэгт төгсөнө. Төслийн замын чиглэлийг Зураг 2-3-т харуулав.

Төсөл нь Хүснэгт 2-1-т үзүүлсэн таван хэсэг буюу “багц”-д хуваагдана.

Хүснэгт 2-1. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд

Хэсэг / Багц	Тодорхойлолт	Урт (м)	Төслийн замын эхлэх цэг - метрт	Төслийн замын төгсөх цэг - метрт	Эхлэх цэгийн КМ-ийн заалт	Төгсөх цэгийн КМ-ийн заалт
I	Дархан-Эмээлтийн тойрог уулзвараас эхлэхэд Хар модотын даваанд ар хүртэлх (52-ын даваа)	37,281.77	0	37,281.77	18.9	56.18
II	Хар модотын даваанд араас Тайсын хөтөлийн өвөр хүртэлх	45,500.17	37,281.77	82,781.94	56.18	101.68
III	Урьхан зоогийн газрын орчмоос Бор толгой буюу Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн замын уулзвар хүртэлх	45,753.06	82,781.94	128,535.00	101.68	147.44
IV	Бор толгой буюу Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн замын уулзвараас Цайдамын хөндий хүртэлх	45,050.56	128,535.00	173,585.56	147.44	192.49
V	Цайдамын хөндийгөөс Дархан хотын тойрог уулзвар хүртэлх	28,840.00	173,585.56	202,425.56	192.49	221.33

Эх сурвалж: MCPCgr ХХК (2019 оны 5-р сарын 21), Инженерийн нарийвчилсан зураг төсөл – 1 дүгээр хэсэг

[2] Аймаг гэдэг нь засаг захиргааны дээд түвшний нэгж юм
[3] Сум гэдэг нь аймгийн дараа орох засаг захиргааны хоёрдугаар түвшний нэгж юм.



Зураг 2-3. Төслийн байршил

Эх сурвалж: MCPCgr ХХК, Инженерийн нарийвчилсан зураг төсөл – 1 дүгээр хэсэг, 2019 оны 5-р сар

2.4. Санал болгож буй ажил

Төслийн хүрээнд хийгдэх ажилд тойрог зам, U хэлбэрийн эргэлт болон зогсоолын талбай, замын тоноглол (хайс хашлага, гэрэлтүүлэг гэх мэт) бүхий шинэ зам барих, найман төмөр замын гарам барих, гүүр болон үерийн ус зайлуулах хоолойг шинэчлэн засварлах, мөн төлбөр хураах цэгүүдийг шинэчлэн засварлах ажил багтана.

Замын зорчих хэсэг болон хажуу хөвөөг аль алиныг нь өргөсгөх бөгөөд 68 км орчим үргэлжлэх хэсэг нь одоо байгаа замтай залгаа байх бол үлдсэн 134 км нь одоо байгаа замын төв гол шугамнаас ойролцоогоор 16-18 метр зайтай хөвөө байна. Зам нь Зураг 2-4-т харуулсан ёсоор чиглэлийнхээ уртын дагууд зорчих хэсгээсээ зүүн талруу болон баруун талруу хөвөө хэсэгт шилжинэ. Уг замын төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд нь Монгол улсын Засгийн газрын Авто зам төсөллөх норм ба дүрэм ЗЗБНбД 22-004-2016-ын дагуу 1-р зэргийн замын стандартын хэмжээнд төлөвлөгдсөн.

Замын хөдөлгөөний удирдлага хяналтын арга хэмжээг Монгол улсын холбогдох стандарт, олон улсын туршлагад нийцүүлэн авч хэрэгжүүлнэ.



Зураг 2-4. Замын тэнхлэгийн жишээ (улаанаар тэмдэглэсэн нь ЕСБХБ-ны санхүүжүүлэх зам)

Эх сурвалж: MCPCgr ХХК, Төсөллөх зураг - 2019 оны 5-р сар

Дараах хэд хэдэн бүтцийг бий болгох шаардлагатай. Үүнд:

- 1 дэх хэсэг – Дархан болон баруун аймгуудын зам салдаг тойрог уулзвараас Хар модотын даваа (52-ын даваа)-ны ар хүртэлх 37.28 км зам - 2 гүүр, 50 хоолой барих ба үүнээс 14 нь мал, амьтан ердийн суудлын тэрэг зам хөндлөн гарахад зориулагдсан.
- 2 дахь хэсэг - Хар модотын даваяны араас Тайсын хөтөлийн өвөр хүртэлх 45.49 км зам – гүүр болон ус зайлуулах хоолойнуудын өнгөрөлтийн чадавхыг нарийвчлан тооцоолсон ба ихэнхийнх нь одоогийн байгаа хэмжээсүүдийг өөрчилсөн (өргөтгөсөн). Гүйцэтгэх ажилд 5 гүүр, 66 хоолой барих ба үүний 26 нь мал амьтан, ердийн суудлын тэрэг зам хөндлөн гарахад зориулагдсан. Төслийн замын энэ хэсэг нь Төв аймгийн Баянчандмань сумын төвөөр дайрч гарах ба Дарьгант, Шарын гол, Сайхан, Шивэрт болон Шавартын жижиг голуудыг гатална.
- 3 дахь хэсэг – Урьхан зоогийн газрын орчмоос Бор толгой буюу Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн замын уулзвар хүртэлх 45.75 км зам - 64 дөрвөлжин болон дугуй хоолойг төсөллөсөн ба эдгээрийн 8 нь мал амьтан, ердийн суудлын тэрэг зам хөндлөн гарахад зориулагдсан. Энэ хэсэг нь Тайсын хөтөл, Тахилтын даваа болон Хараагийн даваагаар дайрч өнгөрнө.
- 4 дэх хэсэг – Бор толгой буюу Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн замын уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.06 км зам – Хийгдэх ажлын хувьд 44 дөрвөлжин болон дугуй хоолой болон 2 гүүр төсөллөсөн. Мал амьтан болон явган хүн зам хөндлөн гарахад зориулсан гарцуудыг 13 цэгт бий болгохоор төлөвлөж байна. Энэ хэсэг нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төвөөр дайрч гарах ба Хараа болон Баян голуудыг гатална.
- 5 дахь хэсэг – Цайдамын хөндийгөөс Дархан хотын тойрог уулзвар хүртэлх 28.84 км зам. Хийгдэх ажлуудад нийтдээ 34 ус зайлуулах хоолойн барилга угсралт багтана. Мал амьтан болон явган хүн зам хөндлөн гарахад зориулсан гарцуудыг 16 цэгт бий болгохоор төлөвлөж байна.

2.4.1. Барилгын үе шат

Барилгын үе шатанд шаардагдах ажиллах хүч буюу тоног төхөөрөмжийн талаар тодорхой мэдээлэл байхгүй бөгөөд барилгын гэрээт гүйцэтгэгч нар үүнийг тодорхойлно. Гэхдээ авто замын төслүүдийн зам

барих талбайн суурилуулалт болон бэлтгэл ажлын хүрээнд нийтлэг хийгддэг дараах ажлууд багтана. Үүнд:

- Түр агуулах, ажлын талбай, барилгын кэмпүүдийг бий болгох;
- Бетон болон бутлуурын үйлдвэрийг дайчлах ба суурилуулах;
- Барилгын ажилд шаардлагатай хангамж, материалууд (автомашин, ачааны тэрэг, барилгын тоног төхөөрөмж)-ыг дайчлах;
- Түр зуурын тэмдэглэгээ, шаардлагатай бол гажилтыг засах;
- Ерөнхий цэвэрлэгээ, шаардлагатай бол моддыг цэвэрлэх буюу тайрах; мөн
- Ус зайлуулах систем суурилуулах.

Газар шорооны ажилд тайрах огтлох буюу эсвэл далан барих ажил багтана. Гэсэн хэдий ч газар шорооны ажлыг хоёр үе шат дамнуулан хийж гүйцэтгэхээс зайлсхийхийн тулд 1-р үе шатанд бүх газар шорооны ажлыг хийх эсэх нь одоогоор тодорхойгүй байна.

Барилгын ажлын явцад шаардагдах түр замыг бий болгох ажил нь Төслийн 1-р үе шатны хүрээнд хийгдэх ёстой ажил. Одоогоор Төслийн 2-р үе шатанд ямар нэг нэмэлт түр зам (эсвэл 1-р үе шатанд бий болсон түр замыг ашиглах) шаардлагагүй гэж үзэж байна. Төслийн 2-р үе шатны гэрээт гүйцэтгэгч нарт хүнд даацын тусгай зориулалтын авто зам шаардагдаж болох хэдий ч гэрээт гүйцэтгэгч нар 2-р үе шатны замын мөргөцөгийг хүнд даацын зам болгон ашиглах магадлалтай. Ажил гүйцэтгэгч нартай гэрээ байгуулснаар энэ асуудал тодорхой болно.

Шаардагдах тоног төхөөрөмжийн төрөлд дараах зүйлс багтана. Үүнд:

- Бульдозер
- Тэгшлэгч машин
- Самосвал
- Дугуйт болон гинжит механик экскаватор
- Зам тавигч машин
- Хог шүүрдэгч машин
- Хийн компрессор
- Цилиндр компрессор
- Усны сав
- Шатахууны сав
- Бетон индүүдэгч / тээрэмдэгч машин
- Ачигч төхөөрөмж
- Бетон холигч
- Генератор
- Хөдөлгөөнт кран
- Хөрс холигч машин
- Насос
- Чичиргээ хавтан
- Компрессор
- Дугуй хөрөө
- Будах тоног төхөөрөмж

Барилгын үед замын хучилтанд элс, цемент, битум, дүүргэгч, ус зэрэг түүхий эд материалууд шаардагдах ба эдгээрийн дийлэнхийг Монголоос авна. Замын дагууд Зураг 2-5-д харуулснаар 17 карьер байна. БОННҮБОННҮ[4] нь гэрээт гүйцэтгэгч нар эдгээрээс 11 карьерыг нь ашиглана гэдгийг тогтоосон.

2.4.2. Ашиглалтын үе шат

2.4.2.1. Замын төсөллөлтийн наслалт

Уг замыг 20 жилийн ашиглалтын хугацаатай байхаар төсөллөсөн.

2.4.2.2. Төлбөр хураах цэг

Улаанбаатраас гарангуут (одоо ажиллаж байгаа төлбөр хураах цэг) болон Дархан-Эрдэнэтийн уулзвар дээр гэсэн хоёр газарт ЗТХЯ-ны замын төлбөр хураах цэг байршина. Орон нутагт зорчих тохиолдолд зам ашигласны төлбөр эсэх нь Монгол улсын хуулиар зохицуулагдаагүй.

2.4.2.3. Замын хурд

Төсөллөсөн хурд нь уг замын бараг 70 орчим хувьд 100км/цаг ба Баруунтүрүү, Хар модот, Тахилтын давааны дамжин өнгөрөхөд хэцүү хэсгүүдэд зорчих дээд хурд нь 80 км/цаг байна. Одоогийн хурдны дээд хязгаар нь 80 км/цаг – гэхдээ энэ хязгаарлалт одоо мөрдөгдөхгүй байгаа нь ажиглагдсан. Хот суурин газрын хурдны хязгаарыг 60 км/цаг болгож бууруулна. Хурд хэмжигч камер хоёр ширхэг, мөн замын

[4] СЭК ХХК (2019 оны 5-р сар), Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ.

хөдөлгөөний тандалт хяналтын видео камер таван ширхэгийг Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй холбогдсон байдлаар суурилуулахыг санал болгож байна.

2.4.2.4. Ашиглалт ба засвар арчлалт

Замын ашиглалт, засвар арчлалтын үйл ажиллагааны талаар нарийвчилсан мэдээлэл одоогоор хараахан байхгүй. Гэсэн хэдий ч энэ чиглэлд түгээмэл хийгддэг тогтмол хугацаат засвар арчлалт, мөн замыг цэвэрлэх, үүссэн нүх, эвдрэлийг засварлах гэх мэт урьдчилан төлөвлөгдөөгүй засвар арчлалтын ажлууд багтана.



Зураг 2-5. Одоо байгаа зам дагуух карьер

Эх сурвалж: MCPCgr ХХК (2019 оны 5-р сарын 21), Инженерийн нарийвчилсан зураг төсөл – 1 дүгээр хэсэг

3. Талуудын оролцоог хангах болон мэдээллийг нийтэд ил болгох тухай шаардлагууд

3.1. Танилцуулга

Талуудын оролцоог хангах, мэдээллийг нийтэд ил болгох үйл ажиллагаа нь Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд тавигдах шаардлагууд болон ЕСБХБ-ны БОНБ 2014-ийн шаардлагуудад тодорхойлсон олон улсын сайн туршлага (ОУСТ)-ыг дагаж мөрдөнө. Эдгээрийг дор тайлбарлав.

3.2. Үндэсний шаардлага

Талуудын оролцоог хангах талаарх Монгол улсын гол заалтууд нь дараах хуулиудад агуулагдана.

3.2.1. Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ)-ний тухай хууль (1998 онд батлагдаж, 2001, 2006 болон 2012 онуудад шинэчлэн найруулагдсан)

Уг хуульд БОННҮБОННҮ-ний явцад олон нийтийг оролцуулах шаардлагатай гэж заасан ба 18.4 дүгээр зүйлд БОННҮБОННҮ-г боловсруулах, хийж гүйцэтгэх явцад орон нутгийн иргэд, оршин суугчдын албан ёсны саналыг авч хэлэлцүүлэн тусгахыг шаардсан.

2012 оны шинэчлэн найруулагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 18 дугаар зүйлийн 1-5-д зааснаар:

- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээ хийгдэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
- Засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үндэсний болон бүс нутгийн хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд стратегийн үнэлгээ хийх явцад олон нийтээс санал авна.
- Стратегийн үнэлгээнд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон бичгээр санал авна.
- Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.
- Олон нийтийн оролцооны асуудлыг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу сайд батална.

3.2.2. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль (2003 онд батлагдаж, 2006 онд шинэчлэн найруулагдсан)

Энэ хуулийн гол зорилт нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын харилцааг зохицуулахад оршино. Хуульд бүсчилсэн хөгжлийн үйл явцад нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын бүрэн эрхийг хүндэтгэх тухай заасан. Хууль нь нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудад иргэдээс ирсэн холбогдох асуултад хариулах, “*иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын*” оролцоог дэмжих, чиглүүлэх замаар бүсчилсэн хөгжлийн үйл явцад иргэдийг татан оролцуулах үүрэг хариуцлагыг оногдуулсан.

3.2.3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 он батлагдаж, 2012 он шинэчлэн найруулагдсан)

Энэхүү хууль нь өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах замаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилготой. Хуулийн 5 болон 10 дугаар зүйлийн олон нийтийн зөвшилцөл хэлэлцүүлэгтэй холбоотой заалтуудыг дор харуулав. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа олон нийтэд ил тод байх; болон
- Байгаль орчны хяналт үнэлгээ нь байгаль орчин, түүний баялгийн талаар хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах.

3.2.4. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-117 тоот тушаал (2014 оны 9-р сарын 4)

Тушаал нь БОННҮБОННҮ-ний үр дүнг орон нутгийн иргэд, олон нийтэд ил тод болгох, тэдэнтэй зөвлөлдөх шаардлагуудыг тусгасан байна. Тодруулбал, БОННҮБОННҮ-г гүйцэтгэх компани / зөвлөх нь орон нутгийн засаг захиргаа, нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, орон нутгийн оршин суугчдын санал хүсэлтийг авах ёстой гэж заажээ. Түүнчлэн, БОННҮБОННҮ-ний зөвлөх нь оролцоог хангах, төслийн мэдээллийг нийтэд ил тод болгох зохих арга хэмжээнүүдийг сонгон авснаар төслийн онцлогт нийцсэн оролцоог хангах ажлыг зохион байгуулна. Үүнд түүврийн судалгаа, асуумж, ярилцлага, олон нийтийн эх үүсвэрийн зураглал, нээлттэй хэлэлцүүлэг болон фокус бүлгийн ярилцлага (ФБЯ)-ын аргууд илүү үр дүнтэй.

БОННҮБОННҮ нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс болон төслийн хамтрагч талуудтай хийсэн уулзалт, зөвлөлдөх уулзалт ба хийгдсэн судалгаанууд, мэдээллийг хэзээ хэрхэн нийтэд ил болгосон тухай; оролцогчдын ирц;
- Ярилцсан гол сэдвүүд, зөвлөлдөх уулзалтын үеэр хөндөгдсөн голлох асуудлуудын талаарх мэдээлэл; мөн
- Зөвлөлдөх уулзалтын явцад дэвшүүлсэн, төслийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үйл ажиллагаанд тусгах шаардлагатай бодит саналууд.

Төсөл хэд хэдэн баг, сумдын нутаг дэвсгэрийг хамарч байгаа тул БОННҮ-ний зөвлөх нь тэдний санал хүсэлтийг авахын тулд БОННҮ-ний үр дүнгийн талаар багийн хурал, сумын иргэдийн хурал тус бүрт мэдээлэл хүргүүлнэ.

3.2.5. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-03 тоот тушаал (2014 оны 1-р сарын 6)

Уг тушаал нь Байгаль орчны стратегийн нөлөөллийн үнэлгээ, Хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ болон БОННҮ-нд хамаарна. Дараах шаардлагуудыг хангах ёстой. Үүнд: Мэдээллийн нээлттэй байдал, мэдээллийн ил тод байдал болон хүртээмж, мэдээлэл солилцох нөхцлийг хангах; хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг дэмжигчид, нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүс (шууд ба шууд бусаар өртөх), нутгийн иргэд олон нийт болон бусад байгууллагуудын дундах зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах; нөлөөллийг бууруулах арга хэмжээг төсөллөхдөө төслийн хамтрагч талуудын санал зөвлөмж, мэдээллийг ашиглах; нутгийн иргэд оршин суугчдын уламжлалт соёл, зан заншил, үнэт зүйлс, уламжлалт амьдралын хэв маяг, эрхийг хүндэтгэх. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөлийн талаарх мэдээлэл нь нээлттэй, иргэдэд хүртээмжтэй байх, энэ төрлийн мэдээллийг олон нийт чөлөөтэй олж авах боломжтой байх ёстой.

Олон нийтийн оролцоо нь БОННҮ-ний явцад дараах байдлаар шаардагдана. Үүнд:

- БОННҮ нь үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог хангах ёстой;
- Урьдчилан таамагласан нөлөөллийн талаарх оршин суугчдын санал бодлыг оролцооны арга ашиглан олж мэднэ;
- Зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг, судалгаа зэрэг арга хэрэгслүүд ашиглан шууд ба шууд бус нөлөөллийг үнэлэх, ингэхдээ амьжиргаа, нийгмийн асуудлуудыг хамруулан авч үзэх;
- Төсөл, түүний эерэг ба сөрөг нөлөөлөл, нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаарх мэдээллээр хангах;
- БОННҮ-ний зөвлөх, төслийг дэмжигч нь БОННҮ-ний тайлан болон Байгаль орчны удирдлагын төлөвлөгөөг боловсруулж дуусгаанаас хойш 15 хоногийн дотор эдгээр баримт бичгүүдийг баг/хорооны нийтийн хуралд хүргүүлж, саналыг нь авах ба ингэхдээ төслийн хамарч буй нутаг дэвсгэр дэх баг, сумдыг бүгдийг нь оролцуулах ёстой;

- Нөлөөлөлд өртсөн иргэд оршин суугчид нь уг санал болгож буй төслийн эцсийн шийдвэр гарахаас өмнө өөрсдийн санал хүсэлтийг баг/хорооны нийтийн хуралд хүргүүлэх шаардлагатай;
- Төслийг дэмжигч, сум/дүүргийн засаг дарга, баг/хорооны нийтийн хурал болон аймаг/нийслэлийн Байгаль орчны газар нь БОННҮ-ний батлагдсан тайланг олж авах боломжоор хангах үүрэгтэй;
- Төслийг дэмжигч нь төслийн хэрэгжилтийн талаар нутгийн иргэд болон олон нийтэд хамгийн багадаа жилд нэг удаа тайлагнах ёстой;
- БОННҮ-ний тайлан дахь зөрүүтэй асуудлуудын талаарх гомдлыг нутгийн иргэд/олон нийтийн зүгээс төсөл, орон нутгийн захиргаа буюу эсвэл Байгаль орчны яаманд мэдүүлж болно;
- Байгаль орчны яам өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх ёстой ба хэрэв тухайн хүн/олон нийт нь тэрхүү шийдлийг хүлээн зөвшөөрөхгүй бол гомдлоо шүүхэд гаргаж болно.

3.3. ЕСБХБ-ны шаардлага

ЕСБХБ нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжихэд бэлэн бөгөөд талуудын оролцоог хангах тухай шаардлагуудаа дараах баримт бичгүүдээр тодорхойлсон байдаг. Үүнд:

- Байгаль орчин, нийгмийн бодлого (2014)
- Олон нийтийн мэдээллийн бодлого (2014).
- ГШ 10 - Мэдээллийг нийтэд ил болгох ба талуудын оролцоог хангах тухай (2014)

ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого нь ЕХ-ны холбогдох заавар удирдамжийг дагаж мөрдөхийг шаарддаг.

3.3.1. ЕСБХБ-ны Байгал орчин, нийгмийн бодлого (БОНБ) (2014)

БОНБ нь ЕСБХБ ил тод байдал, хариуцлагатай байдал, талуудын оролцоог хангах зарчмуудад үнэнч байхыг илэрхийлсэн байдаг. ЕСБХБ нь өөрийн харилцагч буюу зээлдэгчдэд төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй буюу төслийг талуудыг тодорхойлох, төслөөс үүдэн гарсан аливаа асуудал болон сөрөг нөлөөний талаар хангалттай хэмжээний мэдээллийг ил тод болгох, талуудтай нухацтай, соёл уламжлалд нь тохирсон хэлбэрээр зөвшилцөх шаардлага тавьдаг. талыг төсөлд хамаарах болзошгүй нөлөөлөлд зохих хэмжээгээр оролцуулах ёстой.

3.3.2. ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 10 (2014)

ЕСБХБ-ны мэдээллийг нийтэд ил тод болгох ба талуудын оролцоог хангах тухай ГШ 10 нь байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл, асуудлуудыг амжилттай удирдан зохион байгуулахад талуудын оролцоо зайлшгүй чухал бөгөөд олон нийттэй бүтээлч, хариуцлагатай харилцаа холбоог бий болгоход голлох үүрэг гүйцэтгэнэ гэж үздэг. ЕСБХБ-ны мэдээллийг нийтэд ил тод болгох ба талуудын оролцоог хангах тухай ГШ 10-ын шаардлагуудыг дор харуулав.

Талуудын оролцоог хангах шаардлагууд

- Талуудын оролцоог хангах гэдэгт дараах зүйлсийг авч үзэх ба үүнд: Талыг тодорхойлох болон шинжлэн дүгнэх, талуудын оролцоог төлөвлөх, мэдээлэх, нухацтай зөвшилцөх ба оролцоог хангах, гомдол гаргах, барагдуулах үйл явцуудыг ил тод болгох, мөн холбогдох талуудад тогтмол тайлагнах асуудал орно;
- Зээлдэгч нь талуудад цаг тухай бүрт, тэдэнд хамааралтай мэдээлэл, асуудлыг ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх ба оролцооны явцад аливаа булхай, хөндлөнгийн оролцоо, албадлага, айлган сүрдүүлэлт, өс хонзон гарахаас сэргийлсэн, талуудыг тэгш хамруулсан, тэдний соёл уламжлалд тохирсон, утга учиртай хэлбэрээр оролцооны арга хэмжээг зохион байгуулна;
- Талуудыг оролцуулах үйл ажиллагаа нь төслийн төлөвлөлтийн аль болох эхний үе шатанд эхэлж, төслийн бүхий л хугацаанд үргэлжлэх ёстой. Төслийн бүхий л үе шатанд оролцох талуудын оролцоог хангах давтамж, утга агуулга нь төслийн мөн чанар, цар хүрээ болон байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, оролцогч талуудын ашиг сонирхол зэрэгтэй уялдсан байна. Зээлдэгч нь олон нийтэд мэдээлэл хүргэх, хэлэлцүүлэг явуулах талаарх тухайн улс орны хууль, тогтоомж болоод олон улсын шаардлагын дагуу тухайн орны дагаж мөрдөхөөр заасан дүрэм, журмыг хэрэгжүүлнэ; мөн

- Зээлдэгч нь талуудын оролцоог хангах талаарх үүрэг хариуцлага, эрх мэдлийг нарийвчлан тодорхойлж зааж өгөх ба түүнчлэн, талуудын оролцоог хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй боловсон хүчнийг томилсон байна.

Мэдээллийг ил тод болгох шаардлагууд

- Хэрэв нийгмийн бүлгүүд төслөөс үүдэн байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд өртөж болзошгүй бол зээлдэгч нь талуудад төслийн эрсдэл, нөлөөлөл, боломжуудын талаар ойлголт авахад тус дөхөм болох мэдээллээр хангана. Зээлдэгч нь талуудыг дараах мэдээллээр хангана. Үүнд:
    - төслийн зорилго, мөн чанар, цар хүрээ болон төслийн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа;
    - талуудад эрсдэлтэй, бодит нөлөөллүүд үүсэхээр бол эмзэг өртөмхий бүлгүүдийн харилцан адилгүй өртөж болох боломжит эрсдэл, нөлөөллийг онцолсон, тэдгээрийг бууруулах арга хэмжээнүүдийг ялгавартайгаар тусгасан санал дэвшүүлж буй төлөвлөгөө;
    - хэрэв төлөвлөсөн бол талуудын оролцоог хангах аливаа үйл явц, мөн талуудыг оролцуулах боломж, арга замууд; мөн
    - төлөвлөж буй аливаа олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалт болох газар, цаг, уулзалтын тухай мэдэгдэх, нэгтгэн дүгнэх ба тайлагнах, мөн өргөдөл гомдлыг барагдуулах үйл явц орно.
- Уг мэдээллийг тухайн орон нутгийн иргэдийн ярьдаг хэл дээр, ойлгоход хялбар, тэдний соёл, уламжлалд тохирсон зохих хэлбэрээр түгээнэ. Түүнчлэн, өөрсдийн нийгмийн статус, мэдээллийн тусгайлсан хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл, бичиг үсгийн боловсрол, хүйс, шилжилт хөдөлгөөн, хэл соёлын ялгаа, хүртэх боломж зэрэг)-нээс шалтгаалан төслийн нөлөөлөлд ялгаатай байдлаар өртсөн хүн амын бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагыг мөн тооцон үзвэл зохино. Шаардлагатай бөгөөд соёл уламжлалд харшлахгүй бол, айлган сүрдүүлэлт, албадлага буюу бүх хэлбэрийн хууран мэхлэлтээс зайлсхийхийн тулд мэдээллийг нийтэд ил тод болгоход гуравдагч этгээдийг хөлслөн ажиллуулж болно.

3.3.3. ЕСБХБ-ны Олон нийтийн мэдээллийн бодлого (2014)

ЕСБХБ-ны Олон нийтийн мэдээллийн бодлого (2014) нь Банк өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааны талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, дэмжихийн тулд хэрхэн талуудтай зөвшилцөж, мэдээллийг ил тод болгодог тухай тайлбарласан. ЕСБХБ-ны Олон нийтийн мэдээллийн бодлогын шаардлагуудыг дор харуулав. Үүнд:

- Төслийн нөлөөлөлд өртсөн буюу өртөж болзошгүй (эмзэг бүлгүүдийг мөн хамруулна) иргэд, олон нийт, мөн сонирхсон бусад талуудыг тодорхойлох;
- Тэдгээр талууд нь мэдээллийг ил тод болгох, нухацтай зөвшилцөх үйл явцаар дамжуулан өөрт нөлөөлж болзошгүй байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд зохих байлаар оролцох нөхцлийг хангах; мөн
- Төслийн хэрэгжилтийн явцад утга учиртай оролцох зарчмаар хамтрагч талуудтай байнгын үр дүнтэй харилцаа холбоо тогтоож, улам хөгжүүлэх.

3.3.4. Байгаль орчны холбогдолтой төрийн болон хувийн хэвшлийн тодорхой төслүүдийн үр дүн, нөлөөллийг үнэлэх тухай ЕХ-ны 2011/92/EU тоот захирамж (БОНБҮ-ний Захирамж)

БОНБҮ-ний Захирамж болон нэмэлт өөрчлөлтүүд нь шийдвэр гаргах явцад олон нийтийн үр дүнтэй оролцоо, мөн холбоод, байгууллагууд, ялангуяа төрийн бус байгууллагуудын оролцоог хангах хэрэгцээ шаардлагыг цохон тэмдэглэсэн байдаг. Түүнчлэн мэдээлэл, ил тод байдлыг олон нийтэд илүү хүртээмжтэй болгохын тулд байгаль орчны мэдээллийг цаг тухайд нь цахим хэлбэрээр ашиглах боломжтой байлгахыг шаарддаг. Нөлөөлөх байдлын үнэлгээний баримт бичгийг олон нийтийн санал бодлыг авах үүднээс нийтэд ил тод болгох нь энэхүү Захирамжийн хүрээн дэх бас нэг шаардлага юм.

Олон нийтэд зөвлөлдөх үйл явцад бэлтгэх болон оролцоход нь зориулж хангалттай цаг хугацаа олгох ёстой. Зөвлөлдөх уулзалтын үр дүнг бүртгэн тэмдэглэж, төслийг бэлтгэн боловсруулах үе шатанд анхаарч үзэх шаардлагатай.

3.3.5. Аархусын Конвенц

Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх Конвенц (Аархусын Конвенц)-ийг анх 1988 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Европын Эдийн Засгийн Комисс (НҮБЕЭЗК буюу UNECE) баталсан. 2011 оны 7-р сарын 5-нд хуралдсан Конвенцид нэгдэн орсон улс орнуудын уулзалтаас НҮБЕЭЗК-ын бүсийн гаднах улс орнуудыг уг конвенцид нэгдэхийг дэмжих шийдвэр гаргасан бөгөөд тийнхүү нэгдэхэд зориулсан хялбарчилсан журам боловсруулан гаргасан.

Конвенцийн 6 дугаар зүйлд олон нийтэд оролцоход хангалттай хугацаа олгох, аль болох эртнээс оролцох бололцоогоор хангах, оролцооны үр дүнг анхаарч үзэх нөхцлийг хангах үүргийн талаар заасан байдаг. 7 дугаар зүйлд Талуудыг “байгаль орчинтой холбоотой төлөвлөгөө, хөтөлбөр бэлтгэх явцад олон нийтийг оролцоход зориулсан зохих практик буюу эсвэл заалтууд”-ыг бий болгохыг шаарддаг.

Монгол улсын Засгийн газар энэхүү Конвенцид хараахан нэгдээгүй ч НҮБЕЭЗК-тай харилцах замаар Конвенцид нэгдэн орох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Зарчмын хувьд Монгол улсын хууль тогтоомж энэхүү Конвенцийн шаардлагуудад өргөн хүрээнд нийцсэн байна.

3.4. Үндэсний болон ЕСБХБ-ны шаардлага хоорондын ялгаа

Монгол улсын үндэсний тогтолцоо нь олон нийтийн зөвшилцөл, талуудын оролцоог хангах тухай ЕСБХБ-ны шаардлагуудтай өргөн хүрээнд нийцдэг. Гэхдээ шийдвэрлэх шаардлагатай хэд хэдэн ялгаатай талууд бий. Үндэсний шаардлагууд нь талуудын нарийвчилсан тодорхойлолт буюу эсвэл нухацтай, эрх мэдэлжүүлсэн зөвлөлдөх уулзалтыг анхаарч үздэггүй. Мөн гомдол барагдуулах механизмын талаар тодорхой шаардлага тусгагдаагүй.

Тиймээс ТОХТ нь өнөөрийг хүртэл хэрэгжүүлж ирсэн оролцоонд нэмэлт болгох, талуудын оролцоог хангах талаарх ЕСБХБ-ны илүү хатуу стандарт, шаардлагуудад нийцүүлэх зорилгоор цаашдын зөвшилцөх уулзалтуудыг зохион байгуулах болон өргөдөл гомдлыг шийдвэрлэх үйл явцыг тодорхойлох бүхий л шаардлагуудыг авч үзсэн болно.

А зэрэглэлийн төсөл болохын хувьд уг Төсөл нь талуудтай Төслийн үе шат болгонд харилцаж, тэдний санал бодлыг төслийн холбогдох баримт бичгүүдэд тусган оруулах шаардлагатай.

БОНҮ-ний нэмэлт баримт бичгүүд, тухайлбал энэхүү ТОХТ-г олон нийтийн саналыг авах зорилгоор ЕСБХБ-ны вэб хуудсанд байршуулах болон орон нутагт түгээх байдлаар нийтэд ил болгоно.

ТОХТ нь Төслийн барилга угсралт болон ашиглалтын үе шатуудад мөн нарийвчлан боловсруулагдана.

4. Талуудын оролцоог хангах чиглэлд өмнө хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тойм

4.1. Танилцуулга

Энэ хэсэгт Төслийн зүгээс өнөөдрийг хүртэл хэрэгжүүлсэн талууыг оролцоог хангахад чиглэсэн үйл ажиллагаануудыг танилцуулна. Өмнө 1 ба 2 дугаар хэсгүүдэд тайлбарласан ёсоор Төсөл нь ижил замын дагууд хийж гүйцэтгэхээр санал болгож буй ажлын 2-р үе шатыг бүрдүүлнэ. Иймд 2017 оноос хэрэгжсэн нийт төслийн хэрэгцээнд зориулан хийгдсэн Техник эдийн засгийн үндэслэл судалгаанаас эхлээд 1 ба 2-р үе шатуудын аль алиных нь хүрээнд оролцоог хангах чиглэлд гүйцэтгэсэн ажлыг тойм маягаар харуулсан болно. Оролцоог хангах үйл ажиллагаануудын гол үр дүнгийн талаарх тайлбар мэдээллийг мөн дор үзүүлэв.

4.1.1. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын Техник эдийн засгийн үндэслэл (2017) – Нийгмийн судалгааны тайлан

Нийгмийн судалгааг 2017 онд боловсруулсан Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгож хийсэн бөгөөд уг судалгаанд зориулан санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон орон нутгийн иргэдийн төлөөлөл 384 хүн (нийт 130,267 хүн амын тоонд нийцүүлсэн харьцаа)-ийг хамруулсан суурь судалгаа явуулсан. Мөн зам дагуух 6 суурьшлын бүс (Баянчандмань, Жаргалант, Борнуур, Сүмбэр, Баянгол, Хонгор сумд)-д үйл ажиллагаа явуулдаг үйлчилгээ үзүүлэгчид, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөллүүдээс ярилцлага авсан.

Судалгаанд хамрагдагсад Дархан-Улаанбатар чиглэлийн авто замыг засварлаж шинэчлэх санааг бүрэн дэмжсэн (нийт судалгаанд хамрагдсан 384 хүнээс 382 буюу 99.47% нь уг санааг дэмжсэн). Ярилцлага өгсөн байгууллагуудын төлөөллүүд (үйлчилгээ үзүүлэгчид, төрийн ба хувийн хэвшлийн байгууллагууд) бүгд мөн адил уг замд их засвар хийж шинэчлэхийг дэмжсэн. Судалгаанд хамрагдагсдын гуравны хоёр нь замын хучилтын материалд цемент бетон сонгож ашиглахыг илүүд үзсэн бол үлдсэн гуравны нэг нь асфальт бетон ашиглахыг илүүд үзсэн.

Дараах гол асуудлууд хөндөгдөв. Үүнд:

- Хүмүүсийн амьдрал, амьжиргаанд авто замын гүйцэтгэх үүрэг, хэрэгцээ шаардлага маш өндөр;
- Улаанбаатар-Дархан чиглэлийн замыг ашиглагч, зорчигч нар уг замын өнөөгийн байдалд сэтгэл дундуур байдаг бөгөөд шинэчилж сайжруулах нь маш чухал гэж үздэг байна;
- Замын хөгжил нийгмийн хувьд хэр зэрэг чухал, түүнийг дэмжих эсэх тухайд – судалгаанд хамрагдсан нийт 384 хүнээс 382 буюу 99.47% нь Улаанбаатар-Дархан чиглэлийн замыг засажу шинэчлэх ажлыг дэмжиж байна гэж хариулсан. Дарханы замыг шинэчлэх нь нийгмийн хэрэгцээ шаардлага болсон бөгөөд энэхүү их засварыг олон нийт маш ихээр дэмжиж байна; мөн
- Замыг хөгжүүлсний үр дүнд бий болох нийгмийн хөгжил өөрчлөлтийн тухайд – нийтэд нь авч үзвэл, судалгаанд хамрагдагсдын 51-86% нь нийгмийн бүхий л хүрээний асуудалд эерэгээр нөлөөлнө гэж хариулсан; 5.7-23.7% нь замын хөгжил эерэг нөлөө үзүүлнэ гэдэгтэй ямар нэг хэмжээгээр санал нийлсэн.

Ерөнхийдөө, судалгаанд хамрагдагсад замын засвар шинэчлэлтийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь эерэг байна гэж итгэж байлаа. Мөн тэд замыг хөгжүүлсний үр дүнд нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон эерэг өөрчлөлтүүд гарна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн.

4.1.2. 1-р үе шат: Азийн Хөгжлийн Банк (АХБ) Анхан шатны байгаль орчны үнэлгээ (АШБОҮ) – Монгол улсын Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, зам засварын төсөл (2018)

Талуудын зөвлөлдөх уулзалтын асуумж

Талуудын зөвлөлдөх уулзалтыг төслийн 1-р үе шатны БОННҮ-г хийсэн зөвлөх баг 2017 оны 3-р сарын 30-наас 4-р сарын 2-ны хооронд зохион байгуулсан ба холбогдох тайланг АХБ-ны Байгаль орчны

нөлөөллийн анхан шатны үнэлгээ (БОНАШҮ)-ний тайлан[5]-д тусгасан байна. БОНАШҮ-ний тайланг ирүүлэх үеийн 1-р үе шатны зам нь Улаанбаатар-Дархан-Алтанбулаг гэсэн арай илүү урт замыг хамарч байсныг тэмдэглэжээ. Төслийн 2-р үе шаттай холбоотойгоор, оролцоог хангах чиглэлд замын хоёр талаар амьдардаг иргэд олон нийт болон зам дагуух томоохон суурьшлын газруудын оршин суугчдын дунд асуумжид суурилсан судалгаа хийсэн. Уг судалгаанд нийт 85 оршин суугч хамрагдсан.

Зохион байгуулагдсан уулзалтуудын тоо болон огноо зэрэг нарийвчилсан мэдээллийг БОНАШҮ-нд оруулж тайлагнаагүй. Гэхдээ судалгаанд хамрагдагсдын 59% нь эрэгтэйчүүд, 41% нь эмэгтэйчүүд байв. Ажил мэргэжлийн хувьд, нийт судалгаанд хамрагдагсдын 65% нь төрийн байгууллагад ажилладаг гэсэн бол 12% нь хувийн хэвшлийн компаниудад ажилладаг, 5% нь газар тариалангийн бизнес эрхэлдэг (эсвэл фермер), 18% нь бусад салбар, бизнесийн чиглэлд ажилладаг гэж хариулсан байна.

Асуумжийн судалгааны үр дүнг дор (АХБ-ны БОНАШҮ-нд тайлагнасны дагуу) тоймлов. Үүнд:

- Оролцогчдын 50% нь өөрийн гэсэн байнгын оршин суух газар буюу малын бэлчээрийн газаргүй;
- Судалгаанд хамрагдагсдын ойролцоогоор тэн хагас нь Улаанбаатар-Дархан-Алтанбулаг чиглэлийн замаас 10км хүртэлх зайд амьдардаг оршин суугчид байв;
- Судалгаанд хамрагдагсдын 95% нь замын төслийг дэмжиж байна;
- Судалгаанд оролцогчид замыг сэргээн шинэчлэснээр байгаль орчинд дараах байдлаар нөлөөлж болзошгүй гэж үзсэн. Үүнд:
    - Бэлчээрийн газар нутгийг хумьж багасгах зэргээр газар ашиглалтанд нөлөөлөх (10%);
    - Усны эх үүсвэрийг бохирдуулах (7%);
    - Газрыг эвдэж, хөрсийг элэгдэлд оруулах (20%);
    - Тоосжилт үүсгэх (36%);
    - Ургамлын бүрхэвчийг доройтуулах (9%);
    - Зэрлэг ан амьтдын хөдөлгөөн, амьдрах орчинд садаа болох (10%); болон
    - Ойн нөөцөд сөргөөр нөлөөлөх (8%).
- Судалгаанд хамрагдагсад уг замыг шинэчлэн засварлах ажлын улмаас гарах дараах гол эерэг ба сөрөг үр дүнг нэрлэсэн. Үүнд:
    - *Эерэг үр дүн:* 14% ажлын байр нэмэгдэнэ; 6% амьжиргаа дээшилнэ; 5% улсын төсвийн орлого нэмэгдэнэ; 9% орон нутгийн төсвийн орлого нэмэгдэнэ; 17% дэд бүтэц сайжирна; 16% орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд тус дөхөм болно гэж хариулсан.
    - *Сөрөг үр нөлөө*: бэлчээрийн газар доройтно (4%); усны эх үүсвэр хомсдоно (3%); хөрсний гадарга бохирдож элэгдэнэ (7%); агаар бохирдоно (6%); ургамлын бүрхэвч доройтно (3%).
    - Судалгаанд хамрагдагсдын 10% нь ямар нэг сөрөг нөлөөллийг урьдчилан хараагүй.
- Судалгааны оролцогчидзамыг сэргээн шинэчлэх явцад сөрөг нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг авах боломжтой гэж санал болгосон. Үүнд:
    - Тогтмол бага засварын ажил
    - Замын тэмдэг, мал амьтны гарц гармыг сайжруулах;
    - Шаардлагатай цэгүүдэд хурд сааруулагч тавих;
    - Боломжтой бол замыг өргөсгөх;
    - Замын хоёр талаар мод тарихдаа модод болон замын далан хоорондын зайг зохистой хэмжээнд барих. Эс бөгөөс тарьсан модод замруугаа орж ургана; мөн
    - Тарьсан моддыг зохистой арчилж хамгаалахад анхаарах.
- Замын ашиглалт, засвар арчлалтын талаар дараах саналуудыг хэлэв. Үүнд:
    - Зам дээр тогтсон цас, мөс, тоос шороог тогтмол цэвэрлэж байх хэрэгтэй;
    - Замын засвар арчлалтын байгууллагыг цас цэвэрлэгч ачааны машинаар хангах хэрэгтэй;
    - 40 тонноос дээш хүнд даацын ачааны тэргүүдийг зам дээр явуулахыг хориглох;
    - Байгалийн аюултай үзэгдлүүд болдог d цэгүүдэд судалгаа хийх; мөн
    - Замын тэмдэг, тэмдэглэгээ байхгүйгээс зам тээврийн осол ихээр гардаг Дархан суман дахь 226-р цэгт онцгой анхаарал хандуулах.

Төрийн албан хаагчдыг оролцуулах

[5] АХБ (2018), Байгаль орчны нөлөөллийн анхан шатны үнэлгээ (БОНАШҮ). Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, зам засварын төсөл.

Энэхүү талуудтай хийх зөвлөлдөх уулзалтаас гадна 2017 оны 3-р сарын 31 болон 4-р сарын 1-ний өдрүүдэд дараах төрийн 5 албан хаагчидтай дөрвөн удаагийн уулзалт зохион байгуулсан. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын засаг дарга;
- Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газрын дарга;
- Сэлэнгэ аймгийн Ойн газрын дарга;
- Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын хоёр албан хаагч; болон
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын орлогч.

Орон нутгийн засаг захиргааны албан хаагчид Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг шинэчлэн засварлах ажлыг дэмжихээ илэрхийлж, төсөл хэрэгжээд дууссаны дараа орон нутгийн зам угсралтын компаниуд цаашид замын нөхөн сэргээлтийг зохих хэлбэрээр хийж гүйцэтгэх ёстой гэж үзэж, түүний хэрэгжилтэнд санаа зовж байгаа тухайгаа ярьсан. Түүнчлэн санал солилцсон орон нутгийн засаг захиргааны албан хаагчид барилгын компаниудыг барилгын хог хаягдлаа зохистой хаядаг болгох, замын хажуугаар мод тарих, ингэхдээ жолооч нарын харах орчинг хязгаарлахгүй байхад анхаарах зэрэг олон тооны санал хэлсэн.

Улаанбаатар-Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замын корридорын талаарх Олон нийтийн санал бодлын нэмэлт судалгаа

Нэмэлтээр АХБ-ны зөвлөхүүд 2018 оны 3 дугаар сард нь Төслийн 1-р үе шатанд хийгдсэн БОНАШҮ-ний ажлын хүрээнд олон нийтийн санал бодлыг тодорхойлох судалгааг малчдын дунд явуулжээ. Замын корридорын дагуу суурьшин амьдардаг 120 малчин өрхийг уг судалгаанд хамруулсан байна. Төслийн бэлтгэл ажлын зөвлөх малчин өрхүүдээр зочилж, судалгааны хүрээнд ганцаарчилсан уулзалт болон хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулсан. Амьжиргааны суурь нөхцөл, амьжиргаа болон байгаль орчны нөхцөл байдлын тухайд санаа зовоож буй асуудлуудыг ойлгох нь судалгааны гол цөм нь байлаа.

Малчин өрхүүдийн 109 (90.8%) нь Дархан-Уул аймгийн Дархан болон Хонгор сумдын харьяат бол 3 өрх (2.5%) нь Төв аймгийн Баянчандмань сумынх, үлдсэн 8 малчин өрх (7.6%) нь Сэлэнгэ аймгийн[6] Баянгол сумын харьяат байв.

Дараах мэдээлэл нь БОНАШҮ-ний тайлан дурдагдсан байна. Үүнд:

- Судалгаанд хамрагдсан малчдын 15% нь замаас 1 км-ээс илүүгүй зайд амьдардаг;
- Судалгаанд хамрагдсан малчдын 40% нь амьжиргааны хувьд мал бэлчээх, малын өвс тэжээл, бэлтгэх хангалттай хэмжээний газар байхгүй нь хамгийн гол тулгамдсан асуудал гэж үзсэн;
- 25% нь байгаль орчны бохирдол, өсөн нэмэгдсээр байгаа хог хаягдал нь тэдний амьдарч буй газарт тулгамдаад буй байгаль орчны хамгийн гол асуудал гэж хариулсан;
- Айл өрхүүдийн ундны усны эх үүсвэр нь зэргэлдээх голууд болдог. Гэвч голын усыг малчин өрхүүдийн 30% нь л хааяа ундандаа хэрэглэдэг байна. Оролцогчдын 25% нь өөрсдийн усны худагтай гэсэн бол 75% нь худаггүй гэж хариулсан; мөн
- Судалгааны явцад малчдын зүгээс төсөлтэй холбоотойгоор байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөө үүсэх тухай яриагүй бөгөөд судалгаанд хамрагдагсад ерөнхийдөө төслийг дэмжиж байв.

4.1.3. 2-р үе шат: Төслийн 2-р үе шатанд хийгдэх ажлын Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ) (2019)

Төслийн 2-р үе шатанд хийхээр санал болгож буй зам өргөтгөх ажилд зориулан хийгдсэн БОННҮ[7] нь 2019 оны 2-р сараас 4-р сар хүртэлх хугацаанд зохион байгуулагдсан иргэд олон нийтийн зөвлөлдөх уулзалтуудын талаарх мэдээлэл болон Улаанбаатар-Дархан чиглэлийн замын дагуух орон нутгийн 6 сум, суурьшлын бүсүүдийн эрх бүхий байгууллагуудын өгсөн саналыг тусгасан.

ЭсИСи ХХК-ын БОННҮ-ний зөвлөх нь иргэд олон нийтийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тухай албан ёсны хүсэлтээ 2019 оны 2-р сарын 15-нд орон нутгийн засаг захиргаанд илгээсэн. Уулзалтууд нь 2019 оны 2-р сарын 18-наас 3-р сарын 13-ны хооронд зохион байгуулагдсан ба ингэхдээ хоёр янзын

[6] АХБ-ны ТБАТТ-ны зөвлөх (2018), Байгаль орчны нөлөөллийн анхан шатны үнэлгээ (БОНАШҮ)-нд дурдсан (АХБ 2018). Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, зам засварын төсөл.
[7] СЭК ХХК (2019 он), Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ).

хэлбэртэйгээр хийгдсэнийг дурдвал 15 удаагийн Багийн нийтийн хурал (жишээ нь тухайн багт амьдардаг бүх айл өрхүүдийн дунд одоогийн байдлаар улиралд нэг удаа зарлагддаг албан ёсны хурлыг ашиглан) болон 4 удаагийн олон нийтийн уулзалт байв. Эдгээр зөвлөлдөх уулзалтуудыг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн[8] Сайдын А-03 тоот тушаалаар батлагдсан олон нийтийн зөвлөлдөх уулзалтын зарчмын шаардлагуудын хүрээнд зохион байгуулах шаардлагатай.

Уулзалтын үеэр Төслийн байгаль орчинд учруулж болзошгүй нөлөөллийн тухай танилцуулж, талуудын Төслийн нөлөөллийн талаарх ойлголт, үзэл бодлыг мэдэх, болзошгүй сөрөг нөлөөллийг буурулах санал зөвлөмжийг нь сонсохыг зорьсон.

Эдгээр уулзалтуудаар Дархан-Уул аймгийн Дархан сум болон Төв аймгийн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид Хурал гэх)-ын дарга нарыг өөрсдийн санал зөвлөмжөө өгөхийг хүссэн.

Багийн нийтийн хурлын үеэр БОННУ-ний зөвлөхийн хөтөлсөн тэмдэглэл болон Багийн нийтийн хурлын тогтоол шийдвэрүүд (албан ёсны Багийн хурлын тэмдэглэл) дээр үндэслэн тэдгээрээс гарсан санал зөвлөмжүүдийг 2019 оны 3-р сарын 13, 14, 15, 18, 20-ны өдрүүд болон 4-р сарын 2-ны өдрийн сумын Хурал, сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар тус тус хэлэлцсэн.

Хүснэгт 4-1-т Багийн нийтийн болон иргэдийн хурал, уулзалтуудыг нэгтгэн харуулав.

Хүснэгт 4-1. БОННУ-ний бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулагдсан уулзалтууд

№	Байршил	Зөвлөлдөх уулзалтын хэлбэр	Огноо	Оролцогчдын тоо[9]	Ирцийн түвшин*
1	Баянчандмань сум	Олон нийтийн зөвлөлдөх уулзалт	2/18/2019	Тодорхой бус	Хурал хүчинтэй байх ирцийн хувь хүрсэн
2			3/11/2019		
3		Сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан	4/4/2019	6	57.1
4		1-р Багийн нийтийн хурал	3/20/2019	105	25.2
5		2-р Багийн нийтийн хурал	3/26/2019	130	86
6		3-р Багийн нийтийн хурал	3/20/2019	Тодорхой бус	Хурал хүчинтэй байх ирцийн хувь хүрсэн
7	Борнуур сум	Олон нийтийн зөвлөлдөх уулзалт	2/25/2019		
8		Сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан	3/20/2019	5	71.4
9		1-р Багийн нийтийн хурал	2/25/2019	Тодорхой бус	Хурал хүчинтэй байх ирцийн хувь хүрсэн
10		2-р Багийн нийтийн хурал			
11		4-р Багийн нийтийн хурал			
12	Жаргалант сум	Сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан	3/18/2019	4	66.6
13		*Баянбулаг* Багийн нийтийн хурал	3/13/2019	72	65
14	Баянгол сум	Сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан	3/15/2019	8	85.7
15		1-р Багийн нийтийн хурал	2/20/2019	72	55
16		2-р Баг *Баянгийн* нийтийн хурал	2/20/2019	90	Хурал хүчинтэй байх ирцийн хувь хүрсэн
17		3-р Баг *Гонирын* нийтийн хурал	2/20/2019	12	62
18	Дархан сум	Сумын *Хурлын* 10-р	3/14/2019	26	84

[8] 2014 оны 1-р сарын 6-ны өдрийн.
[9] Хүйсээр ангилсан мэдээлэл байхгүй.

		хуралдаан			
19		*Малчин* Багийн нийтийн хурал	2/27/2019	30 өрхөөс 1 иргэн	Хурал хүчинтэй байх ирцийн хувь хүрсэн
20		14-р Багийн нийтийн хурал	3/6/2019	58	Хурал хүчинтэй байх ирцийн хувь хүрсэн
21		13-р Багийн нийтийн хурал	3/6/2019	61	Хурал хүчинтэй байх ирцийн хувь хүрсэн
22	Хонгор сум	Олон нийтийн зөвлөлдөх уулзалт	2/26/2019	Тодорхой бус	Хурал хүчинтэй байх ирцийн хувь хүрсэн
23		Сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан	3/20/2019	7	100
24		1-р Багийн нийтийн хурал	3/6/2019	77	Хурал хүчинтэй байх ирцийн хувь хүрсэн
25		2-р Багийн нийтийн хурал	3/6/2019	50	
	Нийт			783	55-100%

Үр дүнг нь БОННҮ-нд тусгаж оруулах зорилгоор орон нутгийн захиргааны санал, зөвлөмжийг цуглуулж авахын тулд Төв аймгийн Баянчандмань сумын засаг дарга болон засаг даргын орлогч, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын засаг дарга, Төв аймгийн Борнуур сумын засаг дарга болон Төв аймгийн Жаргалант сумын засаг дарга нарт албан захидал илгээсэн. Албан ёсны зөвлөмжүүдийг сум бүрийн сумын Хурлын ээлжит чуулган ба Хурлын Тэргүүлэгчдийн 5 удаагийн хуралдаан, сумын Хурлын ээлжит 1 удаагийн ээлжит чуулган ба 4 удаагийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас тус тус илгээснийг хүлээн авсан.

2019 оны 2-р сараас 4-р сарын сар хүртэлх хугацаанд зохион байгуулсан олон нийтийг татан оролцуулах үйл ажиллагааны үеэр хөндөгдсөн гол асуудлуудыг дор харуулав. Үүнд:

- Замын дагуух ногоон орон зайтай болох, мөн хурд сааруулагч, сумын төвийн замын явган хүний гарц, мөн замын тэмдэг, тэмдэглэгээг замын барилгын үе шатанд нэмж бий болгох;
- Жаргалант сумын хувьд зорчигчид зогсож, хогоо хаях боломжгүй (одоогийн бодит байдал ийм) газарт хогийн сав байршуулах хүсэлтээ илэрхийлсэн;
- Бусад асуудлуудад барилгын явцад гарах тоосжилтыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай хүсэлтүүд багтсан; мөн
- Хэд хэдэн суманд үерийн ус зайлуулах хоолойг цэвэр ба бохир усны шугамын хамт барьж байгуулах хэрэгцээ шаардлага бий гэдгийг тэмдэглэсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын засаг дарга ЗТХЯ-ны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хандан санал хүсэлтээ албан ёсоор хүргүүлсэн байна. Үүнд:

- Сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон шинэчлэгдсэн замын хөдөлгөөний дүрэмд нийцсэн (замын тэмдэг тэмдэглэгээ) байдлыг хангах;
- Сумын дэд бүтэц (бохир усны шугам хоолой, цэвэр усны шугам, дулааны шугам хоолой татах);
- Шар усны гольдролыг өөрчлөх;
- Олон улсын авто замын стандартад нийцүүлэн зам дагуу 100км тутамд амрах цэг байгуулах; мөн
- Эргэн тойрны 50 гаруй дэлгүүр, зоогийн газар, кафе, засварын газрууд зэргийн орлого, бизнес хэвийн үргэлжлэх нөхцлийг хангах.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын засаг дарга ЭсИСи ХХК (БОННҮ-ний зөвлөх)-д илгээсэн албан захидалдаа (захиаг 2-р сарын 28-нд илгээсэн) сумын нутаг дэвсгэрээр дайрах хэсэгт түр зам байгуулах байршлын талаар хоёр санал дэвшүүлсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын засаг дарга ЭсИСи ХХК-д илгээсэн албан захидалдаа (захиаг 3-р сарын 18-нд илгээсэн) сумын одоогийн уулзвар дээр зогсох талбай төлөвлөхгүй байхыг хүсжээ. Одоогоор энэ цэгт хог хаягдаж, нийтийн бие засах газар байхгүйн улмаас орчин нь маш ихээр бохирдсон байна.

Дархан-уул аймгийн Хонгор сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас Байгал орчин, аялал жуулчлалын яам (БОННҮ-ний зөвшөөрлийг зохицуулдаг этгээд)-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар (ХБОБНУГ)-т илгээсэн албан захидалд (2019 оны 3-р сарын 21-нд илгээсэн, дугаар 38) зам дагууд байгуулах түр зогсоолын цэгүүдийн байршил, мал амьтны гарц гармын байрлал, хөдөө аж ахуйн буюу хүнд даацын машин тоног төхөөрөмжийн зам хөндлөн гарах гарцын байршлуудын талаарх саналаа уламжилжээ.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1 ба 2-р Багийн нийтийн хурлаас ХБОБНУГ-т хандан мал амьтны гарц гарам төлөвлөх, замын гэрэлтүүлэг, зохих тэмдэглэлээг сайтар хийх, түр замууд дээр тоос дарах арга хэмжээ авах тухай нутгийн иргэдийн саналыг уламжилсан байна.

Баянгол сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан БОННҮ-ний тайланг дэмжсэн (Шийдвэр #04, 2019 оны 3-р сарын 15); Гонир Багийн Нийтийн хурал, Баян Багийн Нийтийн хурал (Шийдвэр #02, 2019 оны 2-р сарын 20), мөн 1 дүгээр Багийн Нийтийн хурал (2019 оны 2-р сарын 20-ны өдрийн Шийдвэр) БОННҮ-г дэмжсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан БОННҮ-г хэлэлцэн дэмжсэн ба ЭсИСи-д өөрсдийн саналыг замын уулзваруудын байршлыг тэмдэглэсэн газрын зургийн хамт илгээжээ. Тэдний ирүүлсэн саналд сумын төвд хурд сааруулагч, мал амьтны гарц, замын зарим хэсгүүдийн дагууд гэрэлтүүлэг хийх, усны худаг барих, 52-ын даваанаас Хар Хошуу хүртэлх түр замыг услах, Чандмань, Замт, Эрдэнэ Багуудын Нийтийн хурлаас гарсан саналуудад дэмжлэг үзүүлэх тухай багтжээ.

Төв аймгийн Борнуур сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан БОННҮ-ний тайланг дэмжиж, 2019 оны 3-р сарын 20-ны өдрийн 36 тоот шийдвэрээ гаргажээ. Багийн Нийтийн хурлаар 1-р Баг (Шийдвэр #6, 2019 оны 2-р сарын 25), 2-р Баг (Шийдвэр #5, 2019 оны 2-р сарын 25), 4-р Баг (Шийдвэр #1, 2019 оны 2-р сарын 25) БОННҮ-ний тайланг дэмжсэн байна.

Дархан сумын Хурал БОННҮ-г хэлэлцээд тайланг дэмжсэн ба энэ тухай 2019 оны 3-р сарын 14-ний өдөр 10/06 тоот Шийдвэр гаргажээ. Үүнээс гадна, Малчин Баг (Шийдвэр #01, 2019 оны 2-р сарын 27), 14-р Баг (Шийдвэр #19/03, 2019 оны 3-р сарын 6), 13-р Баг (Шийдвэр #04, 2019 оны 3-р сарын 6) бүгд БОННҮ-ний тайланг дэмжсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2019 оны 3-р сарын 18-ны өдрийн 18 тоот Шийдвэртээ түр шороон замаас үүсэх тоос тариалангийн талбай болон хүсний ногоонд хэрхэн нөлөөлж болох талаар судалгаа хийж гарсан үр дүнг нь уг тайланд тусгах, мөн түр замуудыг хэрхэн нөхөн сэргээх (техникийн болон биологийн хувьд) ямар арга хэмжээнүүд авах тухай тайланд оруулахыг санал болгосон байна.

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг Багийн Нийтийн хурал 2019 оны 3-р сарын 13-ны өдрийн 1 тоот Шийдвэртээ БОННҮ-ний тайланг дэмжиж байгаагаа илэрхийлээд Тахилтын давааны зам дээр мал машинд мөргүүлсэн тохиолдол үе үе гардагийг харгалзан тэр хэсэгт мал амьтны гарц төлөвлөх хэрэгтэйг уг тайланд тусгахыг хүсжээ.

4.2. Тодорхойлогдсон асуудлуудын тойм

Ерөнхийдөө дээр танилцуулсан талуудын оролцоог хангах үйл ажиллагаануудын хүрээнд өнөөдрийг хүртэл тодорхойлогдсон асуудлуудыг нэгтгэн дараах байдлаар тоймлож болох юм. Үүнд:

- Хөдөлмөрийн бааз буюу кэмпэд амьдарч буй ажилчдын шилжилт хөдөлгөөн;
- Мал амьтан болон фермерүүдэд зориулсан гарц;
- Амьжиргаанд нөлөөлөх байдал (ажлын байрны боломж зэрэг эерэг нөлөөлөл болон барилгын ажлын үед үүсэх саад тотгор, тав тухгүй байдал зэрэг сөрөг нөлөөлөл);
- Болзошгүй бохирдол, жишээ нь усны (ялангуяа нутгийн оршин суугчид, малчдын ашигладаг эх үүсвэрт), хөрсний бохирдол, тоосжилт;
- Ургамлын аймаг болон амьтны аймагт хохирол, эвдрэл гэмтэл үүсгэх;
- Аялал жуулчлалд нөлөөлөх, дэд бүтэц, тухайлбал орон нутгийн эрүүл мэндийн төв, эмнэлгүүдийн үйл ажиллагаанд нөлөөлөх байдал;
- Малчид ба эмзэг бүлгийн хүн амд нөлөөлөх байдал;

- Замын тэмдэг тэмдэглэгээ, хурдны хяналт, аюулгүй байдлын тоноглол, дэд бүтцийг сайжруулах;
- Ядмаг төлөвлөлт, зогсох хэсгүүдэд хог хагдлын цэг байдаггүй зэргээс шалтгаалан зам дагууд үүсэх хогны асуудал;
- Замын тогтмол засвар арчлалт;
- Үер ба ус зайлуулах системд нөлөөлөх байдал; болон
- Замын барилга угсралт, ашиглалтын үеийн олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал.

4.3. Цаашид санал болгож буй үйл ажиллагаанууд

Цаашид талуудын оролцоог хангах чиглэлд АХБ-ны БОНАШҮ-нээс дараах шаардлагуудыг тодорхойлж гаргасан. Үүнд:

- Хэрэгжилтийн үед ТХН нь төслийн төлөвлөлтийн дагуу хамгийн багадаа хоёр удаа зөвлөлдөх ярилцлага зохион байгуулна. Эхнийхийг нь барилгын ажил эхэлснээс хойшхи 6-8 долоо хоногийн хугацаанд багтаан хийх бол дараагийнхыг нь барилгын ажил дуусгавар болохоос өмнө зохион байгуулна. Энэ талаар АХБ-ны БОНАШҮ-ний Байгаль орчны мониторингийн төлөвлөгөөнд тусгасан.
- Хэрэгжилтийн явцад нөлөөнд өртсөн иргэд олон нийттэй хийх албан бус уулзалт ярилцлага нь барилгын үйл ажиллагаанаас үүсч бий болсон барилгын дуу чимээ, тоос, хатуу хог хаягдал, бохир ус зэрэг олон нийтийн тав тухыг алдагдуулж, садаа болж буй байдлын талаарх иргэд оршин суугчдын гомдол санал, мөн экологийн хамгаалалт, хөрс/газрын асуудал болон тухайлбал цас ихээр орсны улмаас зам ашиглахад хүндрэл гарах гэх мэт нэвтрэх боломжийн хувьд үүсэх бэрхшээлүүдэд голлон анхаарна.

Төслийн 2-р үе шатны ажилд зориулан хийсэн БОННҮ-гээр тодорхойлогдсон цаашдын талуудын оролцоог хангах үйл ажиллагаануудад Төслийн Байгаль Орчин, Нийгмийн Удирдлага болон Мониторингийн Төлөвлөгөө (БОНУМТ)-ний хэрэгжилтийн талаар жил тутам тайлагнах, барилгын үйл явц, өргөдөл гомдлын нөхцөл байдлын талаарх тайлан илтгэлийг сумдад жил хоёр удаа, нутгийн иргэд, оршин суугчид болон Багуудад жилд нэг удаа хүргэх ажлууд багтана.

5. Оролцогч талуудыг тодорхойлох нь

5.1. Танилцуулга

Талуудын оролцоог үр өгөөжтэй байлгахын тулд талуудыг зөв тодорхойлох, тэдний эрэлт, хэрэгцээ, хүлээлт болоод Төсөлтэй холбоотойгоор тодорхойлсон тэргүүлэх чиглэл, хүрэхийг хүсч буй зорилго зэргийг ойлгох нь нэн чухал. ТОХТ-ний энэ бүлэгт ЕСБХБ-ны ГШ 10-д заасан шааардлагын дагуу Төслийн оролцогч талуудыг бие даасан хувь этгээд эсвэл бүлэг этгээд эсэхээс хамааран дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

(i) Төслийн нөлөөнд өртсөн, эсвэл өртөж болзошгүй (шууд буюу шууд бусаар) (нөлөөнд өртөж байгаа талууд); эсвэл

(ii) Төслийн үйл ажиллагааг сонирхож байгаа этгээд (бусад сонирхож байгаа талууд).

5.2. Оролцогч талуудыг тодорхойлох арга барил

Оролцогч талуудыг тодорхойлох нь байнгын хяналт шалгалт, шинэчлэлийг шаарддаг тасралтгүй үйл явц юм. 2019 оны 5 дугаар сард Аткинс ба СИЭ (Састайнабилити Ийст Эйжия) ХХК-аас хийсэн хийдлийн анализаас үзвэл үндэсний хэмжээнд мөрдөх талуудын оролцоог хангах стандартыг хангаж байгаа боловч ЕСБХБ-ны талуудын оролцоотой холбоотой шалгуур үзүүлэлтийг биелүүлэхэд нэлээд цоорхой буюу хийдэл байгааг тогтоосон байна.

Тийм учраас дээр дурдсан хоёр төрлийн оролцогч талыг тодорхойлсон заалтыг ашиглан, бусад оролцогч талуудыг Төслийн оролцогч талуудад учирч болзошгүй нөлөөлөл, түүнд өртөх магадлалыг харгалзан Төслийн үр нөлөөг хүртэх, өртөх сонирхогч ямар ямар талууд байж болохыг тодорхойлсон бөгөөд ингэснээр тэдний оролцоонд уялдуулан мэдээлэл хүргэх, тэднийг үзэл бодол, асуудал бэрхшээлээ илэрхийлэх боломжоор хангах нөгөө талаас тэднийг ойлгож, мэдэх зохистой нөхцлийг бүрдүүлсэн юм. Өөрөөр хэлбэл өөрийн сул тал болон эмзэг байдлын улмаас Төслийн үр нөлөөнд ялгаатай эсвэл зүй бусаар өртөж болзошгүй хувь хүмүүс болон бүлгийг тодорхойлох, эсвэл эдгээр хувь хүмүүс болоод бусад оролцогч талууд орхигдох, эсвэл оролцох боломжгүй нөхцөлд үндсэн чиглэлийн зөвлөлдөх уулзалт эсвэл бусад төрлийн тусгайлсан арга хэмжээ, тусламж дэмжлэг үзүүлэх зэргийг энд багтаасан болно.

Төслийн бусад үе шатанд оролцогч талуудыг тодорхойлж болох тул энэхүү ТОХТ-д багтсан жагсаалтыг шаардлагатай үед шинэчилнэ. Оролцогч талуудын жагсаалтыг бэлтгэсэн (доороос үзнэ үү) бөгөөд төслийн мөчлөгийн туршид тогтмол шинэчлэгдэж байх ёстой. Оролцогч талуудын бүлэг тус бүрт хамаарах эрсдэл өөрчлөгдөж болох учраас шаардлагатай үед үнэлгээг дахин хийнэ. Төслийн оролцогч талуудын төслийн дараагийн үе шатанд тодорхойлохдоо төслийн хэрэгжилтийн турш үе үе давтагдах өргөдөл гомдол гаргах нэгдсэн процедуртай хамтатган зохион байгуулна. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаа, нөлөөллийн цар хүрээг тодорхойлсны дагуу авч үзэх;
- Төслийн боломжит үр нөлөө болон өнөөгийн эерэг болон сөрөг нөлөөний цар хүрээг харгалзан ;
- Төслийн холбогдох төрийн байгууллагууд, иргэний нийгэм, бизнесийн бүлгүүдтэй холбоо тогтоох; болон
- Төслийг сонирхож буй, эсвэл сонирхох магадлалтай байгууллагуудтай холбоо тогтоох.

Оролцогч талуудын жагсаалтыг барилгын үе шат эхлэх болон ашиглалтын үе шат эхлэхээс өмнө шинэчлэн боловсруулах нь хамгийн наад захын шаардлага болно.

5.3. Оролцогч талуудыг тодорхойлох ба шинжлэн дүгнэх

Оролцогч талуудын жагсаалтыг Хүснэгт 5.1-д үзүүлэв. Талуудтай үр дүнтэй хамтран ажиллах хамгийн оновчтой арга замыг үнэлэх, тэдний хувьд ямар мэдээлэл хамгийн эрэлт хэрэгцээтэйг ойлгох, тэдний ашиг сонирхол, нөлөөг илрүүлэх зорилгоор Төслийн хэрэгжилтэнд оролцогч талуудын үзүүлэх нөлөөлөл буюу ашиг сонирхол, тэдний төслийн нөлөөнд өртөх байдлыг тодорхойлсон оролцогч талуудын дүн шинжилгээг хийсэн болно.

5.4. Эмзэг бүлгүүд

Оролцогч талуудыг тодорхойлох арга хэмжээ, өнөөг хүртэл зохион байгуулсан олон нийтийн зөвлөлдөх үйл ажиллагаа, нэмэлт БОННҮ-г Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор буй болж болзошгүй нөлөөнд бусад бүлгээс илүү өртөх магадлалтай бүлэг хүмүүс байгаа эсэхийг судлахаар хийсэн болно. Энэхүү ТОХТ-г бэлтгэх явцад бүлгүүдийг нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, бие махбодийн болон оюуны бэрхшээл буюу эсвэл бусад онцлог шинж чанараас шалтгаалан Төслийн нөлөөнд өртөж болох эсэхийг тодорхойлж, үнэлсэн болно. Үнэлгээгээр дараах хувь хүн болон бүлгийг Төслийн нөлөөнд эмзэг өртөмхий байх магадлалтай гэж тодорхойлсон байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс;
- Ахмад настан;
- Эмэгтэйчүүд;
- Хүүхэд;
- Малчид;
- Биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртөх бизнес эрхлэгчид (жишээ нь, эмэгтэйчүүдийн эзэмшилд байдаг хүнсний ногооны лангуу гэх мэт).

Хүснэгт 5-1. Тодорхойлогдсон оролцогч талууд, үр нөлөө, ашиг сонирхол ба нөлөөлөл

Оролцогч талууд	Хувь хүн ба бүлгүүд	Үр нөлөө / Ашиг сонирхол / Нөлөөлөл
Үр нөлөөнд өртөх талууд		
Өртөх хүмүүс/ олон нийт	Газар чөлөөлсний улмаас хохирох хүмүүс ба өмчлөгчид	**Үр нөлөө**. Төслийн улмаас өмчлөгчдийн өмчийн эрх эсвэл өмч нь түр эсвэл бүрмөсөн өртөх. Өмчийг нүүлгэн шилжүүлэх боломж муутай. Төслийн зүгээс хийх эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртөх хүмүүс ба бизнес эрхлэгчид (түр эсвэл бүрмөсөн). Барилгын ажлын үеэр малчид, жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийг нүүлгэн шилжүүлэх боломж бага. Ашиглалтын явцад малчдын зам хөндлөн гарах боломж байнга өөрчлөгдөх.
	Төсөл хэрэгжиж байгаа газар нутагт нөлөө үзүүлэх орон нутгийн иргэд: ▪ Малчид ▪ Газар тариалан эрхлэгчид ▪ Хот, суурингийн иргэд	**Үр нөлөө**. Байгаль орчны чанарын асуудал (тав тух алдагдах, таагүй байдал үүсэх зэрэг ерөнхий байдлаас гадна зам харгуй хаагдах, нэвтрэх боломжгүй болох, дуу чимээ ихсэх, тоос шороо босох), барилга угсралт, ашиглалтын үе шатан дахь хувь хүний болон мал сүргийн аюулгүй байдал; ажлын байр бий болох зэрэг эдийн засгийн бусад үр ашигтай байдал үүсэх.
	Төсөл хэрэгжиж байгаа газар нутагт нөлөө үзүүлэх орон нутгийн бизнес эрхлэгчид: ▪ ШТС ▪ Ресторан /Хоолны газрууд ▪ Зочид буудал ▪ Дэлгүүр ▪ Машин засварын газрууд ▪ Бие засах газар ▪ Ногооны лангуу	**Үр нөлөө**. Барилгын ажлын үед байгаль орчны аюулгүй байдал, чанарын асуудал (тав тух алдагдах, таагүй байдал үүсэх зэрэг ерөнхий байдлаас гадна зам харгуй хаагдах, нэвтрэх боломжгүй болох, дуу чимээ ихсэх, тоос шороо босох), Орлого буурах эрсдэл үүсэх магадлалтай боловч барилгын ажил хийж орлогоо нэмэгдүүлэх боломж үүснэ. Ашиглалтын үе шатанд ашиг орлого нэмэгдэнэ.
	Эмзэг хувь хүмүүс болон бүлгүүд	**Үр нөлөө**. Эмзэг бүлгийн хүмүүст Төслийн зүгээс зүй бусаар нөлөөлөх магадлал үүсэж болзошгүй. Үүнд: байгаль орчны чанар, газар/өмчөө чөлөөлөх, нөхөн олговор авах, барилга угсралт болон ашиглалтын үед хүн, малын аюулгүй байдал алдагдах; ажлын байр бий болж, эдийн засгийн бусад үр ашиг нэмэгдэнэ.
	Замаар зорчигчид (хувь хүмүүс, бизнес эрхлэгчид)	**Үр нөлөө.** Барилгын ажлын үеэр одоо ашиглаж байгаа замын зарим хэсэгт зорчих, нэвтрэхийг хязгаарлах магадлал их байна. Ашиглалтын үеэр замын нөхцөл байдал сайжирна.

Оролцогч талууд	Хувь хүн ба бүлгүүд	Үр нөлөө / Ашиг сонирхол / Нөлөөлөл
Аймаг, сумын иргэдийн хурал	Орон нутгаас сонгогдсон иргэдийн төлөөлөгчид: ▪ Сум ▪ Аймаг	**Үр нөлөө**. Орон нутгаас сонгогдсон иргэдийн хурлын төлөөлөгчид нь сонгогдсон тойрогоо хариуцсан байдаг учраас шууд бусаар Төслийн үх нөлөөнд өртөнө гэж үзсэн. Тиймээс эдгээр төлөөлөгчид Төслийн үйл ажиллагаа болон түүнээс болж бий тойрогт бий болох үр нөлөөг сонирхож байгаа юм. **Ашиг сонирхол**. Зөвшөөрөл олгох, статистикийн тайлан, хамгаалалтын төрөл бүрийн бүс тогтоох. БОНН-той холбоотой удирдлагын үйл ажиллагааг аймаг, сум болон багийн засаг дарга нар болон ИТХ удирдана.
Аймаг, сумын төр, захиргааны байгууллагууд	Аймаг, сумын ЗДТГ: ▪ Засаг дарга ▪ Нийгмийн ажилтан ▪ БО байцаагч Шуурхай алба: ▪ Цагдаагийн ажилтнууд ба цагдаагийн газрууд	**Ашиг сонирхол**. Аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнийг зохицуулах үүрэгтэй. **Нөлөөлөл.** ЗТХЯ-ы нэрийн өмнөөс нүүлгэн шилжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ. Орон нутгийн иргэдийг ажиллах боломжоор хангах..
Сонирхож байгаа талууд		
Төслийн үр шимийг хүртэгсэд	▪ ЗТХЯ ▪ Төсөл хэрэгжүүлэх баг	**Нөлөөлөл.** Төслийн оролцогч талуудыг тодорхойлох, Төслийг хэрэгжүүлэх, гэрээ гүйцэтгэгчдийг удирдах үүргийг хүлээнэ.
Санхүүжүүлэгч байгууллагууд	▪ ЕСБХБ ▪ АХБ	**Нөлөөлөл.** Төслийн үйл ажиллагааг байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн шаардлагад нийцэж байгааг эсэх, санхүүгийн зарцуулалтад хяналт тавих замаар оруулж байгаа хөрөнгө оруулалтын эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах ашиг сонирхолтой, нөлөө үзүүлэх этгээд
▪ **Гүйцэтгэгчид**	▪ Дизайны компани ▪ Зам, барилга болон засварын ажил гүйцэтгэгчид	**Ашиг сонирхол.** Төсөлд бараа, үйлчилгээ нийлүүлэх слнирхолтой. **Үр нөлөө.** Ажлын байртай болох, сургалтанд хамрагдах, эрүүл мэнд, аюулгүй байдлаа сайжруулах боломж
Ажилтнууд	▪ Ажилчид ▪ Ажил олгогчийн төлөөлөгч	**Ашиг сонирхол.** Барилгын ажлын үед ажил олгогчид, бараа нийлүүлэгчидтэй хамтран ажиллах шууд эрэлт бий болно. **Үр нөлөө.** Ажлын байртай болох, сургалтанд хамрагдах, эрүүл мэнд, аюулгүй байдлаа сайжруулах боломж
Төрийн захиргааны холбогдох	▪ Яамд болон газрууд	**Ашиг сонирхол.** Төслийн тухай мэдээллийг орон нутгийн засаг, захиргаанд мэдээлэх үндсэн эх сурвалж байх.

Оролцогч талууд	Хувь хүн ба бүлгүүд	Үр нөлөө / Ашиг сонирхол / Нөлөөлөл
байгууллагууд		**Нөлөөлөл.** Бодлого тодорхойлох, зөвшөөрөл олгох, Төслийн заавар, журмыг батлах, төслийн хэрэгжилтийн туршид үндэсний хууль тогтоомжийг мөрдөхийг шаардах зэрэг Төслийг журамлах эрх бүхий, нөлөө бүхий этгээд
Орон нутгийн үйлчилгээ	▪ Эрүүл мэндийн төвийн ажилтнууд ▪ Нийгмийн ажилтнууд	**Ашиг сонирхол**. Аюулгүй байдлыг хангах – зам тээврийн осол ихтэй, ослын хохирогч нь ихэвчлэн хүүхэд, багачууд байдаг. Мөн тэдний санаа зовоож байгаа зүйл нь хүүхэд, настай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зам гарахад их хүндрэлтэй байгаа явдал юм. Бас нэг хүндрэл бол мал сүрэгтэй холбоотой ослын менежмент байна. Барилгын ажил болон ашиглалтын явцад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний олдоц, хүртээмжийн асуудал.
Боловсролын байгууллагууд	Орон нутгийн сургуулиуд: ▪ Бага дунд ▪ 10 жилийн сургуулиуд Боловсрол, сургалтын байгууллагууд: ▪ Их сургууль, эсвэл коллеж	**Ашиг сонирхол**. Тэдний хувьд хамгийн их санаа зовоож байгаа асуудал бол зам тээврийн осол их гарч, ослын хохирогч нь ихэвчлэн хүүхэд, багачууд байдаг явдал юм. Мөн хүүхэд, настай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зам гарахад их хүндрэлтэй байдаг. Мал сүрэг машинд дайрагдах нь их байна.
Олон нийт	МУ-ын нийт хүн ам	**Ашиг сонирхол**. Улс орны хөгжил, замын нөхцөл байдал сайжрах.
Бизнесүүд /ханган нийлүүлэгчид	▪ Орон нутгийн зам арчилгааны компаниуд ▪ ХАА-н компаниуд ▪ Замын хураамжийн цэгүүд	**Нөлөөлөл.** Барилгын ажлын үеэр бараа нийлүүлэх эрэлт. Зам ашиглалтын үед зам тээврийн хөдөлгөөн нэмэгдсэнээр ашиг, орлого өсөх.
Төрийн бус байгууллагууд / Орон нутгийн байгууллагууд	▪ Орон нутгийн ТББ болон ОНТББ-ууд ▪ Үндэсний ТББ болон ИНБ	**Ашиг сонирхол.** Байгаль орчин, нийгмийн чиглэлээр ажилладаг ТББ-ууд – Төслийн хамтрагчид. **Нөлөөлөл.** Нөлөөллийн үйл ажиллагаа.
Дэд бүтэц	▪ Ус ▪ Цахилгаан ▪ Мэдээлэл, технологи	**Үр нөлөө**. Барилгын ажлын үеэр ус, цахилгааны хэрэгцээ гарна. Замын дагуух үйлчилгээг нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсэх магадлалтай. **Нөлөөлөл.** Ажил/нийлүүлэлтийн зөвшөөрөл.
Хэвлэл мэдээлэл	▪ Сонирхсон хэвлэл мэдээллийн байгууллагууд	**Ашиг сонирхол.** Төсөл хэрэгжиж байгаа газарт явагдаж байгаа хамаарал бүхий үйл ажиллагаа, үр нөлөөний менежментыг сонирхож байгаа. Хэвлэл мэдээлэл нь Төслийн зүгээс сонирхож талуудтайгаа харилцаа холбоо тогтоох, форум бий болгох чиглэлээр ажиллах хамгийн боломжит хамтрагч.

Оролцогч талууд	Хувь хүн ба бүлгүүд	Үр нөлөө / Ашиг сонирхол / Нөлөөлөл
		Нөлөөлөл. Төслийн тайланд төслийн хөгжил, үйл ажиллагааны талаар олон нийтэд нийцтэй, уншуурТай байх асуудлыг хариуцаж, төслийн тухай олон нийтийн санаа бодолд нөлөө үзүүлэх.
Аж үйлдвэрийн салбарын байгууллагууд	▪ Барилга, дэд бүтцийн худалдааны этгээдүүд ▪ ҮЭ-ийн байгууллагууд	**Үр нөлөө** Тэдний үйл ажиллагаанд учирч болзошгүй нөлөө (хуримтлагдсан байдлаар мөн орно). Цомхотгол, сургалт, эрүүл мэнд, аюулгүй байдал, цагаач ажилчид гэх мэт асуудлууд, нөхөн олговор. **Ашиг сонирхол.** Бизнесийн боломжууд.

6. Нэмэлт оролцоог хангах нь

6.1. Танилцуулга

ЕСБХБ-ны шаардлагыг хангах зорилготой БОНҮ-ний хүрээнд СИЭ ХХК нь талуудын оролцоог хангах арга хэмжээг 5-р сарын 5-наас 8-ны хооронд хэрэгжүүллээ. Эдгээр арга хэмжээний гол зорилго нь Дархан-Уул аймгийн нийгмийн нөхцөл байдлын талаарх сүүлийн үеийн мэдээлэл, ойлголтыг авах,Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Төв аймгийн Баянчандмань, Борнуур, Жаргалант сумд, Дархан-Уул аймгийн Хонгор сумын тухай нарийвчилсан мэдээ, мэдээлэл цуглуулах байлаа.

Нэмэлт зөвлөлдөөн, ялангуяа эмзэг бүлгийнхэнд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага байгаа нь 2019 оны 5 дугаар сард хийгдсэн хийдлийн шинжилгээгээр гарсан тул 2019 оны 5 дугаар сард зохион байгуулсан талуудын оролцоог хангах арга хэмжээ нь эмзэг бүлгийн өртөмхий бүлгийн иргэд олон нийт, түүний дотор малчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмэгтэйчүүд, хүүхдүүд, ахмад настан, эрүүл мэндийн төв, бизнес эрхлэгчдэд голлон анхаарсан.

Санал болгож буй автозамын маршрутын дагуу фокус бүлгийн ярилцлага (ФБЯ) болон гол мэдээлэгчийн ярилцлага (ГМЯ) зохион байгуулж, эмзэг бүлгүүдийг тодорхойлох, баталгаажуулах ажлыг хийлээ.

6.2. Фокус бүлгийн ярилцлага

Хүснэгт 6-1-д хураангуйлан харуулсны дагуу ФБЯ-ыг эмэгтэйчүүд, өндөр настнуудын дунд зохион байгууллаа. Нийтдээ дөрвөн удаагийн ФБЯ зохион байгуулснаас Сэлэнгэ аймгийн Баянгол суманд 2 удаа, (2019 оны 5 дугаар сарын 6-нд), Төв аймгийн Баянчандмань суманд 2 удаа (2019 оы 5 дугаар сарын 8-нд) боллоо. Баянгол сумын ФБЯ-д 12 эмэгтэй оролцсон бол мөн тооны эмэгтэйчүүд Баянчандмань суманд зохион байгуулсан ФБЯ-д оролцсон байна. Баянгол суманд зохион байгуулсан ФБЯ-д арван өндөр настан оролцсон бол Баянчандмань сумын ФБЯ-д зургаан өндөр настан оролцжээ. талуудад тавьсан асуултуудыг Хавсралт А-д оруулсан болно.

6.3. Гол мэдээлэгчийн ярилцлага

Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор газар чөлөөлөх, дахин төлөвлөх үйл явцад түүний үр нөлөөнд өртөнө гэж тодорхойлсон талууд, тухайлбал аймаг сумын албан хаагчид, эрүүл мэндийн төвийн ажилтнууд, замын төлбөр хураах цэгүүд, төмөр замын ажилтнууд, цагдаа, түргэн тусламжийнхан, бизнес эрхлэгчид, өмчийн эзэд, малчид болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ГМЯ хийсэн байна. ГМЯ-ын хураангуйг Хүснэгт 6-1-д харууллаа. талуудад тавьсан асуултыг Хасралт-А оруулсан болно.

Хүснэгт 6-1. Оролцогч талууд болон оролцоог хангах аргачлалын хураангуй

#	Оролцогч талын бүлгүүд	Байршил / Хүний Тоо						Оролцоог хангах арга
		Төв аймгийн Баянчандмань сум	Төв аймгийн Борнуур сум	Төв аймгийн Жаргалант сум	Сэлэнгэ аймгийн Баянгол сум	Дархан-Уул аймгийн Хонгор сум	Дархан-Уул аймаг	
1.	Аймаг, Сумын ЗДТГ: - Нийгмийн ажилтан - Байгаль орчны байцаагч	1			5	2		ГМЯ
2.	Орон нутгийн сургуулийн нийгмийн ажилтнууд, эрүүл мэндийн төвийн ажилтнууд				4	2	3	ГМЯ
3.	Цагдаагийн газар/Төслийн зам дагуу байрлаж байгаа цэгүүд				2		4	ГМЯ
4.	Гал команд				3			ГМЯ
5.	Орон нутгийн зам засвар арчлалтын компаниуд							ГМЯ

#	Оролцогч талын бүлгүүд	Байршил / Хүний Тоо						Оролцоог хангах арга
		Төв аймгийн Баянчандмань сум	Төв аймгийн Борнуур сум	Төв аймгийн Жаргалант сум	Сэлэнгэ аймгийн Баянгол сум	Дархан-Уул аймгийн Хонгор сум	Дархан-Уул аймаг	
6.	Замын төлбөр хураах цэгүүд	1					3	ГМЯ
7.	Төмөр замын ажилтнууд (ажилчид)	2			1		1	ГМЯ
8.	ХАА-н компаниуд		1		2	1		ГМЯ
9.	Замын дагуу бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчид (ШТС, зоогийн газар, гуанз, зочид буудал, дэлгүүр, машин засварын газар, амралт сувилал, амьтны хүрээлэн гэх мэт…)	4	3		4		4	ГМЯ
10.	Тусгай хэрэгцээтэй хүмүүс				2	3		Ярилцлага
11.	Өндөр настан	6			10			ФБЯ
12.	Эмэгтэйчүүд/хүүхэд	12			13			ФБЯ/ярилцлага
13.	Малчид		2	4	1			Ярилцлага
	НИЙТ	26	6	4	47	8	15	

6.4. Үр дүнгийн хураангуй

Хүснэгт 6-2-т харуулсан хураангуй мэдээллээс үзвэл Талуудын арга хэмжээнд оролцсон хүмүүсийн санаа зовж байгаа асуудал, бэрхшээл хоорондоо нэлээд төстэй байгаа нь харагдаж байна. Хамгийн гол асуудал нь шинэ замын барилга угсралт болон ашиглалтын үе шатны замын аюулгүй байдалтай холбоотой асуудал байв. Хүмүүсийн дунд хамгийн түгээмэл яригдаж буй гол сэдэв нь тээврийн хэрэгслүүд заасан хурдны хязгаарыг хэтрүүлэх, замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөний улмаас зам тээврийн осол их хэмжээгээр гарч байгаа тухай байлаа. Зам тээврийн ослын гол хохирогчид хүүхэд, мал байдаг учраас цаашид явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах талаар илүү анхаарах нь зүйтэй гэсэн саналыг олон оролцогчид илэрхийлсэн байна. Аюулгүй байдлыг хангах гэдэгт явган хүний зам, явган зорчигчийн зам гарах гарцны хэсэгт гэрэл дохио байрлуулах, явган зорчигч, малд зориулсан нүхэн гарц, хурд сааруулагч хийх, гудамжны гэрэл гэрэлтүүлэг, замын тэмдэглэгээг нэмэгдүүлэхийг дурджээ.

Замыг барих ажлын үеэр тоос шороо босох, барилгуудыг нүүлгэн шилжүүлэх, бэлчээр болон хөдөө аж ахуйн эдэлбэр газарт хохирол учрах, тухайн сумаар дамжин өнгөрөх аянчдын тоо буурсны улмаас ашиг орлого буурах, явуулын ажилчдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор хүүхдийн аюулгүй байдалд заналхийлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настнууд болон эмэгтэйчүүдэд тулгарах бэрхшээл улам нэмэгдэх талаар оролцогчид санаа зовниж байгаагаа илэрхийлсэн байна.

Бүх оролцогчид замын өнөөгийн байдал зорчиход аюултай, завсарлах шаардлагатай гэдэг дээр санал нэгджээ. Шинээр барих зам нь олон улсын стандартад нийцсэн, оршин суугчид болон явган зорчигчдын аюулгүй байдлыг илүү хангасан, зам тээврийн ослыг бууруулахад дэмжлэг болох тусгаарлагч суурилуулах, эгнээ хоорондын заагийг сайжруулах замаар эсрэг чиглэлд аюулгүй зорчих нөхцлийг хангана гэж итгэж байгаагаа илэрхийлсэн байна.

Хүснэгт 6-2. Оролцогч талуудтай холбоотой тодорхойлогдсон асуудлуудын тойм

Оролцсон Талууд	Оролцогч талуудаас дэвшүүлсэн асуудал, бэрхшээл
Аймаг/сумын албан хаагчид	• Зам тээврийн ослын гаралт, тохиолдол их; • Тухайн хот, суурингийн явган зорчигчид зам гарах гарц, тэмдэглэгээ байхгүй, гэрэлтүүлэг муу; • Олон айлууд малтай бөгөөд өглөө, оройдоо заавал зам гарах хэрэгтэй болдог. Тээврийн хэрэгсэл мал дайрах, гэмтээх тохиолдол маш олон удаа гарсан; • Барилга, байгууламжийг нүүлгэн шилжүүлэх, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зардал; • Түр зам тавиҳдаа тоос шороо багасгах, зөвшөөрөлгүй зам гаргахаас сэргийлэх зэрэг арга

Оролцсон Талууд	Оролцогч талуудаас дэвшүүлсэн асуудал, бэрхшээл
	хэмжээг авсан байх; • Шинээр барих зам олон улсын стандартад нийцсэн, явган зорчигчдын аюулгүй байдлыг хангахад илүү анхаарсан байгаасай гэсэн хүсэл.
Эрүүл мэндийн төв/байгууллагын ажилтнууд	• Хэт олон зам гаргасан, зам тээврийн осол их гардаг; • Сумын эрүүл мэндийн төсвийн ихэнх хэсэг нь байнгын оршин суугч бус иргэний зам тээврийн ослын зардалд зарцуулагддаг; • Жолооч нарын хурдыг сааруулах арга хэмжээ авснаар зам тээврийн ослыг бууруулах; • Зам тээврийн ослын гаралт намрын ургац хураалтын үе болон өвлийн цагт нэмэгддэг; • Өндөр настан, хүүхдүүд болон тусгай хэрэгцээтэй иргэд зам гарахад маш хүндрэлтэй байдаг; • Төв суурин газартаа явган зорчигчид зориулсан зам тавихыг хүссэн ба орон нутгийн оршин суугчдын зорчих аюулгүй орчин бүрдүүлэхийн тулд гэрэл дохио, замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулахыг хүссэн байна; • Зам гарах мал/амьтанд зориулсан гарц хийж, мал/машин мөргөлдөх, дайрагдахаас урьдчилан сэргийлэх.
Замын хураамжийн цэг болон төмөр замын ажилтнууд	• Зарим жолооч нар замын хураамжаа төлдөггүй, зарим нэг нь замын чанар ийм муу хэмээн гомдоллож, төлөх шаардлагагүй гэж үздэг; • Машинууд төмөр замын дэр мод, хөндлөн блокыг дайрч хохирол учруулдаг; • Зам нарийхан учраас урт цуваа үүсгэх эсвэл эсрэг урсгалд байгаа машинуудад хүндрэл үүсгэдэг; • Төмөр замын гарц хаагдсан үед зарим тээврийн хэрэгсэл нэвтрэн орж, ирж байгаа галт тэрэгт дайрагдах шахдаг; • Олон улсын стандартыг мөрдөх нь замыг сайжруулж, галт тэрэг зам хөндлөн гарах шаардлагагүй болно; • Зөвхөн замын хажуу гэлтгүй бусад хэсэгт ч гэсэн мал гарах гарц, замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах шаардлагатай байна.
Цагдаа болон онцгой байдлын ажилтнууд	• Хурд хэтрүүлэх, зам тээврийн дүрэм, журмыг зөрчсний улмаас их хэмжээний зам тээврийн осол гарахад хүргэж байна; • Замын тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй байна; • Стандартын хурд сааруулагч, явган зорчигчийн гарц байхгүй байна; • Тээврийн хэрэгслийн тоо өсөж, хяналт тавих боловсон хүчин хангалтгүй байна; • Мал/тээврийн хэрэгсэл мөргөлдөх тохиолдол нийт зам тээврийн ослын 10%-ийг эзэлдэг; • Замын дагуу 20 км тутамд түр амрах цэгийг байршуулна уу; • Замыг олон улсын стандартын дагуу аль болох нугарал багатай барих.
Нөлөөнд өртсөн бизнес эрхлэгчид болон ажилчид	• Одоо ашиглаж байгаа зам нь эвдрэл ихтэй, чанар муутайгаас шалтгаалан зам тээврийн осол их гарч байна; • Мал/амьтан тээврийн хэрэгсэлд мөргүүлэх, дайруулах осол их гарч байна; • Оршин суугчид, хүүхдүүдэд зориулсан зам гарах гарц, тэмдэг тэмдэглэгээ, гэрлэн дохио огт байхгүй; • Замын ажил эхэлснээс болж орлого буурах, ажлын байраа алдах байх гэж түгшиж байна; • Шороо тоос босох, түр зам дээр гарах зам тээврийн осол болон оройн цагаар үзэгдэх орчин хязгаарлагдснаас болж мөргөлдөх вий гэж санаа зовниж байна.
Малчид	• Мал бэлчээрт гарах эсвэл ус уух гэж зам гарч яваад тээврийн хэрэгсэлд дайруулах, мөргүүлэх нь их байна; • Тээврийн хэрэгсэл хурдтай зорчиж байна; • Мал зам хөндлөн гарахад зориулсан нүхэн гарц одоогийн байдлаар байхгүй; • Замын дагуу хашаа, хайс барьж зам уруу мал нэвтрэхээс сэргийлэх, мал зам гарахад зориулсан нүхэн гарцыг байгуулах талаар бодолцмоор байна; • Түр замыг малын бэлчээр дундуур тавих нь бэлчээр эвдэж, доройтуулж болох юм.
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс	• Жолооч нар явган зорчигчдод зам тавьж өгдөггүй тул замын ойролцоо явах эсвэл зам гарах нь маш хүндрэлтэй байдаг; • Түр тавьж байгаа замаар зорчиход хүндрэлтэй, шороо тоос ихэсгэнэ; • Сайн ажилладаг гэрлэн дохио суурилуулах, явган зорчигчдод зориулсан хатуу хучилттай зам тавих, зам гарах гарц, тэмдэг хийхийг хүсэж байна.
Сургуулийн ажилтнууд	• Цагдаа явган зорчигчдыг зохицуулж зам гаргах боловч байнгын зохицуулалт байхгүй; • Хурд сааруулагчийг стандартын дагуу хийгээгүй учраас зам тээвэр осол бууруулах бус осол гарах шалтгаан болж байна; • Замыг нөхцлийг сайжруулах гэдэгт гэрлэн дохио, гудамжны гэрэлтүүлэг, замын тэмдэг, тэмдэглэгээ, явган зорчигчийн гарц, кодын дагуу байгуулсан хурд сааруулагч зэргийг багтаан ойлгоно; • Хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангахын тулд барилгын ажлын талбай оршин суугчдын байрлаж байгаа газар хоёрыг салгах шаардлагатай.

Оролцсон Талууд	Оролцогч талуудаас дэвшүүлсэн асуудал, бэрхшээл
Эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ (Баянгол сум)	• Эмэгтэйчүүд машин барихын оронд ихэвчлэн алхдаг; • Оршин суух газар нь замын урд талд харин ихэнх үйлчилгээ замын хойд талд байдаг. Тиймээс ямар нэг үйлчилгээ авахын тулд зайлшгүй зам гарах шаардлагатай болдог; • Ихэнх машинууд маш их хурдтай явдаг; • Гэрлэн дохио, гудамжны гэрэл, явган хүний зам зэрэг зүйл байхгүй. Явган зорчигчийн зам гарах гарц, замын тэмдэг, тэмдэглэгээ маш хангалтгүй; • Зам тээврийн ослын хохирогчдын ихэнх нь хүүхэд, мал байдаг; • Түр замаас босох тоос шороо болон барилгын ажлын үед хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хэрхэн явагдах талаар санаа зовниж байна; • Сумын хүмүүст төлөвлөсөн замын ажлын тухай мэдээлэл сайн хүрч амжаагүй байна; • Өмнөх туршлагаас үзэхэд замын ажилчид охид бүсгүйчүүдийг хоргоож, өдөх нь их байдаг учраас санаа зовж байна; • Эмэгтэйчүүдийн ногоо зардаг замын хажуугийн лангууг нүүлгэх болно.
Өндөр настнуудтай хийсэн ФБЯ (Баянчандмань болон Баянгол сумууд)	• Ихэвчлэн зам гарч такси юм уу нийтийн унаанд сууж Улаанбаатар уруу явдаг; • Зам гарах гарц хангалтгүй учраас өндөр настанууд сургуулийн хүүхдүүдэд зам гарахад нь тусладаг; • Тусгай хэрэгцээтэй хүмүүсийн хувьд зам хөндлөн гарах нь маш хэцүү байдаг; • Хүүхдүүд болон мал машин, тээврийн хэрэгсэд өртөх, дайруулах зэрэг аюултай нөхцөлд байна; • Төмөр замаас сумын төв хүртэл нийтийн тээврийн хэрэгсэл явдаггүй учраас хүмүүс замын хажуугаар алхдаг. Харамсалтай нь явган зорчигчдод зориулсан зам байхгүй (Баянгол); • Зам гарахад зориулсан зам доогуурх гарц барьбал өндөр настан, хүүхдүүд зам гарахад тохиромжтой байж болох юм. Мөн мал/амьтанд зориулсан нүхэн гарц байх нь зүйтэй; • Замын гэрлэн дохио, гудамжны гэрэл болон замын тэмдэг, тэмдэглэгээ болон хурд сааруулагчийг барьж, сайжруулах; • Замын барих гэж байгаа тухай мэдээлэл сайн авч чадаагүй байна; • Түр зам малын бэлчээрт хохирол учруулж, тоос шороо их босгоно гэж санаа зовж байна; • Орон нутгийн төлөөлөгчдөөс хяналт, мониторингийн багт орж ажиллах хэрэгтэй гэж санал болгомоор байна.

7. Талуудын оролцоог хангах хөтөлбөр

7.1. Танилцуулга

Гадагшаа чиглэсэн харилцаа холбооны гол зорилго нь зорилтот талуудын оролцоог тасралтгүй хангах, тэдэндТөслийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тухай мэдээллийг цаг алдалгүй хүргэж байхад оршино. Тиймээс энэ хэсэгт Төслийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх үйл явцын салшгүй хэсэг болсон талуудын цаашдын байнгын оролцоо болоод ил тод байдлыг бүрдүүлэхэд Талуудын оролцоог хангах хөтөлбөрийн гүйцэтгэх цар хүрээг тогтоох явдал юм. Энэ нь Талуудын оролцоог хангах зорилго, оролцооны аргууд, цаашдын оролцоог дэмжих оролцооны хөтөлбөрийн ерөнхий тойм, замын барилга угсралт болон ашиглалтын явцын ТОХТ-г нарийвчлан боловсруулахад авч хэрэгжүүлэх ёстой гол алхмуудыг багтаасан болно.

7.2. Оролцооны зорилго, зорилтууд

Талуудын оролцоог тасралтгүй хангах хамгийн гол зорилго бол:

- Үндэсний хууль тогтоомж болон ЕСБХБ-ны ГШ-д нийцүүлэх;
- Төслийг Боловсруулагч, гэрээт гүйцэтгэгч болон Талууд хоорондын харилцан үр ашигтай, урт хугацааны харилцаа холбоог тогтоох, хадгалах
- Талууд Төсөл, түүний үр нөлөө, үр шим зэргийн талаар бүрэн дүүрэн мэдээлэлтэй байхад анхаарах, шаардлагатай бол мэдээллээр хангасны үндсэн дээр засч залруулах боломж олгох, тогтвортой хөгжлийн шийдлүүдийг хэлэлцэж, зөвшилцөх боломжоор хангах;

Талуудын оролцоог хангах хөтөлбөр нь дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Төслийн үр дүнд үүсэж болзошгүй үр нөлөө, үр ашгийн талаар үнэн зөв, бодитой ойлголт өгөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор соёлын хэм хэмжээнд нийцсэн зохистой хэлбэрээр мэдээллийг тогтмол, тасралтгүй, цаг алдалгүй, хүртээмжтэй байдлаар түгээн дэлгэрүүлэх;
- Шаардлагатай үед оролцоог сайтар төлөвлөсөн, ил тод байлгахад анхаарах ингэхдээ мэдээллийг зохих байдлаар хүргэх, зорилгыг тодорхой ойлгуулах, оролцооны үйл явц, баримтжуулалт, эргэх холбоог харилцан тохиролцох;
- Одоо байгаа харилцааны хөтөлбөр, механизмд түшиглэн өнөөг хүртэл Төслийн зүгээс тодорхойлсон орон нутгийн эмзэг асуудлуудыг анхааралдаа авах;
- Төслийн оролцогч талууд болон орон нутгийн иргэдэд тулгамдсан асуудал, өргөдөл гомдлоо зохион байгуулалттай, найдвартай, үр дүнтэй арга замаар шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Талуудын оролцоог хангах үйл ажиллагаанд эмзэг бүлгийн хүмүүс, тэдний төлөөллийг оролцуулах;
- Сонирхогч бүх талуудад тогтмол, зохион байгуулалттай тайлагнах, ингэхдээ оролцогч олон нийтэд тохиромжтой тайлангийн хэлбэрт тусгайлан анхаарал хандуулах;
- Нарийвчилсан ТОХТ-ний үр дүнтэй хэрэгжилтийг хангахын тулд удирдлагын чадавх, үүрэг хариуцлага, тогтолцоог бий болгож, хадгалах.

7.3. Харилцааны аргууд

Өнөөг хүртэл ашиглаж ирсэн оролцооны аргууд, мөн өмнө нь зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтаас гарсан саналууд дээр тулгуурлан дараах үндсэн аргуудыг (бусад аргуудыг тодорхойлж, зохих байдлаар ашиглаж болно) цаашид Талуудын оролцоо, мэдээллийн ил тод байдлыг үр дүнтэй хангахад ашиглахаар төлөвлөж байгаа болно. Үүнд:

Олон нийтийн уулзалт, хурал

Олон нийтийн уулзалт нь нэлээд олон төрлийн үйл ажиллагааг нэгтгэсэн арга хэмжээ юм. Энэ нь нийтэд зориулан танилцуулга хийх, сурталчилгааны зурагт хуудас үзүүлэх, асуулт, хариултын цаг гаргах, эсвэл дугуй ширээний ярилцлага хийх, хэвлэмэл материал тараах зэрэг үйл ажиллагааг багтаасан байдаг. Мөн оролцогчдод санал асуулгын хуудас тарааж болно. Олон нийтийн уулзалтын зорилго нь хэлэлцүүлэг өрнүүлэх, оролцогчдын дунд үр дүнтэй, хоёр талын мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх явдал юм.

Фокус Бүлгийн Ярилцлага

Цөөн тооны хүмүүсийг хамарсан жижиг бүлгийн хэлэлцүүлэг буюу ФБЯ-ыг цаашид тусгай бүлгүүдийн, тухайлбал эмэгтэйчүүдийн оролцоог хангахад ашиглана.

Мэдээллийн самбар

Мэдээллийн самбар нь зурагт хуудас, мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй тараахад хэрэглэгдэнэ. Энэ нь олон нийтэд Төслийн тухай мэдээллийг авахаас гадна аливаа санал бодол, гомдлоо илэрхийлэх талбар болох юм. Эдгээр самбарыг төслийн үр шимийг хүртэгч/ нөлөөнд өртөж буй сум бүрт байрлуулна (олон нийтийн төв/ЗДТГ-ын байранд).

Гол Мэдээлэгчийн Ярилцлага

ГМЯ нь тухайн нэг асуудлын талаар анхдагч мэдээлэл/эсвэл гүнзгий, дагнасан мэдлэгтэй эсвэл тухайн асуудалд сонирхол хандуулсан хувь хүмүүсээс нарийвчилсан ойлголт/мэдээлэл авах арга юм. ГМЯ нь танилуудын хооронд өрнөж байгаа харилцан яриатай төстэй бөгөөд ФБЯ-ын үеэр цуглуулсан мэдээллийг баталгаажуулах, нягтлах боломж олгоно.

Зорилтот Уулзалтууд

Төслийн үйл ажиллагааны улмаас үр нөлөөг амсаж буй хувь хүн болон нүүлгэн шилжүүлсэн хүмүүстэй хувийн асуудлыг ярилцах зорилгоор хэрэглэх арга болно.

Албан ёсны харилцаа холбоо/мэдээлэл солилцох

Албан ёсны бичгэн харилцааг МУ-ын төр, захиргааны байгууллага болон бусад Талуудтай харилцахдаа хэрэглэх болно.

Мэдлэг, мэдээлэл түгээх материал

Замын барилгын ажил/үйл ажиллагааны тухай мэдээллийг оновчтой, зорилтот хэлбэрийг ашиглан боловсруулж, төслийн үйл ажиллагаа болон төлөвлөгөөний тухай олон нийтэд мэдээлэх болно (мөн аюулгүй байдлын тухай). Эдгээр материал нь мэдээллийн хуудас, брошур зэрэг төрөл байх юм.

Гомдол барагдуулах механизм

Аливаа өргөдөл гомдол болон олон нийтэд тулгамдсан асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхээр Гомдол Барагдуулах Механизмыг бий болгосон юм. Төслийн хэрэгжих бүхий л цаг хугацааны явцад Гомдол Барагдуулах Механизм нь Төслийн оролцогч талуудын оролцоог хангах арга хэрэгслийн гол бүрэлдэхүүн хэсэг нь байна.

Орон Нутгийн Хэвлэл Мэдээлэл, Радио болон Сонингийн Нийтлэл

Төсөл нь ТВ, радио, сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран төслийн үйл ажиллагааны мэдээллийг түгээх, төслийн тухай мэдлэг, мэдээллийг нийтэд дэлгэрүүлэх зорилгоор ажиллана.

Замын тэмдэглэгээ

Төслийн үндсэн мэдээллийг агуулсан замын тэмдэглэгээ (аюулгүй байдлыг таниулах, огноо гэх мэт).

7.4. Талуудын оролцоог хангах хөтөлбөр

Талуудын оролцоог хангах хөтөлбөр (СТОХ) нь Төслийн хөгжлийн ерөнхий үе шатуудтай уялдсан хэд хэдэн үе шатнаас бүрдэнэ. Үүнд:

- БОННҮ-г нийтэд ил тод болгох;
- Цаашдын Талуудын оролцоог хангах үйл ажиллагаа (барилгын өмнөх, барилгын үеийн болон ашиглалтын үе шатны).

Төслийн хэрэгжилтээс хамаарч цаашдын үйл ажиллагааг тодорхойлж, төлөвлөх болно (7.4.3 хэсгийг үзнэ үү). Төслийн болон оролцогч талуудын хэрэгцээний талаар илүү сайн ойлголттой болохын хэрээр энэхүү СТОХ-ийг тогтмол хянаж, шинэчилж байх болно. СТОХ-ийн баримт бичгийн дараагийн хувилбарууд нь талуудын оролцоог хангах ажлын явцаас гарсан үр дүнг тодорхойлж, Талуудын оролцоог хангах хөтөлбөрийн цаашдын арга хэмжээнд зориулсан үйл ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан гаргасан байна.

7.4.1. БОННҮ-г нийтэд ил тод болгох

Төслийн БОННҮ-г нийтэд ил тод болгох багц нь орон нутгийн түвшинд байгаль орчны зөвшөөрөл олгох зорилгоор боловсруулсан баримт бичгүүдээс гадна ЕСБХБ-ны шаардлагыг хангахын тулд боловсруулсан үндэсний хууль тогтоомжоос цаашхи нэмэлт баримтуудаас бүрдэнэ. Эдгээр нэмэлт тайланд БОННҮ-г нийтэд ил тод болгох багцыг дараах байдлаар бүрдүүлнэ:

- Батлагдсан БОННҮ тайлан;
- Нэмэлт БОННҮ;
- Техникийн бус нэмэлт дүгнэлт (ТБНД);
- Нэмэлт Байгаль орчин, нийгмийн удирдлага ба мониторингийн төлөвлөгөө (БОНУМТ);
- Газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ (ГЧНШХ);
- Байгаль орчин ба нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНҮАТ); болон
- Энэхүү нэмэлт СТОХ.

БОННҮ-г нийтэд ил тод болгох багцыг Англи болон Монгол хэл дээр ЕСБХБ-ны вэбсайт (www.ebrd.com) –аас авах боломжтой. Энэ нь А зэрэглэлийн төсөл учраас баримт бичгүүдийг нь хамгийн богино зөвлөлдөх хугацаа буюу 60 хоногийн турш байршуулна.

Эдгээр баримт бичгүүдийн хэвлэмэл хуулбарыг Улаанбаатар хот дахь ЕСБХБ-ны төлөөлөгчийн газар болон Монгол Улсын ЗТХЯ-наас авч болно. ТБНД-ийн хэвлэмэл хувийг Төслийн нөлөөнд өртсөн сум, багийн сонирхсон тлуудын хэрэгцээнд зориулан аймаг, сум болон багийн түвшний орон нутгийн удирдлагуудтай хуваалцах болно.

7.4.2. Талуудын оролцоог хангах цаашдын хөтөлбөр

Төслийн барилгын өмнөх болон барилгын, ашиглалтын үе шатанд оролцогч талууд, оролцооны арга замууд мөн нийтэд дэлгэх мэдээллүүдийг Хүснэгт 7-1-д нэгтгэн үзүүллээ. Оролцооны хөтөлбөр нь холбогдох орон нутгийн эрх бүхий этгээдүүдийн идэвхитэй оролцоотойгоор талуудын өмнө бий болгосон тогтолцоо, бүтэц зэрэгт суурилсан байна.

7.4.2.1. Ерөнхий зүйл

Барилгын ажил болон хуваарийн талаарх урьдчилсан анхааруулгыг орон нутгийн иргэдэд өгөх ба үүнд сумын түвшинд хийгдэх үйл ажиллагаа, цаг хугацаа зэргийг багтаасан байна. Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх ажлыг барилгын гэрээт гүйцэтгэгч нар хариуцан гүйцэтгэх ба ТХН нь Төслийн бүх талбар нэгжүүдийн хүрээнд нэгэн жигд хэрэгжүүлэх чиглэлд хяналт тавина. Оролцоо нь ерөнхий мэдээлэл дээр төвлөрөхөөс гадна хүн ам ихээр төвлөрсөн газар, сургууль гэх мэт эрсдэл өндөртэй газар болон өндөр эрсдэлтэй бүлгүүд (тухайлбал малчдад, жишээ нь малаа хариулгагүй орхихгүй байхыг зөвлөх) дээр төвлөрөх болно.

Орон нутгийн иргэдэд орохыг хориглосон хязгаарлалтын талаар болон түр зуурын хувилбарт зохицуулалтуудын талаар урьдчилан мэдэгдэх болно. Түр хугацаанд нэвтрэх талаарх мэдээллийг орон нутгийн хэмжээнд олон нийтэд мэдээлж, шинэчилж байх болно.

Гомдол барагдуулах механизм, түүнийг хэрхэн ашиглах талаар орон нутгийн иргэдэд бүрэн хэмжээнд мэдээллэх болно.

Бүх гэрээт гүйцэтгэгчид/ажилчид, туслан гүйцэтгэгчдэд Сахилгын дүрмийг танилцуулсан байх ба үүнд тэдний нутгийн иргэд, олон нийттэй харилцах харилцааны талаарх хүлээлт, тухайлбал төслийн нөлөөнд өртсөн олон нийтийн дунд мөрдөх сахилга бат, зан байдал (жишээлбэл, зохисгүй бэлгийн харьцаанд орохгүй байх гэх мэт), мөн холбогдох шийтгэлийн талаар заасан байна.

Барилгын гэрээт гүйцэтгэгч нь ТХН-ийн дэмжлэгтэйгээр сар бүр, эсвэл аймаг, сум/баг бүрт хийгдэх барилгын ажлын үе шатанд нийцсэн тодорхой давтамжтайгаар аймаг, сумдыг мэдээллээр хангана.

Өмнө хэрэгжүүлсэн оролцооны ажлуудаар тодорхойлсончлон барилгын ажлын явцад ТХН нь төслийн зурвасын дагуу хамгийн багадаа хоёр удаа ярилцлага хийнэ. Ингэхдээ барилгын ажил эхэлснээс хойшхи 6-8 долоо хоногийн дотор болон төслийн ажил дуусахаас өмнө хийхийг санал болгож байна. Төслийн нөлөөнд өртсөн хүмүүстэй ярилцлага хийхдээ барилгын ажлын дуу чимээ, тоос шороо, хатуу хог хаягдал, бохир ус, экологийн хамгаалал, хөрс / газрын асуудал, нэвтрэх боломж зэрэгтэй холбоотой олон нийтийн санаа зовоосон асуудлуудын талаарх гомдолд анхаарал хандуулах болно.

Талуудын оролцоог хангах үйл ажиллагаа, санал гомдлыг сар тутам мэдээлж, гол асуудлуудын мөрөөр аймаг/сум/багт нь эргэж мэдээлэх болно. Барилгын ажлын явц, өргөдөл гомдлын талаар суманд жилд хоёр удаа, орон нутгийн иргэд, багт жилд нэг удаа танилцуулж байна.

7.4.2.2. Бие махбодийн болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүстэй зөвлөлдөх уулзалт

ГЧНШХ болон дагалдах Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (ГЧНШТ) -ний дагуу газар чөлөөлөлт (түр болон байнгын), нөхөн олговрын арга хэмжээ, амьжиргааг нь сэргээн босгохтой холбоотой уулзалтуудыг нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүстэй хийж байгаа бөгөөд цаашид үргэлжлүүлэн хийх болно. Эдгээр уулзалтуудыг ТХН болон тухайн аймгуудаар дамжуулан хийнэ.

7.4.2.3. Нөлөөнд өртсөн хүмүүс, эмзэг бүлгүүдтэй зөвлөлдөх уулзалт

Төслийн бүсэд багтсан нутагт амьдардаг, нөлөөнд өртсөн бүх хүмүүс, эмзэг бүлгүүдтэй төсөл хэрэгжих хугацааны туршид тогтмол давтамжтайгаар уулзаж зөвлөлдөнө. ТХН, Барилгын гэрээт гүйцэтгэгчидтэй хамтран эдгээр уулзалтыг зохион байгуулах үүрэгтэй. Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгшид болон бусад эмзэг хүмүүс, тухайлбал малчидтай уулзаж тэдний хэрэгцээ, санаа зовоосон асуудлуудыг Төслийн нөлөөлөлтэй уялдуулан шийдвэрлэнэ. Орон нутгийн засаг захиргаа болон иргэдээс барилгын ажилчдын амьдрах кэмпийн байршлын талаар зөвлөгөө авах юм.

Барилгын ажил эхлэхээс өмнө Төслийн талбар бүсэд мэдээлэл түгээх дасгал ажил хийгдэнэ. Энэхүү дасгал ажилд ЗТХЯ/ТХН-ийн гол төлөөлөл гишүүд оролцох бөгөөд нийтэд ил болгох багцад багтсан мэдээллийг Улаанбаатар хотод холбогдох олон нийт (Иргэдийн хурал, орон нутгийн засаг захиргааны хурал)–д, мөн Төслийн бүсэд багтсан сум, багуудад танилцуулна. Ингэснээр орон нутгийн иргэдэд гомдол барагдуулах механизмыг хэрхэн ашиглах талаар мэдээлэл хүргэх болно.

Хүснэгт 7-1. Талуудын оролцоог хангах цаашдын хөтөлбөр

Оролцогч талууд	Оролцоог хангах арга	Нийтэд ил тод болгох мэдээлэл / Үйл ажиллагаа	Хариуцсан тал	Хэрэгжилтийн хуваарь
Барилгын өмнөх үе шат				
Бүх оролцогч талууд	ЕСБХБ-ны вэд хуудас ЗТХЯ болон ЕСБХБ-ны Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газарт хэвлэмэл хувилбарыг байршуулна ТБНД-ийг аймаг/сумын захиргааны ажлын албанд Орон нутгийн Хэвлэл мэдээлэл, Радио, Сонингийн нийтлэл Багийн хурал	БОНҮ-ний бүх Нэмэлт баримт бичгийг нийтэд ил болгох. Үүнд: БОННҮ, ТБНД, ТОХТ, ГЧНШХ болон БОНҮАТ. Нэмэлт мэдээллийн бэлэн байдлын талаар орон нутгийн сонин хэвлэл болон радио, багийн хурал зэргээр дамжуулан зарлах	ЕСБХБ / ЗТХЯ	БОНҮ-г хийж дуусмагц
Өртсөн хүмүүс	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх илтгэл бүхий олон нийтийн эхний уулзалтыг барилгын ажил эхлэхээс өмнө хийх Эмзэг болон эрсдэл өндөртэй	Барилгын кэмпүүдийн байршил зэргийг багтаасан барилгын өмнөх ерөнхий төлөвлөлт болон талбарын бэлтгэл ажил Талбарын бэлтгэл болон барилгын ажлын ерөнхий хуваарь, үүнд дэд үйл ажиллагаанууд, гол үе шатууд болон оролцогч талуудын сонирхох боломжтой үе шатуудыг оруулах	ЗТХЯ / ТХН	Барилгын ажил эхлэхээс өмнө

Оролцогч талууд	Оролцоог хангах арга	Нийтэд ил тод болгох мэдээлэл / Үйл ажиллагаа	Хариуцсан тал	Хэрэгжилтийн хуваарь
	хүмүүсийн дундах олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлын талаар ярилцах ФБЯ Сурталчилгааны материал Суурьшил болгон дахь мэдээллийн самбар, замын тэмдэг Орон нутгийн Хэвлэл мэдээлэл, Радио, Сонингийн нийтлэл Гомдол барагдуулах механизм	Барилгын ажлын үед авах аюулгүй байдлын арга хэмжээ, нэвтрэх боломж, замын хөдөлгөөний удирдлагын талаарх мэдээлэл Эмзэг болон эрсдэл өндөртэй бүлгүүдэд чиглэсэн аюулгүй байдлыг хангах зорилтот арга хэмжээнүүд Үзэл бодол, санаа зовж буй асуудлуудыг сонсож мэдэх Нийтэд ил болгох, Олон нийтийн гомдол барагдуулах механизм		
Төслийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүс	Шаардлагатай бол зорилтот уулзалт	Эдийн засгийн болон бие махбодийн нүүлгэн шилжүүлэлтийн журам, нөхөн олговрын гэрээ хэлцэл Ажлын цагийн хуваарь Олон нийтийн гомдол барагдуулах механизм	ЗТХЯ / ТХН	Барилгын ажил эхлэхээс өмнө
Хурал (аймаг, сумын) **Аймаг, сум** **Засгийн газрын агентлагууд**	Багийн албан ёсны хуралд оролцох Зорилтот уулзалт, хүсэлтийн дагуу Сурталчилгааны материал	Зөвшөөрөл болон батламж Барилгын кэмпүүдийн байршил болон карьеруудын ашиглалт зэргийг багтаасан барилгын өмнөх ерөнхий төлөвлөлт болон талбарын бэлтгэл ажил Дэд үйл ажиллагаанууд, гол үе шатууд болон Талуудын сонирхох боломжтой үе шатууд, нэвтэрч ороход тавигдах шаардлага / бэрхшээлийг багтаасан талбарын бэлтгэл болон барилгын ажлын ерөнхий хуваарь Аливаа өргөдөл гомдлыг хэлэлцэх	ЗТХЯ / ТХН	Барилгын ажил эхлэхээс өмнө
Эмзэг бүлгүүд	Тогтоогдсон эмзэг бүлгийн хүмүүстэй барилгын ажил эхлэхээс өмнө хийх зорилтот уулзалт болон ФБЯ Мэдээллийн материалаар хангах Гомдол барагдуулах механизм	Төслийн бүрдэл хэсгүүд, ялангуяа барилгын ажиллах хүч, аюулгүй байдлын асуудал /удирдлагын талаарх мэдээлэл, боломжит ажил эрхлэлтийн боломжууд, шаардагдах ур чадвар болон сургалтанд хамрагдах боломжууд, замын хөдөлгөөний удирдлага, нэвтрэх чиглэл зэргийн талаар нарийвчлан зөвлөлдөх	ЗТХЯ / ТХН	Барилгын ажил эхлэхээс өмнө
Өртсөн хүмүүс **Эмзэг бүлгүүд** **Бизнес эрхлэгч / ханган**	Суурьшлын бүс болгон дахь мэдээллийн самбар, дэлгүүр, орон нутгийн албан газар гэх мэтэд	Удахгүй зарлагдах барилгын үе шатны ажил эрхлэлтийн боломж, ажилд орох өргөдөл гаргах үйл явц	ЗТХЯ / ТХН	Барилгын ажил эхлэхээс өмнө

Оролцогч талууд	Оролцоог хангах арга	Нийтэд ил тод болгох мэдээлэл / Үйл ажиллагаа	Хариуцсан тал	Хэрэгжилтийн хуваарь
нийлүүлэгчид **Аж үйлдвэрийн салбарын компаниуд** **Боловсролын байгууллагууд** **Олон нийт**	байршуулсан мэдэгдэл Орон нутгийн (аймаг, сумын) Хурлаар дамжуулан хэвлэн нийтлэх Сурталчилгааны материал Орон нутгийн хэвлэл мэдээлэл / сонин / радио			
Замын цагдаа	Зорилтот уулзалт	Замын аюулгүй байдал	ЗТХЯ / ТХН	Барилгын ажил эхлэхээс өмнө
Эрүүл мэндийн төвүүд **Цагдаа** **Гал команд**	Зорилтот уулзалт	Онцгой байдлын үеийн Бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө – онцгой байдлын үед дайчлах орон нутгийн эх үүсвэрийн боломж	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Барилгын ажил эхлэхээс өмнө
Гэрээт гүйцэтгэгч нар	Тендерийн бичиг баримт	Гэрээний мэдээлэл / Тендер зарлах хугацаа	ЗТХЯ / ТХН	Төлөвлөлтийн үе шатанд
Нийтийн үйлчилгээний байгууллагууд	Шаардлагатай бол зорилтот уулзалт Албан харилцаа	Нийтийн үйлчилгээний төлөвлөлт Гомдол барагдуулах механизм	ЗТХЯ / ТХН	Төлөвлөлтийн үе шатанд
ЕСБХБ	Албан уулзалт / харилцаа	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНҮАТ)-г дагаж мөрдөхтэй холбоотой албан харилцаа	ЗТХЯ / ТХН	Шаардлагатай үед
Бүх оролцогч талууд	Орон нутгийн хэвлэл мэдээлэл / сонин Замын тэмдэглэгээ Гомдол барагдуулах механизм	Төслийн барилгын үндсэн гол мэдээлэл (огноо/хуваарь, аюулгүй байдлын санамж, үйл ажиллагаа)	ЗТХЯ / ТХН	Барилга угсралтыг эхлэхээс өмнө нэн даруй аль нэг байршил дээр
Барилгын үе шат				
Өртсөн хүмүүс **Эмзэг бүлгүүд**	Эмзэг болон эрсдэл өндөртэй хүмүүсийн дунд барилгын ажлын явцад доод тал нь 2 удаа буюу эсвэл тухайн аймаг/сум/багтай, эсвэл эмзэг бүлгүүдтэй шууд тохиролцсон хугацаанд хийх ФБЯ/ГМЯ Өртсөн хүмүүстэй ядаж барилгын	Төслийн хэрэгжилтийн хуваарь / ахиц дэвшлийн талаар мэдээлэх Хөдөлмөр эрхлэлт, ажил хэрхэн горьлох тухай мэдээлээр хангах Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөтэй газарт болон эргэн тойронд нь зохион байгуулагдаж буй үйл ажиллагаануудад тогтмол оролцох, бусдад мэдээлэх (шаардлагатай бол)	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Шаардлагатай үед хийх гэнэтийн уулзалтууд Жил тутам

Оролцогч талууд	Оролцоог хангах арга	Нийтэд ил тод болгох мэдээлэл / Үйл ажиллагаа	Хариуцсан тал	Хэрэгжилтийн хуваарь
	ажлын явцад 2 удаа, эсвэл тодорхой өргөдөл гомдлын мөрөөр хийх ярилцлага Ёс зүйн дүрэм Сонин Гомдол барагдуулах механизм	Орон нутгийн иргэд олон нийттэй төслийн хэрэгжилт, нөлөөний тухайд тэд ямар үзэл бодол, саналтай талаар зөвшилцөх Гомдол барагдуулах механизмын талаарх ойлголт мэдлэгийг олгож, бодитоор бий болгох		
Ажилчид	Сургалт, жишээ нь Ёс зүйн дүрмийн талаар Барилгын кэмп, ажлын талбай дээрх мэдээллийн самбар Барилгын кэмп дээрх уулзалт Сурталчилгааны материал Гомдол барагдуулах механизм	Ёс зүйн дүрэм Талуудын оролцоо, олон нийттэй холбоотойгоор Төслийн бодлого / төлөвлөгөөний талаар мэдээлэх Гадаад гомдол барагдуулах механизмын талаар мэдээлэх Дотоод хүний нөөцийн гомдол барагдуулах механизмын талаар мэдээлэх Хөдөлмөрийн маргаан гомдол	Гэрээт гүйцэтгэгчид	Талбар дээр ажил хийгдэж эхлэхээс өмнө ажилчдад танилцуулах Барилгын ажлын явцад тогтмол
Бүх оролцогч талууд	Суурьшлын бүс болгон дахь мэдээллийн самбар, дэлгүүр, албан газар, мөн зам дагуух зоогийн газар гэх мэт бусад газарт байршуулсан мэдээлэл Багийн хурал Мэдээний хуудас, товхимол хэлбэрээр орон нутгийн иргэд, бизнесүүдэд түгээх сурталчилгааны материал Замын тэмдэглэгээ ашиглах Орон нутгийн хэвлэл мэдээлэл / сонин / радио Гомдол барагдуулах механизм	Барилгын ажлын хуваарь Барилгын үйл ажиллагаа Барилгын явцын өрнөл Барилгын нөлөө, түүнийг бууруулах арга хэмжээ (эргэн мэдээлэх боломж бүхий) Гомдол барагдуулах механизмын талаарх ойлголт мэдлэгийг олгож, бодитоор бий болгох	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Гэнэтийн / шаардлагатай үед
Засгийн газрын агентлагууд	Албан уулзалт / харилцаа	Төсвийн үйл явцын талаар мэдээлж, нарийвчилсан мэдээллээр хангах Тайлан илгээж, санал дүгнэлтийг нь асуух	ЗТХЯ / ТХН	Жилд хоёр удаа болон шаардлагатай үед
Хурал (аймаг, сумын)	Сард нэг удаа эргэн мэдээлэх Албан харилцаа / уулзалтанд	Төсвийн үйл явцын талаар мэдээлж, нарийвчилсан мэдээллээр хангах	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Жилд хоёр удаа болон шаардлагатай үед

Оролцогч талууд	Оролцоог хангах арга	Нийтэд ил тод болгох мэдээлэл / Үйл ажиллагаа	Хариуцсан тал	Хэрэгжилтийн хуваарь
Аймаг ба сум **Засгийн газрын байгууллагууд**	оролцох ГМЯ Сурталчилгааны материал Гомдол барагдуулах механизм	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөтэй газарт болон эргэн тойронд нь зохион байгуулагдаж буй үйл ажиллагаануудад тогтмол оролцох, бусдад мэдээлэх (шаардлагатай бол) Шаардлагатай зөвшөөрөл Материал ашиглалтын шаардлага (ус, дүүргэгч материал, эрчим хүч гэх мэт) Өргөдөл гомдлын талаар хэлэлцэх Тайлан илгээж, санал дүгнэлтийг нь асуух		
Хэвлэл мэдээлэл	Албан харилцаа	Хүсэлтийн дагуу төслийн талаарх нарийвчилсан мэдээлэл	ЗТХЯ / ТХН	Гэнэтийн / шаардлагатай үед
ТББ **Олон нийтийн бүлгүүд** **Боловсролын байгууллагууд**	Албан харилцаа / уулзалт Орон нутгийн хэвлэл мэдээлэл / сонин / радио Сурталчилгааны материал Гомдол барагдуулах механизм	Төслийн мэдээлэл болон сурталчилгааны материалаар хангах Тодорхой асуудлуудын талаарх уулзалт	ЗТХЯ / ТХН	Гэнэтийн / шаардлагатай үед
Өртсөн хүмүүс **Эмзэг бүлгүүд** **Бизнес эрхлэгч / ханган нийлүүлэгчид** **Аж үйлдвэрийн салбарын компаниуд** **Боловсролын байгууллагууд** **Олон нийт**	Суурьшлын бүс болгон дахь мэдээллийн самбар, дэлгүүр, албан газар гэх мэтэд байршуулсан мэдээлэл Сурталчилгааны материал Орон нутгийн хэвлэл мэдээлэл / сонин / радио	Байнгын, шинээр бий болох ажил эрхлэлтийн боломжууд, ажилд орох өргөдөл гаргах үйл явц	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Жилд хоёр удаа болон шаардлагатай үед
ЕСБХБ	Албан уулзалт / харилцаа	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНҮАТ)-г дагаж мөрдөхтэй холбоотой албан харилцаа	ЗТХЯ / ТХН	Шаардлагатай үед
Эрүүл мэндийн төв **Цагдаа** **Гал команд**	Зорилтот уулзалт	Онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө, орон нутагт авах боломжтой үйлчилгээний талаар танилцуулах	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Байгууллагуудтай тохирсон ёсоор тогтмол

Оролцогч талууд	Оролцоог хангах арга	Нийтэд ил тод болгох мэдээлэл / Үйл ажиллагаа	Хариуцсан тал	Хэрэгжилтийн хуваарь
Ашиглалтын үе шат				
Ажилчид	Сургалт Гомдол барагдуулах механизм	Ёс зүйн дүрэм Дотоод хүний нөөцийн гомдол барагдуулах механизмын талаар мэдээлэх	ЗТХЯ	Ашиглалтын явцад тогтмол
Гэрээт гүйцэтгэгчид **Өртсөн хүмүүс** **Эмзэг бүлгүүд** **Бизнес эрхлэгч / ханган нийлүүлэгчид** **Аж үйлдвэрийн салбарын компаниуд** **Боловсролын байгууллагууд** **Олон нийт**	Бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх хэвлэлүүдэд тавигдах зар сурталчилгаа Мэдээллийн самбар	Ашиглалтын явцад ажил эрхлэх боломж болон шаардагдах ур чадвар / дэд гэрээгээр ажил гүйцэтгэх боломжуудын талаарх мэдээлэл	ЗТХЯ	Ашиглалтын явцад, шаардлагатай үед
Бүх оролцогч талууд	Орон нутгийн хэвлэл мэдээлэл / сонин / радио Замын тэмдэг	Төлбөр хураах цэгүүд, төлбөр хураах зардал, яаралтай тусламжийн журам, жолоочийн аюулгүй байдал болон хурдны хязгаарын талаар мэдээлэл түгээх	ЗТХЯ	Барилгын эцэст / ашиглалтын эхэнд
ЕСБХБ	Албан уулзалт / харилцаа	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНҮАТ)-тэй холбоотой албан харилцаа	ЗТХЯ	Шаардлагатай үед
Эрүүл мэндийн төв **Цагдаа** **Гал команд**	Зорилтот уулзалт	Олон нийтийн онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө болон орон нутагт холбогдох үйлчилгээг авах боломжууд	ЗТХЯ	Байгууллагуудтай тохирсон ёсоор тогтмол

7.4.3. Талуудын оролцоог хангах нарийвчилсан хөтөлбөр боловсруулах нь

Энэхүү СТОХ нь барилга угсралт болон ашиглалтын шатанд хэрэглэх Талуудын оролцоог хангах нарийвчилсан хөтөлбөр боловсруулахад мөрдлөг болгох ёстой зорилт, зарчмуудаар хангах юм. Гүйцэтгэх үүрэг хариуцлагыг 10-р хэсэгт тусгасан болно.

Төсөлд бүхэлд нь хамаарах СТОХ-ийг боловсруулахын тулд ЗТХЯ /ТХН дараах алхмуудыг хийх хэрэгтэй. Багц тус бүрт буюу хариуцан ажиллаж буй замын хэсэгтээ зориулсан үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр хангахын тулд Барилгын гэрээт гүйцэтгэгч нар Төслийн СТОХ-ийг боловсруулах ёстой.

Оролцогч талуудын нарийвчилсан жагсаалт гаргах

Хүснэгт 4.1-т харуулсан оролцогч талуудын жагсаалтыг оролцогч талуудын бүртгэл хэлбэрт оруулан илүү боловсронгуй болгож, тэр нь оролцогч талуудын дэлгэрэнгүй жагсаалт болон холбоо барих мэдээллийн баазаар хангадаг байх ёстой. Энэхүү жагсаалтыг ЗТХЯ болон орон нутгийн засаг захиргаатай хамтран боловсруулна. Цаашдын холбогдох оролцогч талуудыг бусад оролцогч талуудын холбон зуучлал, мөн Төсөлд оролцох сонирхлоо илэрхийлсэн байгууллагуудын холбоо сүлжээгээр дамжуулан тодорхойлох болно. Оролцогч талуудын бүртгэлийг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэх хэрэгтэй.

Харилцаа холбооны төлөвлөгөө

Дотоод ба гадаад харилцааны удирдамж чиглэлээр хангах дотоодын Харилцаа холбооны төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Энэхүү төлөвлөгөө нь ТХН, ЗТХЯ, АХБ, ЕСБХБ, Барилгын гэрээт гүйцэтгэгчид хоорондын Төслийн холбогдолтой ерөнхий асуудлуудын талаарх харилцааг үр дүнтэй болгож, эдгээр хамтрагч талуудыг Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөв байдлын талаар хамгийн сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангагдах нөхцлийг бүрдүүлнэ.

Талуудын оролцоог хангах нарийвчилсан хөтөлбөр боловсруулах

Хүснэгт 7-1-т Талуудын оролцоог хангах хөтөлбөрийн тойм бүдүүвчийг харуулсан. Түүнийг илүү нарийвчилсан оролцооны хөтөлбөр болгон сайжруулах, ингэхдээ ЗТХЯ/ТХН болон Барилгын гэрээт гүйцэтгэгчдэд оногдуулсан үүрэг хариуцлагуудыг тоорхой зааж оруулах хэрэгтэй. Хөтөлбөр нь оролцооны төлөвлөгдсөн үйл ажиллагаанууд, тухайлбал уулзалт, зөвлөлдөх үйл ажиллагаа зэргийг багтаасан байх ёстой. Тэдгээр арга хэмжээний товлосон огноо, байршил зэргийг ТХН болон Барилгын гэрээт гүйцэтгэгчид аль зохистой байдлаар боловсруулна. Хуваарь гэдэгт барилгын ажлын эхлэл, жилийн тайлан зэрэг төслийн гол мэдээллийг олон нийтэд ил болгох өдөр зэрэг мэдээлэл орно.

Талуудын оролцоог хангах нарийвчилсан хөтөлбөрийг боловсруулахад дараах асуудлууыг анхаарх хэрэгтэй. Үүнд:

- Оролцогч талуудын тодорхойлогдсон төрөл тус бүрт нийцүүлсэн гол мэдээллийг боловсруулах.
- Харилцаа холбооны материал, сурталчилгааны арга хэрэгсэл (жишээ нь хэвлэмэл материал, брошур, танилцуулга, хэвлэл мэдээллийн аянд зориулсан мэдээний хуудас, хэвлэлээр сурталчлах гэх мэт)-ийн загвар шийдэл болон үйлдвэрлэл.
- Бусад байгууллага буюу түншлэл, жишээ нь ТББ-тай хамтран зохион байгуулах оролцооны арга хэмжээнүүдийг тодорхойлох хэрэгтэй.
- Талуудын оролцоог хангах олон янзын үйл ажиллагаануудын зохион байгуулагдах өдөр, байршлыг тусгасан нарийвчилсан хуваарь боловсруулах.
- Гомдол барагдуулах механизм болон Өргөдөл гомдлын мэдээллийн сан/Бүртгэлийг бий болгох (8-р хэсгийг харна уу).

8. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизм

8.1. Танилцуулга

Холбогдох талууд (ЗТХЯ/ТХН/Барилгын гэрээт гүйцэтгэгчид) яливаа асуудал, ялангуяа нөлөөнд өртсөн иргэд олон нийтийн мэдүүлсэн гомдолд хариу өгдөг байх, өргөдөл гомдлын төвлөрсөн арга барил болон бүртгэл бий болох нөхцлийг хангах зорилгоор албан ёсны олон нийтийн гомдол барагдуулах механизмыг бүрдүүлж хэрэгжүүлнэ.

Гомдол барагдуулах механизмыг удирдахад үүрэг оролцоотой байхаар томилогдсон ажилтнуудыг сургаж чадавхжуулахад онцгой анхаарал хандуулах болно. Энэхүү гомдол барагдуулах механизм нь ажилчин-бус хүмүүс (нөлөөнд өртсөн хүмүүс болон нутгийн иргэд зэрэг холбогдох оролцогч талууд)-ийг хамруулна. Ажилчдын өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд зориулан Хүний нөөцийн хөдөлмөрийн маргаан гомдол барагдуулах механизмыг тусад нь бий болгох ба хэрэгжилтийн талаар Хөдөлмөрийн удирдлагын төлөвлөгөөнд тайлагнана.

8.2. Гомдол барагдуулах механизм

Санал дэвшүүлж буй Гомдол барагдуулах механизм (ГБМ) нь АХБ-ны 1-р үе шатны ажилд ашигласан нэгэнт бий болсон арга барилыг баримталж, Монгол улсын иргэд олон нийтийн төлөөллүүдийн мэдүүлсэн орон нутгийн асуудлуудтай холбоотой өргөдөл гомдлыг зохицуулдаг олон нийтийн одоогийн бүтэц тогтолцоонд түшиглэнэ. Одоо байгаа 1-р үе шатны ГБМ-ыг хэвээр хадгалж, олон тооны төстэй механизмуудын улмаас талуудын дунд үүсэж болзошгүй төөрөгдлийг багасгахад гол суурь болгон ашиглахыг зөвлөмж болгож байна.

Одоогийн ГБМ нь ЕСБХБ-ны ГШ10 болон ОУСТ-ын шаардлагуудад нийцсэн. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх гол платформын үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ ГБМ нь дараах зорилтуудыг хангахад тус дөхөм болохоор төлөвлөгдсөн байна. Үүнд:

- Үр дүнтэй харилцааны сувгуудыг нээх, түүний дотор төслөөс үүсэн гарах байгаль орчны шинэ асуудал бэрхшээлүүдийг тодорхойлох;
- Олон нийтийн гишүүд болон тэдний байгаль орчны сайн сайхан байдлын талаар санаа зовниж буйгаа харуулах; мөн
- Төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны улмаас олон нийтэд тулгарах байгаль орчны аливаа сөрөг нөлөөнөөс сэргийлэх, багасгах.

ГБМ нь олон нийтийн бүх гишүүдэд хүртээмжтэй байх болно. Нөлөөнд өртсөн хүн ГМБ-ын гаргасан шийдвэрт сэтгэл хангалуун бус байх тохиолдолд гомдлоо барагдуулахын тулд Монгол улсын хууль эрх зүйн тогтолцоонд хандаж болно.

Одоогоор, оршин суугчдын өргөдөл гомдлыг (олон нийттэй холбоотой) баг буюу сумын иргэдийн төлөөлөгчдөөр шийдвэрлүүлэхээр илгээдэг. Орон нутгийн иргэ олон нийт энэхүү арга барилтай хэдийнээ танил болсон, мэддэг учраас ГБМ уг арга барилыг ашиглахыг санал болгож байна. Төслийн 1-р үе шатны ГБМ-ыг аймгийн засаг захиргаанд танилцуулсан ба тэд уг арга барилыг дэмжихээ илэрхийлсэн тул 2-р үе шатанд ижил төстэй арга барилыг ашиглах нь орон нутгийн засаг захиргааны түвшинд дэмжигдэнэ гэсэн хүлээлттэй байна.

ЗТХЯ өөрийн хэрэгжүүлэгч агентлагаараа дамжуулан, ТХН-тэй зөвшилцөж, орон нутгийн засаг захиргаатай хамтран сумд түшиглэсэн Олон нийтийн Гомдол Барагдуулах Нэгж (ОНГБН) байгуулна. ОНГБН нь ТХН-ийн туслалцаатайгаар, барилгын үе шат эхлэхээс урьтан, Төслийн хэрэгжилтийн бүхий л хугацаанд Төслийн нөлөөнд өртсөн хүмүүсийн номлыг шийдвэрлэх зорилготойгоор байгуулагдана.

Сумд түшиглэсэн Олон нийтэд Хүрч очих, Хяналт үнэлгээний Ажилтнууд (ОНХОХҮА)-ыг томилох ба тэдгээр нь орон нутгийн түвшинд ГБМ-ын хэрэгжилтийг хангах үүрэг хүлээнэ. Уг ажилтнууд төслийн талаарх мэдээлэл авах буюу хэлэлцэж ярилцах тодорхой асуудал бүхий оршин суугчдын харилцах гол хүн нь байна. Барилгын гэрээт гүйцэтгэгчид өөрийн байгууллагын ажилтнууд дотроос Олон нийттэй харилцах ажилтан (ОНХА)-ыг сонгон томилох ба тэрхүү ажилтан нь орон нутгийн түвшинд ОНХОХҮА болон ОНГБН-тэй долоо хоног тутам харилцаж, мэдээлэл солилцох үүрэгтэй.

ТХН болон Барилгын гэрээт гүйцэтгэгчийн ОНХА нь сумын ОНХОХҮА-аар дамжуулан ГБМ-ын хамаарах Төслийн нутаг дэвсгэрийн иргэдийг мэдээллээр хангах олон нийтэд зориулсан мэдэгдэл гаргана. ТХН-ийн хяналтан дор ажиллах Барилгын гэрээт гүйцэтгэгчийн ОНХА нь тэрхүү мэдэгдлийн мөрөөр олон нийтийн зөвлөлдөх уулзалт болон тухайн орон нутгийн иргэд оршин суугчдын дундах зорилтот уулзалтуудыг зохион байгуулна.

Холбогдох хүмүүсийн холбоо барих утасны дугаар, факс, хаяг, и-мэйл хаягийг баг, сум, аймгийн засаг захиргааны холбогдох албадын байранд болон олон нийтийн газруудад дэлгэн харуулах замаар түгээнэ.

Сумд түшиглэсэн ОНХОХҮА нь орон нутагт өргөдөл гомдлын мэдээллийн санг хадгалан ажиллуулах тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдсан байх ба ТХН, Барилгын гэрээт гүйцэтгэгчийн Талбайн менежерүүд, аймаг, сум, багийн засаг дарга нартай харилцана.

Бүх өргөдөл гомдол болон тэдгээрийг шийдвэрлэсэн байдал (гомдлын мэдээллийн санд)-ын талаарх мэдээллийг агуулсан төвлөрсөн мэдээллийн санг барилгын үе шатанд ТХН хариуцан ажиллуулах бол ашиглалтын үе шатанд ЗТХЯ хариуцна. Талуудын оролцоог хангах болон өргөдөл гомдол барагдуулах ажлыг хариуцахаар ТХН-ийн дотроос томилогдсон ажилтан нь бүх сумдын ОНГБН-тэй тогтмол харилцаатай ажиллаж, төв мэдээллийн санг байнга шинэчлэн баяжуулна.

Төв мэдээллийн санг Төслийн замын үргэлжлэх нутаг дэвсгэрт бүхэлд нь үүссэн өргөдөл гомдлыг хянах, шалгахад ашиглах бол Барилгын гэрээт гүйцэтгэгч бүр өөрийн хариуцсан Багцтай холбоотойгоор ТХН-д хүргүүлсэн гомдлын мэдээлэлтэй нийцсэн тухайн байршилд хамаарах өргөдөл гомдлын нарийвчилсан мэдээллийн санг ажиллуулах үүрэгтэй. Тэрхүү мэдээллийн сан нь хамгийн сүүлийн үеийн мэдээллийг агуулсан, ТХН-ийн төв мэдээллийн сантай нийцсэн байх ёстой. Хэрэв гомдлыг шууд гэрээт гүйцэтгэгчид мэдүүлсэн бол үүнийг бүртгэж, холбогдох сумын ОНХОХҮА ба ТХН-д аль алинд нь мэдэгдэнэ.

ОНГБН өргөдөл гомдолд өгөх хариуг зохицуулах үүрэг хүлээнэ, гэхдээ тухайн хариуг өгөх хамгийн тохиромжтой этгээдийг тодорхойлно. ОНГБН нь тухайн асуудлыг дангаар шууд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд ТХН-ийн томилсон төлөөлөгч болон Барилгын гэрээт гүйцэтгэгчийн ОНХА-тай холбогдож, ямар арга хэмжээ авахыг шийдвэрлэхийн тулд зөвшилцөнө. Эдгээр нэр дурдсан этгээдүүд тогтмол уулзалтууд зохион байгуулах хэдий ч “хэрэгцээ”-нд тулгуурласан харилцаа холбоо ч тогтоох боломжтой.

ТХН нь хамгийн багадаа сар бүр Барилгын гэрээт гүйцэтгэгчийн ОНХА-тай холбогдож ажлын талбарт хамаарах асуудлуудыг үнэлж дүгнэж, төв мэдээллийн сангийн мэдээллийн нийцтэй болоод алдаа мадаггүй үнэн зөв байдлыг хангана.

8.3. ГБМ-ын журам ба хугацаа

Ямар ч асуудал, санал гомдлыг сумын түвшний ОНГБН-ийн сонорт амаар болон бичгээр (шуудангаар буюу и-мэйлээр) хүргэж болох бөгөөд ингэхдээ өргөдөл гомдол гаргах маягтыг бөгөлнө (жишээ загварыг Хавсралт Б-гээс харна уу). Хувь хүмүүс өөрийн нэрийг нууцлах эрхээ эдлэх хүсэлт гаргаж болох бөгөөд энэхүү механизм нь оролцогч талуудын өргөдөл гомдлоо хууль шүүхийн бусад арга хэрэгслээр шийдвэрлүүлэх эрхийг нь хязгаарладаггүй.

Бүх өргөдөл гомдлыг дараах бадлаар зохицуулна. Үүнд:

- Хүлээж авсан гэдгээ ажлын 5 өдөрт багтаан мэдэгдэнэ.
- Өргөдөл гомдлыг хүлээн авснаас хойш 10 хоногоос хэтрүүлэлгүй хариу өгөх. Гомдол барагдуулах шийдвэрлэх арга хэмжээг зөвшилцөн тогтоосон бол түүнээс хойш 7 хоногийн дотор шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Тусгайлан сонгогдож, сургагдаж бэлтгэгдсэн ажилтнууд гомдлын мэдээллийг өргөдөл гомдлын мэдээллийн санд бүртгэнэ. Ингэхдээ дараах мэдээллийг багтаана. Үүнд:

- Оролцогч талын нэр, холбоо барих мэдээлэл.
- Гомдлын талаар, хаана хэзээ ирүүлсэн, хүлээж авсан гэдгийг мэдэгдсэн, хариу өгсөн болон хаасан тухай дэлгэрэнгүй мэдээлэл.

ГБМ-ыг хэрэгжүүлэх журам болон хугацааг Хүснэгт Figure 8-1-т харуулав. Барилгын үе шатанд өргөдөл гомдлыг дараах 4 үе шаттайгаар шийдвэрлэнэ. Үүнд:

1-р үе шат

ГБМ-д хандах. Хэрэв асуудал үүсвэл өргөдөл гомдол гаргагч (ӨГГ) нь Барилгын гэрээт гүйцэтгэгч / үйл ажиллагааны операторт шууд хандан асуудлыг шийдвэрлэж болно[10]. Гэхдээ хэрэв асуудал нь амжилттай шийдэгдээгүй бол ӨГГ нь багийн эсвэл сумын өөрийн таалалд хамгийн нийцсэн түвшний эрх бүхий байгууллагад гомдол мэдүүлнэ . Ямар ч гомдлын тухайд, тэдгээр нь холбоо барьсан цэгт бүртгэгдэж, дараа нь ОНГБН /ТХН-д мэдээлэгдэх ба ингэснээр Төв мэдээллийн санг өнөөдрийг хүртэлх бүх өргөдөл гомдлын мэдээллээр шинэчлэн баяжуулах ба сумын ОНХОХҮА-ууд асуудлын талаар мэдээлэлтэй байна.

2-р үе шат

Сумын ОНГБН (барилга угсралт) эсвэл ЗТХЯ (ашиглалт)-нд албан ёсны гомдол гаргана. Баг/сумын эсвэл ОНХОХҮА-ны төлөөлөгч 3 хоногийн дотор ОНГБН-д хандан амаар буюу бичгээр гомдол мэдүүлнэ. Амаар мэдүүлсэн гомдлыг ОНГБН нь бичиж бүртгэж авна. Гомдлыг орон нутгийн өргөдөл гомдлын мэдээллийн санд бүртгэнэ. Мэдүүлсэн гомдол тус бүрийг хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг ОНГБН үнэлэх ёстой. Хэрэв гомдол нь шаардлага хангахгүй, жишээ нь төслийн цар хүрээнээс гаднах асуудалтай холбоотой бол ОНГБН нь ӨГГ-д ажлын 5 өдөрт багтаан бичгээр тодорхой ойлгомжтой хариу өгнө. Шаарлагатай бол ОНГБН уг хариуны талаар ТХН-тэй, хэрэв хамаарахаар бол Барилгын гэрээт гүйцэтгэгчийн ОХНА-тай ярилцана.

3-р үе шат

ОНГБН-ийн Гомдлын Шийдвэр. ОНГБН-ийн өргөдөл гомдлын удирдлагын томилогдсон хүн асуудлыг мөрдөн судлах, шийдвэрлэх алхмуудыг хийнэ. Үүнд гэрээт гүйцэтгэгчид алдаагаа засаж залруулах арга хэмжээ авах талаар зааварчлах алхам багтаж болно. Гомдлыг барагдуулах шийдлийн талаар санал нэгдэж сонгосноос хойш долоон өдрийн дотор буюу анх гомдлыг мэдүүлсэн өдрөөс хойш 30 хоногт багтаан холбогдох хариуцагч тал (жишээ нь гэрээт гүйцэтгэгч, ТХН, оператор, томилогдсон бусад тал) нь гомдол барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлэх ба энэ тухай гомдлын удирдлагын томилогдсон хүнд уламжилна. ОНГБН хариуны талаар ТХН-тэй, хэрэв хамаарахаар бол Барилгын гэрээт гүйцэтгэгчийн ОХНА-тай ярилцана.

4-р үе шат

Аймгийн шийдэл. Хэрэв ТХН/Гэрээт гүйцэтгэгч (барилга угсралт) эсвэл ЗТХЯ (ашиглалт) асуудлыг шийдвэрлэж чадахгүй, ӨГГ гомдолтой хэвээр байвал ОНГБН нь холбогдох аймагтай уулзалт хийнэ. Хэрэв аймагт шийдэл олсон бол түүнийг хэрэгжүүлнэ.

5-р үе шат

Орон нутгийн шүүхийн үйл явц. Хэрэв ӨГГ нь 4-р үе шатан дахь үр дүнд сэтгэл хангалуун бус байвал орон нутгийн шүүхийн байгууллагад хандан шийдвэрлүүлж болно.

[10] Ийм шийдвэрийг албан ёсоор хүлээн авч / харилцан ярианы тэмдэглэлд бичиж бүртгэх хэрэгтэй ба энэ нь бага түвшний болон албан бус санал хүсэлт / гомдлыг хянах боломжийг бүрдүүлнэ.



Зураг 8-1. ГБМ-ын журам ба хугацаа

9. Хяналт үнэлгээ ба тайлагналт

9.1. Танилцуулга

ТОХТ-нд талуудын үүрэг амлалтыг тодорхой зааснаар тэдгээрийн биелэлтийг хянах үнэлэх, үр дүнг тайлагнах нь маш чухал болдог. Талуудын оролцоог хангах үйл ажиллагаануудын үр дүнг хянах, цаашид засаж сайжруулах боломжит чиглэлүүдийг нь тодорхойлохоор хөтөлбөрийн үр дүнг үнэлэх нь оролцоог хангах үйл явцын чухал тал нь юм. Товчхондоо, хяналт үнэлгээний үйл явц нь дараах нөхцлүүд хангагдсан эсэх тухай мэдээлэл өгдөг. Үүнд:

- Үйл ажиллагаа нь хүссэн үр дүнд хүрч байна;
- Хэрэгжилт нь анхны өргөн хүрээтэй бөгөөд тодорхой зорилтуудтай нийцдэг;
- Хэрэгжилт нь хүлээгдэж буй үр дүнд хүрэхээр урагш ахиж байна; мөн
- Цаг хугацааг эрхэмлэн хүндэтгэж байна.

9.2. Гүйцэтгэлийн голлох шалгуур үзүүлэлтүүд болон хяналт үнэлгээний арга хэмжээнүүд

Төсөл нь түүнд хамаарах талуудын оролцоог хангах байнгын тасралтгүй үнэлгээг хийж гүйцэтгэхэд бэлэн байна. Хүснэгт 9-1-т талуудын оролцоог үнэлэхэд ашиглагдах гүйцэтгэлийн голлох шалгуур үзүүлэлтүүд (ГГШҮ)-ийг харуулав.

Хүснэгт 9-1. Гүйцэтгэлийн голлох шалгуур үзүүлэлтүүд

Дугаар	ГГШҮ	Зорилт	Хяналт үнэлгээ / Арга хэмжээ
ТОХТГГШҮ01	Олон нийтийн өргөдөл /гомдлын тоо	Өмнөх жилээс буурсан нийт тоо	Өргөдөл гомдлын мэдээллийн сан
ТОХТГГШҮ02	1 сарын хугацаанд шийдвэрлэсэн гомдлын тоо	Зорилт 90%	Өргөдөл гомдлын мэдээллийн сан
ТОХТГГШҮ03	Олон нийт, оролцогч талуудаас авсан эерэг сэтгэгдлийн тоо	Өмнөх жилээс өссөн нийт тоо	Олон нийт / санал бодол
ТОХТГГШҮ04	Оролцооны үйл ажиллагаанд оролцсон олон нийтийн төлөөллийн тоо	Төлөвлөсөн оролцооны үйл ажиллагаануудыг 100% хэрэгжүүлэх (ТОХТ-ний дагуу)	Талуудын оролцоог хангах мэдээллийн сан
ТОХТГГШҮ05	Эмзэг бүлгийн айл өрхүүдтэй ажилласан тоо	Төлөвлөсөн оролцооны үйл ажиллагаануудыг 100% хэрэгжүүлэх	Талуудын оролцоог хангах мэдээллийн сан
ТОХТГГШҮ05	Бүрэн бүртгэгдсэн оролцооны үйл ажиллагааны тоо	Оролцооны үйл ажиллагаануудыг 100% бүртгэхийг зорих	Талуудын оролцоог хангах мэдээллийн сан / Үйл ажиллагааны төлөвлөгөө
ТОХТГГШҮ06	Гомдол барагдуулах механизмын хэрэгжилтийн талаар олон нийтэд эргэн мэдээлэх	Гомдол барагдуулах механизмын үр дүнгийн талаарх тогтмол тайланг олон нийтэд хүргэх	Тайлагналт
ТОХТГГШҮ07	ТОХТ болон Гомдол барагдуулах механизмд аудит хийж аль аль нь амжилттай хэрэгжиж, өргөдөл гомдлыг хангалттай шийдвэрлэсэн гэдгийг баталгаажуулах.	Жилд хоёр удаа аудит хийгдсэн	Аудитын тайлан

Энэхүү ТОХТ-нд нийцүүлэн оролцогч талуудын оролцоог хангах чиглэлд авч хэрэгжүүлэх хяналт үнэлгээний арга хэмжээнүүдийг Хүснэгт 9-2-т үзүүлэв.

Хүснэгт 9-2. Хяналт үнэлгээний арга хэмжээ

Дугаар	Сэдэв / Асуудал	Арга	Хариуцсан тал	Хугацаа / Давтамж
ТОХТа	Олон нийтийн өргөдөл гомдол	Өргөдөл гомдлын мэдээллийн санг, түүний дотор тодорхой хугацаа тутамд (хамгийн багадаа сар бүр) хаагдсан болон шийдэгдээгүй тохиолдлуудыг шалгахдаа дараах мэдээллүүдийг харна. Үүнд: ▪ Тухайн сард нээгдсэн бөгөөд хараахан шийдэгдээгүй гомдол, хүсэлтийн тоо; ▪ Тухайн сард нээгдсэн гомдлын тоо; ▪ Хяналт эхэлснээс хойш гарсан хувьсал өөрчлөлт (график дүрслэл); болон ▪ Өргөдөл гомдлын төрөл.	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Сар тутам
ТОХТа	Олон нийтийн өргөдөл гомдол	Олон нийтийн өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар (мөн гомдлын төрөл хэлбэр, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн болон түүнээс гарсан үр дүнгийн талаар) олон нийтэд байнга эргэн мэдээлнэ. Гомдол барагдуулах механизмд жил бүр аудит хийнэ.	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Жил тутам
ТОХТб	Талуудын оролцоог хангах үйл ажиллагаа	Оролцогч талуудын мэдээллийн санд бүртгэлтэй орон нутгийн олон нийтийн албан болон албан бусаар хамтран ажилласан тухай мэдээллийг бүртгэх. Үүнд олон нийттэй холбогдсон бүхий л харилцааг багтаана. Долоо хоногийн тайлан / сарын тайланд хураангуйгаар оруулна.	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Долоо хоног бүр / сар тутам
ТОХТв	Тараасан нийтэд ил болсон материалууд	Боловсруулсан болон тараасан бүх төрлийн танилцуулга/брошур зэргийг байршлаар нь бүртгэж, сар тутмын тайланд нэгтгэгдэх долоо хоногийн тайланд тусгана.	ЗТХЯ / ТХН / Гэрээт гүйцэтгэгчид	Долоо хоног бүр

Дотоод аудит

ТОХТ-г дагаж мөрдөнө гэдэг нь дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж, мөн жил бүр аудит хийлгэнэ гэсэн үг. Хэрхэн дагаж мөрдсөнийг жил тутмын дотоод аудитын хөтөлбөрөөр дамжуулан хянана. Энэхүү дотоод аудит нь Төслийн ТОХТ-ний хэрэгжилтийг бүхэл нь хянадагтай нь холбоотойгоор ТХН-д, мөн дотооддоо шаардлагатай арга хэмжээг хэрхэн мөрдлөг болгож байгаагаа хянах үүрэгтэй Барилгын гэрээт гүйцэтгэгчдэд хамаарна.

Барилгын гэрээт гүйцэтгэгчид нь эхний хариуцсан ажлаа гүйцэтгэхийн өмнө шалгалт, аудит хийлгэх ба дараа нь оролцооны төлөвлөгөөний хэрэгжилт, удирдлага, гэрээт гүйцэтгэгчид шууд хандан мэдүүлсэн гомдлын талаар тайлагнах журмуудыг дагаж мөрдсөн гэдгээ баталгаажуулахын тулд сар бүр шалгуулна.

Мөн ГБМ-ын журмын дагуу бүх гомдлыг бүртгэж, цааш уламжилсан гэдгийг баталгаажуулах, ОНГБН нь тэдгээр гомдлуудын талаар Барилгын гэрээт гүйцэтгэгчид болон ТХН-д мэдэгддэг гэдгийг бататгах үүднээс ТХН нь ОНГБН-д аудит шалгалт хийнэ.

ТОХТ болон ГБМ-д нийцүүлэхийн тулд хөнлөнгийн аудиторууд (жишээ нь ЕСБХБ)-аар тогтмол хугацаанд үнэлгээ хийлгэх шаардлагатай.

9.3. Тайлагналт

Талуудын оролцоог хангах үйл ажиллагаануудаас гарсан бүхий л саналуудыг баримтжуулах болно. Оролцооны үйл ажиллагааны бүртгэлд дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- Уулзалт, хурлын тэмдэглэл;
- Ирцийн бүртгэл (нэрээ нууцлахыг хүссэн хүмүүсийн хүсэлтийг хүндэтгэн хүлээж авах);
- Хүйсийг бүртгэх, хэрэв боломжтой бол оролцогчдын эмзэг өртөмхий байдлыг мөн бүртгэнэ;
- Оролцооны арга хэрэгслүүд; мөн
- Санал хүсэлт, хариу мэдээллийн шинэчилсэн тайлан.

9.3.1. Хуваарь

Хурал уулзалт, зөвлөлдөх арга хэмжээ зэрэг оролцоог хангах чиглэлд төлөвлөсөн арга хэмжээнүүдийг багтаасан хуваарь гаргаж, тэдгээр арга хэмжээний огноо, байршлын мэдээллийг оруулах ажлыг ТХН болон Барилгын гэрээт гүйцэтгэгчид хийнэ. Хуваарь нь барилгын ажил эхлэх өөр, жилийн тайлан зэрэг төслийн гол мэдээллийг нийтэд ил болгох өдрүүдийг агуулна.

9.3.2. Талуудын оролцоо болон өргөдөл гомдлын мэдээллийн сан

Бүх талуудын холбоо барих мэдээлэл, оролцооны үйл ажиллагаа болон талуудтай холбоотой бүх өргөдөл гомдлын мэдээллийг Талуудын оролцоо, өргөдөл гомдлын мэдээллийн санд байршуулах ба ингэснээр тэдгээрийн оролцооны үйл явц болон хүлээн авсан бүх өргөдөл гомлын мөрөөр хянах шалгах боломжтой болно. Төв мэдээллийн сан нь ТХН-ийн эзэмшил хяналтанд байх ба хамгийн багадаа дараах мэдээллүүдийг агуулах ёстой. Үүнд:

- Нэр болон холбоо барих мэдээлэл (хэрэв нэрээ нууцлахыг хүссэн бол бүртгэлийн код буюу дугаар ашиглана);
- Холбоо барьсан огноо;
- Арга аргачлал;
- Хүлээж авсан гомдол;
- Өргөдөл гомдлын шалтгаан (санал, дүгнэлт, гомдол ...);
- Санал болгож буй хариу арга хэмжээ болон алхмууд; мөн
- Төлөв байдал (бүртгэгдсэн, шийдвэрлэх шатандаа буй, хаагдсан).

Мэдүүлсэн бүх өргөдөл гомдлыг Хавсралт Б-д харуулсан маягтын дагуу бүртгэх ёстой.

Бүх уулзалтын арга хэмжээг Хавсралт В-д харуулсан Уулзалтын тэмдэглэл хөтлөх загварыг ашиглан бүрдүүлсэн мэдээлэлд үндэслэн бүртгэнэ.

Төв мэдээллийн санд шинээр нэмэгдсэн оролцогч тал, хөндөгдсөн асуудлууд болон бүртгэгдсэн асуудлуудыг шийдвэрлэх үйл явцын талаарх мэдээллийг оруулж шинэчилнэ. Төв мэдээллийн санг ТХН-ээс томилсон өргөдөл гомдлыг зохицуулан шийдвэрлэх ажилтан хариуцаж ажиллана. Хавсралт Г-д жишээ болох Мэдээллийн сан (бүртгэл)-г үзүүлэв.

Барилгын гэрээт гүйцэтгэгчид өөрсдийн хариуцсан багцын холбогдох мэдээллийн санг бүрдүүлэх ёстой бөгөөд тэр нь Төв мэдээллийн сантай бүрэн нийцсэн байх шаардлагатай.

ОНГБН мөн тухайн сумын холбогдох бүх өргөдөл гомдлыг бүртгэх ба ТХН-нээр дамжуулан төв мэдээллийн санд нэгтгэж мэдээлнэ.

9.3.3. Долоо хоногийн / сарын тайлан

Барилгын гэрээт гүйцэтгэгчид ТХН-д илгээх долоо хоног тутмын болон сар тутмын тайлан бэлтгэх ба тэдгээр тайланд дээр дурдсан хяналт үнэлгээний гол арга хэмжээнүүдийг тусгах ба дараах зүйлс багтана. Үүнд:

- Долоо хоног/сар тутам зохион байгуулагдсан оролцооны үйл ажиллагаанууд;
- Гэрээт гүйцэтгэгчийн шийдвэрлэсэн өргөдөл гомдол; мөн

- Дараа сарын төлөвлөгөө болон илүү урт хугацааны төлөвлөгөө.

ОНГБН сумын түвшинд бий болсон гомдлын мэдээллийн сангийн талаар сар тутам тайлан бэлдэх ба тайлан нь ТХН-д хүргэгдэж, Барилгын гэрээт гүйцэтгэгчид хувийг нь авна.

ТХН энэхүү мэдээллийг хянаж үзээд Төсөлд бүхэлд нь хамаарах талуудын оролцоо, өргөдөл гомдлын талаарх сар тутмын хураангуй тайланг бэлтгэнэ.

9.3.4. Жилийн тайлан

ТХН нь барилгын явцад талуудын оролцоог хангах болон өргөдөл гомдлыг зохицуулан удирдах чиглэлд хийгдсэн ажлын үр дүнг хураангуйлсан тайланг жил бүр боловсруулна. Ашиглалтын үе шатанд энэхүү тайланг ЗТХЯ хариуцан бэлтгэнэ. Тайлан зохион байгуулагдсан бүхий л олон нийтийн зөвлөлдөх уулзалт, оролцоог хангах үйл ажиллагаа, өргөдөл гомдол хүлээн авах болон шийдвэрлэх арга хэмжээ, түүнээс гарсан үр дүнгийн талаарх эмхэтгэсэн мэдээллээр хангана.

10. Эх үүсвэр болон үүрэг хариуцлага

10.1. Барилгын өмнөх ба барилгын үе шат

Төслийн хэрэгжитийн 1 ба 2-р үе шатыг удирдан зохицуулах үүрэгтэй ТХН-ийг ЗТХЯ-нд байгуулсан. ЗТХЯ нь ТХН-ийн тусламжтайгаар санал болгож буй хөрөнгө оруулалт болон Зээлийн хэлэлцээрийн хяналт үнэлгээ, удирдлагыг бүхэлд нь хариуцах болно. ТХН нь гэрээт гүйцэтгэгч нар, ОНГБН-ийн хэрэгжүүлж буй болон бусад бүх талуудын оролцоог хангах үйл ажиллагааг хянаж үнэлэх ба олон янзын гэрээг гүйцэтгэгч нар, сум/аймаг болон ОНХОХҮА-ын зүгээс оролцогч алуудад ирүүлсэн мэдээллийн нийцтэй байдлыг хангана.

Сумын ОНХОХҮА-ыг ТХН тодорхойлох ба ОНХОХҮА нь орон нутгийн түвшинд ГБМ-ын хэрэгжилтийг хангах үүрэг хүлээнэ. Төслийн талаар мэдээлэл авах хүсэлтэй болон тодорхой асуудалтай, тэр талаараа ярилцах хүсэлтэй оршин суугчдын хувьд гол холбоо барих цэг нь ОНХОХҮА байна.

Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч нар талуудын оролцоог хангах, өөрийн хариуцсан Багцад хамаарах өргөдөл гомдлыг барагдуулах үүрэгтэй Олон нийттэй харилцах ажилтныг байгууллагаасаа сонгож томилно. Барилгын өмнөх үе шатанд Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал (БОНЭМАБ)-ын удирдагчийг ТХН-ийн бүтцэд бий болгоно. Энэхүү удирдагч нь талуудын оролцоог хангах болон ТХН-ийн хүрээн дэх өргөдөл гомдол барагдуулах ажлыг удирдахад гүйцэтгэх үүргийг тодорхойлох үүрэгтэй. Нэр дэвшиж сонгогдсон хүн нь Төслийн ТОХТ-г боловсруулах ба барилгын гэрээт гүйцэтгэгч нарын дагаж мөрдөх ёстой Оролцооны Хөтөлбөрийн бүдүүвчийг гаргана. Гүйцэтгэх бусад үүрэгт нь ТХН-д талуудын оролцоог хангах үйл явцыг хянахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх болон аливаа гэрээт гүйцэтгэгчийн оролцогч талын оролцоог хангах үйл ажиллагаанд аудит хийх, сум, аймаг, ОНХОХҮА, гэрээт гүйцэтгэгч нартай төслийн зүгээс тогтоосон харилцаа холбоог удирдах ажил багтана. Уг хүн үр ашиггүй байдал, төөрөгдөл, зөрчилтэй мэдээлэл, зөрчилдсөн үүрэг амлалтууд (Талуудын оролцоо болон өргөдөл гомдлын мэдээллийн сан)-ыг бууруулах төв мэдээллийн санг бүрдүүлнэ.

ОНГБН нь талуудын оролцоог хөрсөн дээр нь бодитоор хангах ажлыг манлайлж, шаардлагатай бол Багцын барилгын гэрээт гүйцэтгэгчид болон ОНХОХҮА-тай хамтран хэрэгжүүлэх болно.

ТХН нь барилгын гэрээт гүйцэтгэгч нар Төслийн ТОХТ-ний талаар мэдэх бөгөөд уг төлөвлөгөөний нэг хувийг авсан гэдгийг баталгаажуулах үүрэгтэй. Мөн гэрээт гүйцэтгэгч нарын боловсруулж бэлтгэх тухайн багцын онцлогт нийцсэн ТОХТ/Үйл ажиллагааны төлөвлөгөөг хянана.

Барилгын үе шатанд барилгын гэрээт гүйцэтгэгч нарыг ЗТХЯ-ны одоогийн бүтцээр дамжуулан сонгож ажиллуулна. Багцын онцлогт нийцсэн оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагаанууд нь гэрээт гүйцэтгэгч нарын хариуцах ажил болж хувирна. Уялдаа холбоог хангахын тулд ТХН нь оролцогч талуудтай хийхээр санал болгож буй зөвлөлдөх уулзалт болон хамтын ажиллагааны талаар урьдчилан мэдсэн байх шаардлагатай. ТХН бүхий л горим журмыг зохицуулж, түгээгдэж буй мэдээллүүд хоорондоо уялдаатай, гэрээт гүйцэтгэгч нарын хэрэгжүүлэх оролцоог хангах журамд шаардлагатай тохиолдолд ТХН-ийн оролцуулахаар тусгасан байхад анхаарна.

Гэрээт гүйцэтгэгч нар Төслийн оролцогч талуудын оролцоог хангах шаардлагыг дагаж мөрдөж байгааг баталгаажуулах үүднээс үйл ажиллагаанд нь тогтмол аудит хийнэ. Мөн ГБМ-ын ажиллагаа, үр дүнг баталгаажуулах зорилгоор гэрээт гүйцэтгэгч нар болон ОНГБН-ийг аудитад хамруулна.

10.2. Ашиглалт ба засвар арчлалтын үе шат

Ашиглалтын явцад ЗТХЯ нь Ашиглалт ба Засвар арчлалт (АЗА)-ын ТОХТ-г боловсруулах болон хэрэгжүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол АЗА-ын гэрээт гүйцэтгэгч нар нь ЗТХЯ-ны удирдлага хяналтын дор оролцоог хангах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

Хавсралт

Хавсралт А. Ярилцлагын асуултууд

Аймаг, сумын засаг даргын ажлын албанаас авах ярилцлагын асуултууд

Ярилцлага өгөгчийн нэр:
Албан тушаал:
Хүйс:
Сум:
Огноо:

1. **Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдал**
   1.1 Энэ нутгийн оршин суугчдад зам, замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ямар бэрхшээлүүд тулгардаг вэ?
   Хариулт дутуу бол тодруулах асуултууд:
   - Энэ нутгийн оршин суугчдын хэрэгцээ шаардлага нь юу вэ?
   - Энэ нутгийн ойролцоох Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам дээр хэр их зам тээврийн осол гардаг вэ?

   1.2 Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ? Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар та ямар санал хэлэх вэ?
   - Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг юу сайжруулах **вэ**?
   - Явган хүний гарц, мал, амьтны гарам, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ, гүүрэн болон газар доогуурх гарц зэргийн талаар хэлэх санал байна уу?

2. **Олон нийтийн эрүүл мэнд & аюулгүй байдал**
   2.1 Таны бодлоор замын барилгын ажил энэ нутгийн оршин суугчдад хэрхэн нөлөөлөх вэ?
   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажил энэ нутгийн оршин суугчдын эмзэг өртөмхий байдал буюу эсвэл аюулгүй байдлыг нэмэгдүүлэх үү?

   2.2 Барилгын ажлын явцад үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар та ямар санал хэлэх вэ?
   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажлын явцад юуг анхаарах шаардлагатай вэ?
   - Дуу чимээ, шороо тоосыг багасгах талаар ямар санал хэлэх вэ?
   - Хог хаягдлын менежментийн талаар санал байна уу?
   - Барилгын ажилчидтай холбоотой ямар нэг санал хэлэх үү?

   2.3 Орон нутгийн иргэд оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд зам төлөвлөлтөнд юуг анхаарахыг зөвлөх вэ?
   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд хэн, ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

Сургууль, эрүүл мэндийн төвийн ажилтнуудаас авах ярилцлагын асуултууд

Ярилцлага өгөгчийн нэр:
Албан тушаал:
Хүйс:
Сум:
Огноо:

1. **Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдал**

1.1 Энэ нутгийн оршин суугчдад зам, замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ямар бэрхшээлүүд тулгардаг вэ?

Хариулт дутуу бол тодруулах асуултууд:

- Энэ нутгийн ойролцоох Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам дээр хэр их зам тээврийн осол гардаг вэ?
- Энэ нутгийн оршин суугчдын хэрэгцээ шаардлага нь юу вэ?
- Энэ нутгийн хүүхдүүдэд ямар бэрхшээл тулгардаг вэ?

1.2 Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ? Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар та ямар санал хэлэх вэ?

- Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг юу сайжруулах **вэ**?
- Явган хүний гарц, мал, амьтны гарам, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ, гүүрэн болон газар доогуурх гарц зэргийн талаар хэлэх санал байна уу?

2. **Олон нийтийн эрүүл мэнд & аюулгүй байдал**

2.1 Таны бодлоор замын барилгын ажил энэ нутгийн оршин суугчдад хэрхэн нөлөөлөх вэ?

Хариулт дутуу бол тодруулах асуулт:

- Замын барилгын ажил энэ нутгийн оршин суугчид (мөн хүүхдүүд)-ын эмзэг өртөмхий байдал буюу эсвэл аюулгүй байдлыг нэмэгдүүлэх үү?

2.2 Барилгын ажлын явцад үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар та ямар санал хэлэх вэ?

Хариулт дутуу бол тодруулах асуулт:

- Замын барилгын ажлын явцад юуг анхаарах шаардлагатай вэ?
- Дуу чимээ, шороо тоосыг багасгах талаар ямар санал хэлэх вэ?
- Хог хаягдлын менежментийн талаар санал байна уу?
- Барилгын ажилчидтай холбоотой ямар нэг санал хэлэх үү?

2.3 Орон нутгийн иргэд оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд зам төлөвлөлтөнд юуг анхаарахыг зөвлөх вэ?

Хариулт дутуу бол тодруулах асуулт:

- Оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд хэн, ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

Цагдаа болон онцгой байдлын албаны ажилтнуудаас авах ярилцлагын асуултууд

Ярилцлага өгөгчийн нэр:
Албан тушаал:
Хүйс:
Сум:
Огноо:

1. **Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдал**
   1.1 Энэ нутгийн оршин суугчдад зам, замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ямар бэрхшээлүүд тулгардаг вэ?
   Хариулт дутуу бол тодруулах асуултууд:
   - Энэ нутгийн ойролцоох Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам дээр хэр их зам тээврийн осол гардаг вэ?
   - Энэ нутгийн оршин суугчдын хэрэгцээ шаардлага нь юу вэ?

   1.2 Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ? Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар та ямар санал хэлэх вэ?
   - Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг юу сайжруулах **вэ**?
   - Явган хүний гарц, мал, амьтны гарам, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ, гүүрэн болон газар доогуурх гарц зэргийн талаар хэлэх санал байна уу?

2. **Олон нийтийн эрүүл мэнд & аюулгүй байдал**
   2.1 Таны бодлоор замын барилгын ажил энэ нутгийн оршин суугчдад хэрхэн нөлөөлөх вэ?
   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажил энэ нутгийн оршин суугчид (мөн хүүхдүүд)-ын эмзэг өртөмхий байдал буюу эсвэл аюулгүй байдлыг нэмэгдүүлэх үү?

   2.2 Барилгын ажлын явцад үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар та ямар санал хэлэх вэ?
   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажлын явцад юуг анхаарах шаардлагатай вэ?
   - Дуу чимээ, шороо тоосыг багасгах талаар ямар санал хэлэх вэ?
   - Хог хаягдлын менежментийн талаар санал байна уу?
   - Барилгын ажилчидтай холбоотой ямар нэг санал хэлэх үү?

   2.3 Орон нутгийн иргэд оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд зам төлөвлөлтөнд юуг анхаарахыг зөвлөх вэ?
   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд хэн, ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

Бизнес эрхлэгчдээс авах ярилцлагын асуултууд

Ярилцлага өгөгчийн нэр:
Бизнесийн төрөл чиглэл:
Хүйс:
Сум:

1. **Танд болон таны бизнест замын барилгын ажил хэрхэн нөлөөлж байна вэ? Таны санааг зовоож буй асуудал юу вэ?**
   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажил эхлэхэд танд ямар бэрхшээлүүд тулгардаг вэ?
   - Замын төсөл таны бизнесийг нүүлгэн шилжүүлэх үү?
   - Нүүлгэн шилжүүлэлт нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд харилцан адилгүй нөлөөлөх үү?
   - Танд нүүлгэн шилжүүлэлтийн талаар албан ёсоор мэдэгдсэн үү? Хэзээ мэдэгдсэн бэ?
   - Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, орлогын түвшин зэрэг нийгмийн үзүүлэлтүүд нь бизнес эрхлэгчдийн хөдөлгөөн, зам ашиглалтын байдалд хэрхэн нөлөөлдөг вэ?

2. **Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ?**
   - Таны (бизнес эрхлэгчдийн) хэрэгцээ шаардлага юу вэ?

3. **Барилгын ажлын явцад үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар та ямар санал хэлэх вэ?**

Хариулт дутуу бол тодруулах асуулт:
- Замын барилгын ажлын явцад юуг анхаарах шаардлагатай вэ?
- Дуу чимээ, шороо тоосыг багасгах талаар ямар санал хэлэх вэ?
- Хог хаягдлын менежментийн талаар санал байна уу?
- Барилгын ажилчидтай холбоотой ямар нэг санал хэлэх үү?

4. Замын төлөвлөлтөнд юу юуг багтаах хэрэгтэй вэ?
   - Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг юу сайжруулах **вэ**?
   - Явган хүний гарц, мал, амьтны гарам, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ, гүүрэн болон газар доогуурх гарц зэргийн талаар хэлэх санал байна уу?
   - Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар та ямар санал хэлэх вэ?

Авто замын төлбөр хураах цэг болон төмөр замын ажилтнуудаас авах ярилцлагын асуултууд

Ярилцлага өгөгчийн нэр:
Албан тушаал:
Хүйс:
Сум:
Огноо:

1. **Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдал**

   1.1 Танд зам болон замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ямар бэрхшээлүүд тулгардаг вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Энэ нутгийн ойролцоох Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам дээр хэр их зам тээврийн осол гардаг вэ?
   - Энэ нутгийн оршин суугчдын хэрэгцээ шаардлага нь юу вэ?

   1.2 Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ? Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар та ямар санал хэлэх вэ?
   - Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг юу сайжруулах **вэ**?
   - Явган хүний гарц, мал, амьтны гарам, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ, гүүрэн болон газар доогуурх гарц зэргийн талаар хэлэх санал байна уу?

2. **Олон нийтийн эрүүл мэнд & аюулгүй байдал**

   2.1 Таны бодлоор замын барилгын ажил энэ нутгийн оршин суугчдад хэрхэн нөлөөлөх вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажил энэ нутгийн оршин суугчид (мөн хүүхдүүд)-ын эмзэг өртөмхий байдал буюу эсвэл аюулгүй байдлыг нэмэгдүүлэх үү?

   2.2 Барилгын ажлын явцад үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар та ямар санал хэлэх вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажлын явцад юуг анхаарах шаардлагатай вэ?
   - Дуу чимээ, шороо тоосыг багасгах талаар ямар санал хэлэх вэ?
   - Хог хаягдлын менежментийн талаар санал байна уу?
   - Барилгын ажилчидтай холбоотой ямар нэг санал хэлэх үү?

   2.3 Орон нутгийн иргэд оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд зам төлөвлөлтөнд юуг анхаарахыг зөвлөх вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд хэн, ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс (ХБХ)-ээс авах ярилцлагын асуултууд

Ярилцлага өгөгчийн нэр:
Нас:
Хүйс:
Хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэр:
Оршин суугаа газар:

1. **Та замын хөдөлгөөнд хэрхэн оролцдог талаараа бидэнд хэлнэ үү?**
   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   а. Та Улаанбаатар-Дархан чиглэлийн замаар зорчдог уу? Хэр тогтмол зорчдог вэ?
   б. Та машин жолооддог уу? Хэр тогтмол жолооддог вэ?
   в. Та нийтийн тээвэр (такси,…)-ээр зорчдог уу? Хэр тогтмол вэ?
   г. Та моторт бус тээврийн хэрэгсэл (МБТХ), дугуйтай тэргэнцэр, унадаг дугуй эсвэл моторт дугуй, ердийн хөсөг ашигладаг уу, явган алхдаг уу? МБТХ-ийг хэр тогтмол ашигладаг вэ?
   д. ХБХ-ийн дунд хамгийн түгээмэл хэрэглэгддэг тээврийн хэрэгсэл юу вэ?

2. **Та замын хөдөлгөөнд оролцохдоо ямар бэрхшээлүүдтэй тулгардаг вэ?**
   а. Та ганцаараа зорчдог уу эсвэл ихэнхдээ хэн нэгэн хүн тантай хамт явдаг уу?
   б. ХБХ-ийн хэрэгцээ шаардлага нь юу вэ?
   в. ХБХ замын төсөлд хэр зэрэг хүчтэй дуу хоолойтой, нөлөөтэй вэ?
   г. Санал болгож буй төсөл тэдэнд ямар хэмжээгээр нөлөөлөх вэ?

3. **Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ? Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар та ямар санал хэлэх вэ?**
   а. Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг юу сайжруулах **вэ**?
   б. Явган хүний гарц, мал, амьтны гарам, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ, гүүрэн болон газар доогуурх гарц зэргийн талаар хэлэх санал байна уу?
   в. Замын төлөвлөлтөнд юу юуг багтаах хэрэгтэй вэ?

Ахмад настнуудын фокус бүлгийн ярилцлагын асуултууд

1. **Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдал**

   1.1 Та замын хөдөлгөөнд хэрхэн оролцдог талаараа бидэнд хэлнэ үү?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Та Улаанбаатар-Дархан чиглэлийн замаар зорчдог уу? Хэр тогтмол зорчдог вэ?
   - Та машин жолооддог уу? Хэр тогтмол жолооддог вэ?
   - Та нийтийн тээвэр (такси,…)-ээр зорчдог уу? Хэр тогтмол вэ?
   - Та моторт бус тээврийн хэрэгсэл (МБТХ), унадаг дугуй эсвэл моторт дугуй, ердийн хөсөг ашигладаг уу, явган алхдаг уу? МБТХ-ийг хэр тогтмол ашигладаг вэ?
   - Ахмад настнуудын дунд хамгийн түгээмэл хэрэглэгддэг тээврийн хэрэгсэл юу вэ?

   1.2 Та замын хөдөлгөөнд оролцохдоо ямар бэрхшээлүүдтэй тулгардаг вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Та ганцаараа зорчдог уу эсвэл ихэнхдээ хэн нэгэн хүн тантай хамт явдаг уу?
   - Ахмад настнуудын хэрэгцээ шаардлага нь юу вэ?
   - Замын төсөлд ахмад настнууд хэр зэрэг хүчтэй дуу хоолойтой, нөлөөтэй вэ?
   - Санал болгож буй төсөл тэдэнд ямар хэмжээгээр нөлөөлөх вэ?

   1.3 Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ? Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар та ямар санал хэлэх вэ?
   - Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг юу сайжруулах **вэ**?
   - Явган хүний гарц, мал, амьтны гарам, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ, гүүрэн болон газар доогуурх гарц зэргийн талаар хэлэх санал байна уу?

2. **Олон нийтийн эрүүл мэнд & аюулгүй байдал**

   2.1 Таны бодлоор замын барилгын ажил танд болон таны гэр бүлд хэрхэн нөлөөлөх вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажил ахмад настнуудын эмзэг өртөмхий байдал буюу эсвэл аюулгүй байдлыг нэмэгдүүлэх үү?

   2.2 Барилгын ажлын явцад үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар та ямар санал хэлэх вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажлын явцад юуг анхаарах шаардлагатай вэ?
   - Дуу чимээ, шороо тоосыг багасгах талаар ямар санал хэлэх вэ?
   - Хог хаягдлын менежментийн талаар санал байна уу?
   - Барилгын ажилчидтай холбоотой ямар нэг санал хэлэх үү?

   2.3 Орон нутгийн иргэд оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд зам төлөвлөлтөнд юуг анхаарахыг зөвлөх вэ?

3. **Нийгмийн эрсдэл**

   3.1 Замын төсөл ахмад настнуудыг нүүлгэн шилжүүлэх үү?

   3.2 Нүүлгэн шилжүүлэлт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд харилцан адилгүй нөлөөлөх үү?

   3.3 Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, орлогын түвшин зэрэг нийгмийн үзүүлэлтүүд нь хөдөлгөөн, зам ашиглалтын байдалд хэрхэн нөлөөлдөг вэ?

Эмэгтэйчүүдийн фокус бүлгийн ярилцлагын асуултууд

1. **Зам, замын хөөлгөөний аюулгүй байдал**

   1.1 Та замын хөдөлгөөнд хэрхэн оролцдог талаараа бидэнд хэлнэ үү?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Та энэ замаар зорчдог уу? Хэр тогтмол зорчдог вэ?
   - Та машин жолооддог уу? Хэр тогтмол жолооддог вэ?
   - Та нийтийн тээвэр (такси,…)-ээр зорчдог уу? Хэр тогтмол вэ?
   - Та моторт бус тээврийн хэрэгсэл (МБТХ), унадаг дугуй эсвэл моторт дугуй, ердийн хөсөг ашигладаг уу, явган алхдаг уу? МБТХ-ийг хэр тогтмол ашигладаг вэ?
   - Энэ нутгийн эмэгтэйчүүд ихэвчлэн ямар тээврийн хэрэгсэл ашигладаг вэ?

   1.2 Та замын хөдөлгөөнд оролцохдоо ямар бэрхшээлүүдтэй тулгардаг вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага нь юу вэ?
   - Замын төслийн тухайд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага ялгаатай юу?

   1.3 Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ? Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар та ямар санал хэлэх вэ?
   - Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг юу сайжруулах **вэ**?
   - Явган хүний гарц, мал, амьтны гарам, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ, гүүрэн болон газар доогуурх гарц зэргийн талаар хэлэх санал байна уу?

2. **Олон нийтийн эрүүл мэнд & аюулгүй байдал**

   2.1 Таны бодлоор замын барилгын ажил танд болон таны гэр бүлд хэрхэн нөлөөлөх вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажил эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эмзэг өртөмхий байдал буюу эсвэл аюулгүй байдлыг нэмэгдүүлэх үү?

   2.2 Барилгын ажлын явцад үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар та ямар санал хэлэх вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Замын барилгын ажлын явцад юуг анхаарах шаардлагатай вэ?
   - Дуу чимээ, шороо тоосыг багасгах талаар ямар санал хэлэх вэ?
   - Хог хаягдлын менежментийн талаар санал байна уу?
   - Барилгын ажилчидтай холбоотой ямар нэг санал хэлэх үү?

   2.3 Орон нутгийн иргэд оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд зам төлөвлөлтөнд юуг анхаарахыг зөвлөх вэ?

   Хариулт дутуу бол тодруулах асуулт:
   - Оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд хэн, ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

3. **Нийгмийн эрсдэл**

   3.1 Замын төсөл эмэгтэйчүүдийг нүүлгэн шилжүүлэх үү?

   3.2 Нүүлгэн шилжүүлэлт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд харилцан адилгүй нөлөөлөх үү?

   3.3 Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, орлогын түвшин (магадгүй үндэс угсаа, шашин гэх мэт бусад асуудлууд ч мөн орох) зэрэг нийгмийн үзүүлэлтүүд нь хөдөлгөөн, зам ашиглалтын байдалд хэрхэн нөлөөлдөг вэ?

Малчдаас авах ярилцлагын асуултууд

Ярилцлага өгөгчийн нэр:
Хүйс:
Сум:
Танай гэр бүл энэ нутагт хэр удаан суурьшин амьдарсан бэ:
Малын нэр төрөл:
Малын тоо толгой (ойролцоогоор):

1. **Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдал**

1.1 Энэ нутгийн малчдын дунд хамгийн түгээмэл ашигладаг тээврийн хэрэгсэл юу вэ?

Хариулт дутуу бол тодруулах асуулт:

- Та машин жолооддог уу? Хэр тогтмол жолооддог вэ?
- Та моторт бус тээврийн хэрэгсэл (МБТХ), унадаг дугуй эсвэл моторт дугуй, ердийн хөсөг ашигладаг уу, явган алхдаг уу? МБТХ-ийг хэр тогтмол ашигладаг вэ?

1.2 Авто замтай ойрхон амьдарснаар танд болон танай мал сүрэгт ямар бэрхшээл тулгардаг вэ?

Хариулт дутуу бол тодруулах асуулт:

- Малчдын хэрэгцээ шаардлага нь юу вэ?
- Танай мал усны цэг буюу бэлчээрт хүрэхийн тулд зам хөндлөн гарах хэрэгтэй юу?
- Танай малд зам гарахад ямар нэг хүндрэл бэрхшээл байдаг уу?
- Одоо байгаа зам хөндлөн огтлох гарц, гарамын тоо, хэрэглээний талаар та ямар сэтгэгдэлтэй байна вэ?

1.3 Эдгээр бэрхшээлүүдийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ? Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах талаар та ямар санал хэлэх вэ?

- Зам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг юу сайжруулах **вэ**?
- Явган хүний гарц, мал, амьтны гарам, гэрлэн дохио, хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ, гүүрэн болон газар доогуурх гарц зэргийн талаар хэлэх санал байна уу?
- Замын төсөлд малчид хэр зэрэг хүчтэй дуу хоолойтой, нөлөөтэй вэ?
- Санал болгож буй төсөл малчдад ямар хэмжээгээр нөлөөлөх вэ?

2. **Олон нийтийн эрүүл мэнд & аюулгүй байдал**

2.1 Таны бодлоор замын барилгын ажил таны гэр бүл болон мал сүрэгт хэрхэн нөлөөлөх вэ?

Хариулт дутуу бол тодруулах асуулт:

- Замын барилга угсралт малчдын эмзэг байдал, эсвэл аюулгүй байдлыг нэмэгдүүлэх үү?
- Барилгын ажил бэлчээрийн газарт нөлөөлөх үү?
- Барилгын ажил танай худаг буюу ундны усны эх үүсвэрт нөлөөлөх үү?

2.2 Барилгын ажлын явцын сөрөг нөлөөллийг багасгах талаар таны санал юу вэ?

Хариулт дутуу бол тодруулах асуулт:

- Замын барилгын ажлын явцад юуг анхаарах шаардлагатай вэ?
- Газрын доройтлыг хэрхэн бууруулах талаар санал байна уу?
- Дуу чимээ, шороо тоосыг багасгах талаар ямар санал хэлэх вэ?
- Хог хаягдлын менежментийн талаар санал байна уу?
- Барилгын ажилчидтай холбоотой ямар нэг санал хэлэх үү?

2.3 Орон нутгийн иргэд оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд зам төлөвлөлтөнд юуг анхаарахыг зөвлөх вэ?

Хариулт дутуу бол тодруулах асуулт:

- Оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулахын тулд хэн, ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?

3. **Нийгмийн эрсдэл**

3.1 Замын төсөл малчдыг нүүлгэн шилжүүлэх үү?

3.2 Нүүлгэн шилжүүлэлт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд харилцан адилгүй нөлөөлөх үү?

3.3 Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, орлогын түвшин зэрэг нийгмийн үзүүлэлтүүд нь хөдөлгөөн, зам ашиглалтын байдалд хэрхэн нөлөөлдөг вэ?

Хавсралт Б. Төслийн өргөдөл гомдол гаргах маягт

Бүртгэлийн дугаар (Протоколын дугаар)	
Нэр/Овог *Жич: Хэрэв та хүсвэл өөрийн нэрээ нууцлах, эсвэл таны зөвшөөрөлгүйгээр хувийн мэдээллийг тань гуравдагч этгээдэд залруулахгүй байх хүсэлт тавьж болно.*	
Өргөдөл гомдол гаргасан огноо:	
Холбоо барих мэдээлэл Тантай хэрхэн холбоо барьвал тохиромжтойг тэмдэглэнэ үү	○ шуудангаар ○ утсаар ○ и-мэйлээр
Тантай ямар хэлээр харилцвал зохихыг илтгэнэ үү	
Тохиолдол буюу гомдлын тодорхойлолт: Юу болсон бэ? Энэ явдал хаана болсон бэ? Энэ явдал хэнд тохиолдсон бэ? Тохиолдол буюу асуудал ямар үр дүнд хүрсэн бэ?	
Тохиолдол буюу гомдол үүссэн огноо:	
	○ Нэг удаа ○ Нэгээс олон удаа ○ Үргэлжилсээр буй
Асуудлыг шийдэхийн тулд юу хийхийг хараахыг хүсэж байна вэ?	

Хавсралт В. Уулзалтын тэмдэглэл хөтлөх загвар

Уулзалтын тэмдэглэл	
Зөвлөлдөх уулзалтын огноо	
Зөвлөлдөх уулзалтын төрөл	○ Ганцаарчилсан уулзалт ○ Хэлэлцүүлгийн бүлгүүд ○ Олон нийтийн уулзалт ○ Хэвлэлийн бага хурал ○ Бусад
Байршлын хаяг	
Хот/тосгоны хаяг	
Оролцогч талын холбоо барих хүн	
Оролцогч тал болох хувь хүн буюу бүлгүүд	
Төлөөлөгчид	
Бусад оролцогчид	
Нууц эсэх	○ Тийм ○ Үгүй
Хэлэлцүүлгийн бүс	
Асуудал	
Өргөдөл гомдол, таагүй явдал буюу санал хүсэлт	
Хавсралт	

Хавсралт Г. Өргөдөл гомдлын мэдээллийн сангийн бүртгэлийн загвар

Нэр/Холбоо барих хүний мэдээлэл	Гомдол мэдүүлэх арга (ТХН/ОНГБН-д шууд мэдүүлэх, Гэрээт гүйцэтгэгчээр дамжуулах, Баг буюу Сумаар дамжуулах)	Бүртгэлийн дугаар	ТХН-ийн хариуцсан ажилтан (нэр, гүйцэтгэх үүрэг)	Хүлээн авсан огноо	Гомдол мэдүүлсэн огноо	Өргөдөл гомдлын дэлгэрэнгүй мэдээлэл (асуудал, одоогоор авсан арга хэмжээ, хэзээ эхэлсэн – хэрэгтэй бүх нарийвчилсан мэдээлэл)	Арга хэмжээ (Асуудлыг шийдэх буюу эсвэл өргөдөл гомдлыг дараагийн түвшинд тавихын тулд ТХН-ийн зүгээс авах дараагийн арга хэмжээ)	Арга хэмжээний үүрэг хариуцлага	Шийдвэрлэхийг хүссэн огноо	Шийдвэрлэсэн огноо	Гомдлын мөрөөр авах шаардлагатай арга хэмжээ болон огноо

<АЖ АХУЙН НЭГЖ>

Холбоо барих мэдээлэл